



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 05-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр, Баасан гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2-6
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	7-93
<i>1.Хөрөнгө оруулалтын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	7-20
<i>2.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	20-49
<i>3.Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “PISA-2022” үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн талаар</i>	49-79
<i>4.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2024.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/</i>	79-93

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
04 дүгээр сарын 05-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 72 гишүүнээс 37 гишүүн хүрэлцэн ирж, 51.4 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 24 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Ш.Адьяашаа, А.Адъяасүрэн, Б.Баярсайхан, С.Бямбацогт, Ц.Даваасүрэн, Б.Дэлгэрсайхан, Б.Пүрэвдорж, Б.Чойжилсүрэн, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Ц.Анандбазар, П.Анужин, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Батболд, Д.Батлут, Э.Батиугар, Т.Доржханд, Н.Наранбаатар, Ш.Раднаасэд, Ц.Сэргэлэн;

Тасалсан: С.Амарсайхан, С.Ганбаатар, Х.Ганхуяг, Б.Жавхлан, Ц.Идэрбат, Ч.Хүрэлбаатар, Б.Энх-Амгалан, Б.Энхбаяр;

Хоцорсон: Ж.Батсуурь-1 цаг 02 минут, Х.Болорчулуун-38 минут, Х.Булгантуяа-31 минут, Л.Мөнхбаатар-07 минут, Н.Учрал-1 цаг 01 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ албан бичиг ирүүлснийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ үг хэлэв.

Нэг.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 7 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ё.Энхсайхан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Эдийн засгийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Эдийн засгийн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрам нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ц.Туваан, Д.Ганбат, Б.Бат-Эрдэнэ, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен, Б.Бат-Эрдэнэ нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 19
Татгалзсан: 19
Бүгд: 38
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Г.Занданшатар: Горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 26
Татгалзсан: 14
Бүгд: 40
65.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 11 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүн 2024.03.25-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан, Шинжлэх ухааны академийн Газарзүй, геоэкологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч М.Алтанбагана, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх Б.Мяхадаг, Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх П.Хулан, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал нар байлцав.

Улсын Их Хурлын дэд дарга Л.Мөнхбаатар 13 цаг 03 минутаас 13 цаг 28 минутад хуралдааныг даргалав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Д.Өнөрболор, Н.Ганибал, Ж.Батсуурь, Б.Батгөмөр, Д.Сарангэрэл нарын тавьсан асуултад Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга, хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх Д.Лүндээжанцан нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн, Б.Бейсен нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	22
Татгалзсан:	15
Бүгд:	37

59.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгойн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хоршооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиудын болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 13 цаг 30 минутад хэлэлцэж дуусав.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 08 минут үргэлжилж, 13 цаг 32 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 08 минутад эхлэв.

Гурав.Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл /Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “PISA-2022” үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаар/

Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, мөн яамны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Боловсролын үнэлгээний төвийн дарга Л.Ганбат, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч Х.Отгонбаатар нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга С.Ганболд, мөн газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, мөн хэлтсийн референт Б.Хангай нар байлцав.

Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “PISA-2022” үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаар мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, С.Одонтуяа, О.Цогтгэрэл, Б.Бейсен, Д.Ганбат нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.11-т заасны дагуу Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын “PISA-2022” үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаар мэдээлэл хийв.

Уг асуудлыг 15 цаг 55 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа нарын 19 гишүүн 2023.12.08-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын Нарийн бичгийн дарга Г.Төгөлдөр оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Г.Анар-Эрдэнэ, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаарх илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Н.Алтанхуяг, Н.Ганибал нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн С.Одонтуяа хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.12-т заасны дагуу санал хураалтыг хойшлуулав.

Уг асуудлыг 16 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Баталсан хууль, тогтоолын эцсийн найруулгыг сонсох

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат байлцав.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын эцсийн найруулгыг танилцуулав. Улсын Их Хурлын гишүүдээс эцсийн найруулгатай холбогдуулан асуулт, санал гараагүй болно. Улсын Их Хурлын гишүүд тогтоолын эцсийн найруулгатай танилцлаа. /16:34/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцоож, С.Энхзаяа, ахлах мэргэжилтэн С.Золжаргал нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 34 минут үргэлжилж, 72 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 61.1 хувийн ирцтэйгээр 16 цаг 34 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Д.ЭНХБАТ

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

2024 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр,
Баасан гараг Төрийн ордон “Их
хуралдай” танхим 10 цаг 38 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын ирц бүрдсэн тул Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы 4 дүгээр сарын 5-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 4 асуудал хэлэлцэнэ. 1-д, Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл улсын, 2 дугаарт Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал нарын 38 гишүүн өргөн мэдүүлсэн, 3-д Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын 19 гишүүн өргөн мэдүүлсэн. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээлэл Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA 2022 үнэлгээний Монгол Улсын үр дүн, бодлогын зөвлөмжийн талаар мэдээлэл сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу өмнөх өдрийн 17 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлсэн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүний үг хэлэх хүсэлтийг уншиж танилцуулъя. Улсын Их Хурлын дарга Занданшатар танаа миний бие 4 дүгээр сарын 5-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны

хэлэлцэх асуудлын дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоно уу. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гэсэн байна. Улсын Их Хурлын гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа та бүхнийхээ өглөөний амгаланг айлтгая. Би нэг тодорхой асуудал ярихгүй болохгүй байна. Энэ 2 жил дараалан өвөл хүндэрсэн. Энэ жилийн хувьд бүүр байгалийн гамшигт үзэгдэлд нэрвэгдчихлээ. Нийт улс орон даяар бараг 80 хувь нь зудтай, тэр дундаа энэ зүүн 3 аймаг үнэхээр хүнд байна. Засгийн газар өндөржүүлсэн бэлэн байдал зарласан. Энэ хүрээнд шуурхай бүлэг томилсон. Ингээд бид ажилласан. Сая Улсын Их Хурлын 7 дугаар тогтоолын дагуу Монгол Улсын ЗГ 2024 оныг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болгон зарласантай холбоотой энэ бүсчилсэн хөгжлийн талаарх танилцуулга хэлэлцүүлгийг зохион байгуулж, ингэж 3 аймгийн 20 гаруй сумдаар явлаа, 3000 гаруй иргэдтэй уулзлаа. Бидний хийж байгаа энэ уулзалт дээр хөдөөгийн малчид төлөөллөө ирүүлж их өргөнөөр оролцсон.

Үнэхээр нөхцөл байдал амаргүй байна. 4 сарын 1-ний байдлаар улсын хэмжээнд 6 сая мал хорогдчихсон байгаа ийм дүн мэдээ байгаа. Бидний явсан сумдууд ялангуяа энэ төмөр гэж нэрлээд байгаа тэр мөсөн зудтай байгаа газруудад сумд малынхаа 50-иас илүү хувийг нь алдчихсан сумдууд олон байна. Энэ бол цаашдаа нэмэгдэхээр байна, та бид нар бүгдээрээ мэдэж байгаа. Хавар яагаа ч үгүй байна. Ер нь мал ногоо үнэрлээд л мууддаг шүү дээ. Монгол Улсын Засгийн газар, Их Хурлаас энэ өвлийн бэлтгэл ажлыг хангахтай холбоотой, өвөл хүнд болохтой холбоотой шат дараалсан арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлсэн хэдий боловчиг энэ үнэхээр давагдашгүй ийм нөхцөл байдал үүсчихлээ.

Тэгэхээр одоо бол ерөөсөө л өнөөдөр энэ малчин түмний өмнө тулгамдаад байгаа энэ ажил асуудлыг яаж шийдэх юм бэ? Бид нарын яриад байгаа тэр малчдын зээлийн асуудлыг яаж юм бэ? Тэр малаа алдсан иргэдийг малжуулахтай холбоотой, цаашилбал энэ орлого, ажлын байрыг яаж энэ цогцоор нь ажил асуудлыг шийдэх юм бэ? Энэ дээр бол ерөөсөө бид нар цаг алдах ямар ч нөхцөл байдал байхгүй байна. Маргаашийн тухай асуудал биш, өнөөдрийн тухай асуудлыг дорвитой шийдэх ийм шаардлага байна. Харин заяатай нь бол энэ сүүлийн 2 бүрэн эрхийн хугацааны Улсын Их Хурал, ЗГ энэ баялгийн реформтой холбоотой энэ шинэчлэлийг дорвитой хийж байгаатай холбоотойгоор Монгол Улсын төсөв давж биелсэн. Зөвхөн Таван толгой нөгөө алдагдсан Эрдэнэтээс гэхэд л 6 их наядаар хөрөнгө төвлөрч байгаа асуудлыг өчигдөр Ерөнхий сайд танилцуулгадаа хэллээ шүү дээ. Тэгээд ийм бололцоо байгаа.

Үнэхээр энэ Улсын Их Хуралд 5 бүрэн эрхийн хугацаанд сууж байхад энэ өмнө нь бол ерөөсөө нөхдүүд энэ баялгийн реформтой холбоотой, энэ шударга ёс, ашиг сонирхол авлигаас ангид байхтай холбоотой ийм асуудал дээр ерөөсөө ер нь л ган хийхгүй шүү дээ үе үеийн парламент. Би худлаа юм яриагүй бодитой. Энэ Их Хуралд сууж байгаа улсууд нэг хэсэг нь ерөөсөө ямар хандлагатай байдаг вэ гэхээр зэрэг дарга юу гэж хэлнэ, мань дагана гэсэн ийм байдалтай л гөлийгөөд сууж байдаг. Нэг хэсэг нөхдүүд бол яадаг вэ гэхээр зэрэг ашиг сонирхлын асуудалтай холбоотой өөрийнхөө нэг жижигхэн ашиг сонирхлын асуудлыг гүйцэлдүүлсэн бол тэгээд л амандаа ус балгасан юм шиг л ингээд таг сууж байдаг. Энэ Оюу толгой, энэ Тавантолгойг 100 жилээр Хятадын компанид өгөх, энэ Оюу толгойг үндэстэн дамнасан компанид өгөөд улс орноо 2,3 тэрбум долларт оруулчихаад л ингээд

сууж байгаа шүү дээ. Тэгээд ийм байсан. Харин энэ дарга нар энэ 2 бүрэн эрхийн хугацаанд ажилласан Ерөнхий сайдууд энэ байгалийн баялгийн реформтой холбоотой асуудлыг тавьсан учраас харин нөгөө дуугүй байдаг улсууд чинь бүгдээрээ энд тэндгүй салхины аяс дагаад яриад байдаг болсон байна. Үгүй ээ сайн.

Одоо энэ асуудлаа бол цэгцлээд тэр Баялгийн сангийн хууль энэ баялгийн реформтой холбоотой энэ хулгай худлаар алдсан юмнуудаа татаж авах хэрэгтэй шүү дээ. Стратегийн орд газрууддаа авах хэрэгтэй. Тэгээд ийм учраас бол ерөөсөө миний товчхон тавиад байгаа энэ асуудлыг шийдэж өгөөч. Үнэхээр амьдрал бол хүнд байна. Энэ Монгол Улсын чинь 300 мянган өрхийн, тэд нарын цаад талд байгаа нийт хүн амын чинь 50-иас илүү хувь нь амьдрал байдал ийм хүнд нөхцөлд орчихсон, байгалийн гамшигт нэрвэгдчихсэн ийм байж байхад бид нар ерөөсөө цаг хугацаатай уралдаж энэ асуудлыг яаралтай шийдэх хэрэгтэй байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Санаачлаад ажиллах хэрэгтэй, тэгээд тийм тодорхой асуудлуудаа, ам ажил 2 нэг байх хэрэгтэй. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно.

Нэг.Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын 7 гишүүн 2024.04.02-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ. Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг танилцуулна.

Ц.Цэрэнпунцаг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын нэр бүхий гишүүд 2024 оны 4 сарын 3-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. Хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлага, төслийн зохицуулах харилцааны талаар товч танилцуулъя. Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 10.2.1.1 дэх заалтад газрыг 60 хүртэлх жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 жилээр сунгах татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийг хөрөнгө оруулагчид үзүүлж болохоор заасан байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан төрөөс гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүнд газрыг төлбөр хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол журмаар ашиглуулж болно гэсэн зохицуулалт буюу зөвхөн ашиглуулж болно гэсэн зохицуулалттай зөрчилдөж байна.

Газрын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2-т гадаад улс, олон улсын байгууллага, гадаадын хуулийн этгээдэд газрыг тодорхой хугацаагаар түрээс, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр ашиглуулах талаар шийдвэр гаргах асуудал нь Улсын Их Хурлын бүрэн эрхийн асуудал гэж заасан бөгөөд мөн хуулийн 18.1.6-д уг газрын зааг, ашиглах журмыг ЗГ тогтооно гэж заасан. Түүнчлэн Газрын тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5-д гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд энэ хугацааг ЗГ тогтооно гэж заасан нь мөн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн дээрх саналтай зөрчилдөж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн төслийн 16 дугаар зүйлийн 16.1.1-д

хөрөнгө оруулагчид газрыг 15-аас 60 жил хүртэл жилээр гэрээний үндсэн дээр ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 жил, 40 хүртэл жилээр сунгах хөрөнгө оруулалтын татварын бус урамшууллыг үзүүлж болохоор тусгажээ. Хуулийн төслийн уг заалттай холбогдуулан иргэд, олон нийтийн зүгээс Улсын Их Хурлын албан ёсны цахим системээр дамжуулан саналаа илэрхийлсэн бөгөөд уг цахим системд 2024 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр иргэн Н.Номун-Эрдэнийн газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах, эзэмшихийг цуцлах сэдэвтэй хуулийн төсөл санаачлах талаар санал гаргах ангиллаар нийтлүүлсэн хүсэлт 100167 иргэний дэмжлэгийг авсан байна.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2.3-д хуулийн төслийн талаарх саналыг 100 мянга ба түүнээс дээш тооны иргэн дэмжсэн Улсын Их Хурал уг саналыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу хэлэлцэхээр заасан байдаг. Иймээс хууль хоорондын зөрчлийг арилгах, иргэд, олон нийтийн сонгож байгуулсан төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах зорилгоор хуулийн төсөл, төслийг боловсруулсан болно. Хөрөнгө оруулагчид үзүүлэх татварын бус хөрөнгө оруулалтын дэмжлэгийн нэг хэлбэр болох газрыг 60 хүртэл жилээр гэрээний үндсэн дээр эзэмшүүлэх ашиглуулах, уг хугацааг гэрээний анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгах зохицуулалтыг тусгасан заалтыг Хөрөнгө оруулалтын тухай хуулиас хасах өөрчлөлтийг хуулийн төсөлд тусгалаа.

Хуулийн төслийг хэлэлцэн баталснаар Монгол Улсын Үндсэн хууль болон газрыг иргэн, ААНБ-д эзэмшүүлэх ашиглуулахтай холбогдсон суурь харилцааг зохицуулдаг Газрын тухай хуульд Хөрөнгө оруулалтын тухай хуулийг нийцүүлж хууль хоорондын зөрчил арилах болно. Төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгнө

үү. Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.

Г.Занданишатар: Төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Чинбатын Ундрам танилцуулна.

Ч.Ундрам: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Ц.Цэрэнпунцаг нарын гишүүдээс 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Эдийн засгийн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагчийн зүгээс Улсын Их Хурлын цахим өргөдлийн системд нэр бүхий иргэний гаргасан газрыг гадаадын иргэн 100 жилээр ашиглах эзэмшихийг цуцлах сэдэвтэй нийтийн өргөдлийг судлаад, 2013 онд батлагдсан Хөрөнгө оруулалтын тухай хуульд хөрөнгө оруулагч гадаад улсын иргэн, хуулийн этгээдэд газрыг нийт 100 хүртэл жилийн хугацаагаар эзэмшүүлэх нөхцөл бүрдсэн нь Монгол Улсын Үндсэн хууль, Газрын тухай хуулийн холбогдох зүйл, заалттай зөрчилдөж байгаа тул хууль хоорондын зөрчлийг арилгах, төрийн эрх барих дээд байгууллагын үйл хэрэгт иргэдийн оролцоог хангах зорилгоор уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төслийг *D.parliament.mn* цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байна. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг энэ хуулийн төсөл Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагдсан тохиолдолд гадаадын хөрөнгө оруулагч иргэн, хуулийн этгээдэд газар ашиглуулах асуудлыг ямар хууль тогтоомжоор зохицуулах, Засгийн

газраас 2023 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хөрөнгө оруулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан Гадаадын хөрөнгө оруулагчдад газар ашиглуулах асуудал энэ хуулийн төсөлтэй хэрхэн нийцэх талаар асуулт асууж, хариулт авлаа. Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Норовын Алтанхуяг гишүүн асуулт асууна.

Н.Алтанхуяг: Энэ тэгээд нөгөө Хүрэлбаатарын тэр өргөн барьсан хуулийн төсөл нь яаж байгаа юм бэ? Би ерөөсөө ойлгосонгүй. Тэрэнд нэг хариулт авъя. Тэр хуулийн төслийг хэлэлцэх гэж байгаа юм уу, хэлэлцэхгүй гэж байгаа юм уу. Хэлэлцэхгүй гэж байгаа бол нэг янзын үг хэлмээр байна, хэлэлцэнэ гэж байвал тэрэн дотор чинь дахиад 60, 40-өөсөө гадна гадаадын төрийн өмчийн байгууллагын компаниудын тухай асуудал явж байгаа шүү дээ.

Тэгээд би нэг залруулга бас хийнэ. Энэ Хүрэлбаатар байхгүй байна. Би Хүрэлбаатарыг шүүхэд өгье гэсэн юм. Энэ хаваржингаа энэ Хөрөнгө

оруулалтын хуулиар нэг баахан сенсац дээдээж, шоу хийлээ шүү дээ. Энэ Хүрэлбаатар, би Засгийн газрын алдаа гэж харахгүй байгаа. Би Хүрэлбаатар гэдэг хүн ямар алдаатай хууль оруулж ирсэн гэхээр Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль гэдэг чинь гадаадаас хөрөнгө оруулахыг хэлдэг байхгүй юу. Хөрөнгөө оруулчихсан хүнд нь газрыг яах вэ гэдэг энэ 2 дугаар асуудал байсан юм. Гэтэл энэ хавраас энэ орж ирээд энд баахан бужигнуулсан хууль дээр бол 100 мянган долларыг нь хаячихсан. Ингэхээр гадаадаас хөрөнгө оруулахгүй, тэгэхдээ газрыг зуу, 60 юм уу, 40 жилээр эзэмшүүлэх хууль, эзэмшүүлэх ч юм уу, ашиглуулах хууль болчихсон юм байна лээ. Тэгэхээр ийм алдаатай хуулиа яаж байгаа юм бэ? Би тэрнийг ойлгохгүй байна.

2 дугаарт нь одоо сонсохоор 1900 биш ээ 2013 оны хуулиас 60 нэмэх нь 40-ийг аваад хаячихъя гээд тэгж байна. Болох байх л даа тэгэхээр. 93 оныхоо хуулиас бас авдаггүй юм уу? 60, 40 чинь 93 дээр байсан байхгүй юу. Тэгээд яагаад ингээд 20, 30 жилээр ийм юм явж байснаа гэнэтхэн ингэдэг юм бэ? Энэ 60, 40 гэдэг бол би дахиад нэг юм хэлчихье. 93 оны хууль дээр байсан юм байна лээ. 2013 оны хуульд Их Хурлаар батлагдаж гарсан хууль дээр бас байгаа. Манай ЗГ тэр үед байсан Норовын Алтанхуяг гэдэг хүн энэ 60, 40-ийг оруулчихсан гээд энэ худлаа гүтгээд байгаа юм Хүрэлбаатар. Энэ Их Хурлынхан нэг дараа нь надад нэг бичгээр өгчхөөрэй. Ямар асуудал вэ гэхээр Их Хурлын архивд байгаа. Би тэр архивыг үзэхээр манай Засгийн газраас 60 дээр нэмэх нь 40-ийг оруулаагүй, 100 мянга доллар л оруулсан юм байна лээ. Дараа нь Их Хурал дээр та нар бүгд мэднэ шүү дээ. Ажлын хэсэг байгуулагдаад л наана, цаана болоод л, тэгээд л Их Хурал чинь ЗГ оруулж ирсэн хуулийг нэмж, хасаад явдаг. Тэгэхдээ 60, 40-ийг нэмсэн юм байна лээ. Би тэрнийг нь буруу гэхгүй байгаа л даа. Их Хурлын бүрэн эрхийн асуудал.

Тэгэхээр ЗГ өргөн бариад батлуулчихсан юм шигээр олон нийтэд энэ айлуудын үндэсний телевизээр орж сууж байгаад худлаа гүтгээд байгааг би шүүхэд өгч байгаа юм. Энэ Занданшатар дарга тэр энэ Их Хурлын Тамгын газар надад албан бичиг өгөх хэрэгтэй байна. 13 оны Засгийн газрын өргөн барьсан төсөл дотор 60, 40 байхгүй гэдгийг нотолсон юмыг надад өгмөөр байна. Ингэж энэ хаваржингаа, энэ зунжингаа ингээд шоу хийж энэ ард түмнийг үймүүлдгээ ер нь болих хэрэгтэй, гүтгэлэг явуулдгаа ерөөсөө болих хэрэгтэй. Энэ, энэ Сангийн сайд, энэ Эдийн засгийн сайд энэ тэр чинь хааччихсан юм бэ? Сонгууль хийгээд л, нөгөө баахан хуссан мөнгөө тараагаад л явж байгаа байх даа одоо. Тэгээд ийм замбараагүй юм хийдэг. адад энийг нэг хэлээд өгөөч Энэ хамгийн чухал асуудал шүү. Тэгээд энэ Их Хурал дээр ер нь ингэж нэг худал, үнэн хүнийг гүтгэдэг явдлыг би бас их олон жил тэвчлээ. Тэгээд би шүүхэд өгөх юм байна. Шүүх дээр очоод үнэн зөвөө бол нотлуулаад ингээд явах юм байна.

Цагаан суваргын асуудлыг би хэлье. Яг энэнтэй холбоотой. Цагаан суваргын 34 хувийг засгийн юу төр эзэмшинэ гэдэг ийм төслийг ЗГ би Ерөнхий сайд байхдаа бичээд Их Хуралд өгсөн юм. Улсын Их Хурал дээр ажлын хэсэг гарч, баахан үзэж юм ярьж байснаа тэрнийг хасаад хаячихсан байхгүй юу. Тэгээд 100 хувь, төрийн өмчийн 34-ийг хасаад 100 хувь хувийнх болгочихсон юм. Гэх мэтчилэн Их Хурал өөрөө бас Засгийн газрын өргөн барьсан олон юмыг өөрчилдөг, муугаар хэлбэл бас лоббид автдаг юм олон байдаг. Энийгээ өөрснөө засаарай.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хууль санаачлагч асуултад хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Алтанхуяг гишүүний асуултад хариулъя. Энэ 2013 онд одоо хүчин төгөлдөр өөрчлөлт орсон,

тэр өмнөх хуулиуд дээр өөрчлөлт нэмэлт, өөрчлөлт оруулаад явсан хамгийн сүүлийн хувилбар хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль нь хуулиас л энэ зүйл, заалтыг хасъя л гэсэн ийм хуулийн төсөл. Тэр асуудлыг Их Хурлын дарга өнөөдөр Их Хурал дээр энэ төсөл ямар явааг Их Хурлын дарга хариулах болов уу.

Г.Занданшатар: 1 дүгээрт энэ Улсын Их Хурлын Тамгын газраас энэ хуулийг хэлэлцэхтэй холбоотой лавлагаа гаргасан. 2013 онд баталсан Хөрөнгө оруулалтын тухай хуулийг Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсөлд энэ заалт байгаагүй. Энэ заалтыг ажлын хэсэг ажиллаад Зоригт гишүүнээр ахлуулсан байсан байх. Ажлын хэсэг ахлаад тэгээд нэг бөөн санал хөрөнгө оруулалтын дэмжлэг, хөрөнгө оруулалтын бус дэмжлэг гэсэн ийм дэмжлэг дотор ингээд ийм заалт батлагдсан юм билээ. Энэ нь бол дараа нь Үндсэн хуулийн зөрчилтэй байна гээд Газрын тухай хуульд өөрчлөлт оруулах гэснийг буцааж байсан юм байна лээ. Сүүлд Засгийн газраас өргөн мэдүүлсэн тэр хууль дээр бол дотоодын хөрөнгө оруулагчдын эрхийг зөрчиж байгаа. Хөрөнгө оруулагч гэдэг ангилалд дотоод, гадаад хоёулаа оруулж байгаа учраас хөрөнгө оруулагч зөвхөн ашиглах эрхтэй гээд оруулаад ирэхээр дотоодын хөрөнгө оруулагч газар тариалангийн зорилгоор, байшин барилгын зорилгоор газар эзэмших эрхгүй агуулгатай болоод, одоо ингээд нөгөө газрыг нь дуртайгаар нь аль ч Засаг дарга цуцлаад хаячхаж болдог, ашиглах эрх энэ тэр бол ийм зохицуулалттай байгаа.

Бусад хөрөнгө оруулалттай холбоотой олон асуудлууд яригдаж байгаа. Энэ асуудлыг хэлэлцээд ингээд хэлэлцэхгүй хойшлуулъя, буцаая гэж, дахин боловсруулах шаардлагатай гэж ийм санал солилцсон байгаа. Харин тэр төсөл дээр орсон заалтыг бол Засгийн газраас өргөн мэдүүлээгүй байсан байх. Тэрнийг бол Тамгын газраас холбогдох хүсэлтээ тавиад мэдээлэл бичиг

баримтуудыг авч болно. Болох байх гэж бодож байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Ц.Туваан: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хууль гээд ард иргэдийг маш их талцуулсан, бухимдуулсан ийм хууль. Тэгээд сүүлдээ ч бүүр бид нар битгий хэл ард иргэд хүртэл ер нь учрыг нь ойлгохоо больчихож байгаа юм. Тийм. Ямар хуулийг нь хэлэлцэх гээд байгаа юм, ямар хууль нь зөв юм, ямар өөрчлөлт орох гээд байгаа юм гээд. Ер нь бол энэ маш чухал асуудал учраас энэ дээр бас тодруулж асуух зүйл байна. Энэ Монгол Улсын газар нутаг дээр одоо олгогдчихсон байгаа энэ газрын лиценз, уур уурхайн лиценз, энэ талын холбоотой асуудал дээр ер нь судалгаа юм уу, тооллого юм уу хийсэн зүйл байгаа юу, ер нь хийх үү? Сая хөдөө орон нутгаар яваад ажиллаж байхад энэ газрын лицензтэй холбоотой ялангуяа маш их асуудал ярьж байна. Гаднын маш олон компаниудад маш их хэмжээний лиценз байдлаар олгосон газрын асуудал ярьж байна. Тэгээд энэ газар газрын доорх баялаг чинь бас төр ард түмний мэдлийнх юм энэнийгээ тоолж мэдсэн, нэгдсэн ийм ил тод олгосон мэдээлэл байна уу гэдэг асуудлыг асууж байна. Тэгэхээр энэ тооллого явуулах уу гэдэг нэг асуулт асууя. Энэ юутай тэр лиценз дээр гэхэд нийт газар нутгийн хэр гадаадын хөрөнгө оруулагчдад хэдэн хувь буюу ямар хэмжээний газар олгогдсон байдаг юм бол? Энэ дээр нэг мэдээлэл авчихъя.

2 дугаарт нь энэ сая энэ хөдөө орон нутгаар явсан үнэхээр нөхцөл байдал бодсоноос илүү хүнд байна. Хавар маш хүнд байна. Сая Бат-Эрдэнэ гишүүн хэлж байна, үнэн шүү дээ. Тэгээд энэ асуудлыг бас ярья гээд ингээд асуудал оруулаад ирэхээр ингээд асуудлыг ерөөсөө авч хэлэлцэхгүй байна. Малчид өнөөдөр яг малаасаа түрүүлээд сөхөрчихсөн, өөрсдөө маш хүнд нөхцөл байдалд дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу байдалтай байна. Тэр малчдын зээлийн

хүүг, хүүд өөрчлөлт оруулсан, одоо тэрийг нь төлж байгаа гээд байгаа юм. Ямар ч тийм юм алга. Малчид энийгээ нэхэж байна гээд л ингээд ярьж байна. Тэр асуудал чинь одоо чухам яаж явж байгаа юм бэ? Тэгэхээр энэ асуудлыг илүү чухалчилж яримаар байна Их Хурлын даргаа.

Тэр малаа алдчихсан, одоо та бүхэн энэ нэг албан ёсны 6 сая гээд л тоо яриад байна. Энэ чинь худлаа шүү. Энэ бол худлаа тоо. Энэ яаж гардаг тоо юм бэ гэхээр багийн дарга нар хөөрхий малчид руугаа асуугаад танайх хэдэн мал хорогдсон бэ тоогоо өгөөч гэж авдаг тоо. Эргээд 1, 2 асуугаад эргээд тэр багийн дарга нар чинь халираад ярьж ч чадахгүй байна. Тэгэхээр энэ худлаа тоо. Явж байхад замаар дүүрэн малын сэг зэм байна. Тэгэхээр энэ асуудлаа урьд нь ярьж хэлэхгүй юм уу?

Дээрээс нь энэ хотын сэргэлт, хөдөөгийн сэргэлт гээд ярьж байгаа энэ эсрэгээрээ явлаа шүү. Одоо бид нар энэ малжуулах хөтөлбөрийг улсын төсвийн тодотгол хийж яаралтай хийхгүй бол аж ахуйгаасаа малаасаа салсан иргэд Улаанбаатар хот, аймгийн төвүүд рүү орж ирэхэд бэлэн болчихсон байна шүү. Тэгэхээр энэ асуудлыг бас яаралтай хэлэлцмээр байна. Бид нараас энэ Улсын Их Хурлын гишүүдээс, Засгийн газраас дорвитой бодлогын өөрчлөлт л хүсэж байна. Энийг бас дамжуулж хэлээч гэдэг ийм зүйл хэлсэн.

Энэ цалин төрийн захиргаа, үйлчилгээний албан хаагч, хөдөө орон нутгийн ажилчдын цалин хөлсийг нэлээн ярьж байж энэ асуудлууд нэмсэн. Тэгэхдээ энэ чинь юмны үнийнхээ өсөлтийг яагаад ч гүйцэхгүй байна. Энэ төрийн захиргаа, төрийн үйлчилгээ, тэтгэврийнхэн чинь бүгдээрээ мал бүхий иргэд байдаг юм. Энэ хүмүүс мах ө... тулдаа өнөөдөр нэг амьдрал нь жоохон болж байгаа юм шиг байгаад байгаа юм. Одоо тэр тэд нарын малыг нь малладаг

хүмүүс нь малын асуудал чинь өөрөө маш өндөр эрсдэлд орчихлоо. Монгол Улс тэр Засгийн газрын гаргасан тоон дээр урьдчилсан.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн Эдийн засгийн байнгын хороон дарга хариулъя.

Ц.Цэрэнпунцаг: Туваан гишүүний асуулт шууд өнөөдрийн хэлэлцэж байгаа хуулийн төсөлтэй бол шууд холбоогүй. Лицензийн мэдээлэл тооллого хийх гэж байна уу гээд асууж байна. Тэгэхдээ энэ газар ашиглалт, энэ лиценз олголт гээд л, тэгээд л татвар ноогдуулалт гээд л энэ маш өргөн цар хүрээтэй сэдвээр Хянан шалгах түр хороо байгуулах бэлтгэл ажлыг хийх ажлын хэсэг Их Хурлаас Их Хурлын даргын захирамжаар гарсан. Энэ ажлын хэсгийг би ахалж ажиллаж, ажлын хэсэг ажиллаад тайлан дүгнэлтээ бэлдээд, тэгээд энэ лицензтэй ялангуяа холбоотой, энэ олголттой холбоотой, өнөөдөр хэчнээн тооны лиценз эзэмшигчид нь эцсийн эзэмшигчид нь ямар хүмүүс байдаг юм энийг нь бид нар ард түмэнд ил тод болгоё гээд Хянан шалгах түр хороо байгуулъя гээд энэ бэлтгэл ажил хангагдсан.

Гишүүд 19-өөс дээш гишүүн зурах ёстой гишүүд хангалттай дэмжиж санаачилж гарын үсгээ зураад өнөөдөр бэлэн болсон. Ингээд Хянан шалгах түр хороо ингээд байгуулагдаад ажиллахаар зэрэг энэ дээр төвлөрч ажлаа хянан шалгах, энэ нотлох баримтыг цуглуулж, энэ ард иргэддээ мэдээллийг ил болгож болгох энэ нотлох баримт дээрээ хяналт шинжилгээ хийж ажиллана. Ажлын дэд хэсэг байгуулсан 19 байгууллагаас мэдээлэл авсан, хангалттай материал цугласан. Тэгээд энэ Хянан шалгах түр хороо ажиллахаар таны энэ асуусан асуултад буюу ард түмний хүсэж байгаа тэр хариулт тэнд гарч ирэх байх гэж бодож байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Хуулийг дэмжиж байна. Энэ хуулийг анхны хэлэлцүүлгээр нь батлах боломжтой юу гэдэг зүйлийг нэг тодруулчихъя. Нөгөө талаар тэр 2013 онд өөрчлөлт ороод Үндсэн хуультай бол нийцэж чадаагүй ийм зүйл, заалт ороод өнөөдрийг хүртэл бараг 20, 10 гаруй жил хэрэглэчихжээ. Энэнээс үүдээд ямаршуухан нөхцөл байдал бий болсон бэ? Энэ талаар та бүхэн бас судалж харсан зүйл байгаа юу нэг?

2 дугаарт, ингээд гаднын Хөрөнгө оруулалтын хууль Засгийн газраас өргөн барьсан. Тэр дотор иймэрхүү алдаанууд их олон гарсан байна. ЗГ энийг чинь дэмжиж байгаа юу? Тэр Засгийн газраас өргөн барьсан хуультай наадах чинь нийцэж байна уу, нийцэхгүй байна уу? Нөгөө талаар бол бид нар чинь, бид нар ч гэж дээ та нар ч эх орончид гээд л өөрсдийгөө, Эх орончдын өдөр гээд л тэмдэглээд л. Бусад нь нэг эх орончид биш юм шиг. Иймэрхүү л байдаг л даа. Гэхдээ энэ хуулийг өргөн барьсан улсуудыг би бол жинхэнэ эх орончид гэж хэлмээр байна. Хэрэгтэй, хэрэггүй баахан хуулиудыг яаравчилсан горимоор оруулж ирээд яваад байдаг. Мааш их маргаан дагуулсан. Ер нь бол газар улсын үндэс. Тэр хэдэн мянган жилийн өмнө Модун Шаньюгийн үед тэр хамаг юмыг нь гуйдаг нэхдэг байхад ганцхан газраа л өгөөгүй байдаг шүү дээ. Хэнд ч хэрэггүй тэр дунд нь байсан үржил шимгүй нэг жсоохон газрыг гуйхад нь өгөөгүй. Бүгд л өгнө гэж бодож байсан. Газар ийм чухал зүйл.

Гадна, дотнын хөрөнгө оруулагчид, Монгол Улсын иргэд ямар ялгаатай нөхцөл байдалтай байдаг юм бэ? Зүгээр жирийн иргэд маань үл хөдлөх хөрөнгөө газраа 10, 15, 20 жилээр эзэмшдэг, тэгээд дараа нь хэдхэн жилээр сунгуулдаг. Иргэддээ ийм хатуу ханддаг мөртөө гаднын хүмүүст бас өөр илүү таатай нөхцөл бий байлгадаг ийм

байхгүй. Энэ гадна, дотнын хөрөнгө оруулагчид ялгаагүй адилхан л хандах ёстой. Гаднын хөрөнгө оруулагч ч гэсэн орж ирээд нэг их гийгүүлээд байгаа юм алга. Энэ манай урд, хойд 2 хөршөөс гаднын хөрөнгө оруулагч нар сүүлийн хэдэн жилүүдэд бүгд л гараад явсан. Тэглээ гээд Монгол Улсад орж ирж байгаа ийм юм алга байна. Бүгд л Энэтхэг, Вьетнам руу л явж байх шиг байна.

Нөгөө талаараа гадаадын аялал жуулчлалыг татъя гээд байдаг. Тэр ОХУ-ын Ерөнхий сайд IT-ийн мэргэжилтнүүдээ хүртэл буцаж ирээч гээд гуйж байна шүү дээ. Тэр IT-ийнх мэргэжилтнүүд буцаж очихгүй байна. Нөгөө манай бас Монгол Улсын хувьд ч гэсэн 300-аад мянган иргэн гадагшаа гараад явчихсан. Тэр дотроо дотор ч гэсэн өндөр чадалтай IT-ийн мэргэжилтнүүд зөндөө бас гараад явчихсан байна. Нөгөө талаар бол энэ өнгөрдөг 8 жил манай иргэдийн хувьд цонх үе байсан байхгүй юу. Энэ залуучуудын ид ажиллах үе. Энэ хугацаа бол бас ингээд алдагдчихлаа. Энэ бүхэн энэ ялгаатай хандагаас бол бий болсон ийм нөхцөл байдал юм гэж дүгнэж болохоор байгаа юм. Тэгээд ер нь энэ хуулийг дэмжиж байна. Өргөн барьсан гишүүдэд талархалтай хандаж байна. Энэ өмнө гарсан алдааг засах гэж байгаад зөв зүйтэй зүйл гэж хэлэх байна.

Г.Занданшатар: Үг хэллээ. Баярлалаа. 1 асуулт. Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн хариулья.

Ц.Цэрэнпунцаг: Анхны хэлэлцүүлгээр дэмжих бололцоотой юу гэж. Энэ ерөөсөө 1 л зүйлд зүйл, заалт хасаж байгаа ингээд гишүүд маань дэмжвэл анхны хэлэлцүүлгээр ингээд баталгаажуулчих боломжтой ийм юм.

2 дугаарт таны тэр 2 дахь асуулт нь бид нар өнөөдөр тооцож чадахгүй байна энэ хор уригийг нь 2013 оноос ийм

хуулийн зөрчилтэй яваад өнөөдөр өдийг хүртэл явсны хор уришиг. Энэ Хянан шалгах түр хороо байгуулагдаад ажиллахаар бас нэлээн зүйл нь тодорхой болох байх. Ер нь Алтанхуяг гишүүний түрүүний хэлдэг бас нэг зарчмын нэг саналтай нэг байгаа юм. Ер нь хөрөнгө оруулалт. Бид нар энэ газраа улсын үндэс болсон энэ газраа бид нар хөрөнгө оруулалтын татварын бус дэмжлэг хэлбэрээр *perk* болгож хөрөнгө оруулагчдыг татдаг, *perk* болгож ашиглах чинь үндсэндээ зөв юм уу, буруу юм уу бид нар бас сайн энийг эргэж бас бодох ёстой л асуудал гэж бодож байгаа.

Г.Занданишатар: Ганбат гишүүн маш тодорхой асуудал асуулаа л даа. Ер нь тэгээд энэ гадаад, дотоодын аливаа хөрөнгө оруулагчдын асуудал тогтвортой байдал, ойлгомжтой байдал, энэ авлигал, хээл хахууль, шүүх энэ маш олон хүчин зүйлээс хамаарч байгаа бөгөөд хамгийн гол нь тогтвортой ойлгомжтой хууль байна гэж байгаа юм. Тэгтэл энэний нэг иүүд эдийн засаг, нийгмийн үр дагавар гэж нэг их юм байхгүй л дээ. Засгийн газраас өгсөн санал дээр 44 дүгээр зүйлийн юу, Засгийн газрын санал бол энэ Газрын хуулиар зохицуулагдсан энэ хууль үйлчлээгүй, хэрэггүй илүү заалт, хасаад Газрын хуулиараа зохицуулах нь зүйтэй гэж дэмжсэн санал өгөөд. Тухайлбал холбогдох яам, тамгын газраас лавлагаа авахад ингэж өгсөн байгаа юм. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид юу Газрын тухай хуулийн 44-ийн Газрын тухай хуулийн 18.1.6-д Засгийн газрын бүрэн эрхэд энэ хуулийн 17.1.2-т заасан газрын зааг, ашиглах журмыг тогтооно гээд заачихсан Засгийн газар. 44 дүгээр зүйлийн 44.5-д гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ хуулийн дагуу газрыг тусгай зориулалт, хугацаа, болзолтойгоор ашиглуулах бөгөөд уг хугацааг ЗГ тогтооно гээд тус тус заасан.

Газар ашиглуулахтай холбоотой тухайлсан харилцааг Газрын тухай хуулиар зохицуулсан байх тул Хөрөнгө оруулалтын тухай хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгох хуулийн төслийг дэмжиж байгаа болно гэж холбогдох яам, газрын харилцаа асуусан газар энэ тэрүүд тийм санал ирсэн. Тийм учраас энэ ямарваа нэгэн, тийм. Дашидондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Нэгэнт бид нар газрын асуудлыг ярьж байна. Тэгэхээр Монгол Улсын маань газар үе үед нэлээн алдагдсан уу яасан бэ? Тэр Хэнтий соёны гээд л бага ангид байхад бид нар унидаг л байсан Миний нутаг дээр. Тэр Соёны уул нь одоо хаана байна вэ? Тэр Тана уул бас хаана байна вэ? Цэдэнбал даргын өвөлжөө байдаг юм уу, байдаггүй юм уу? Энийг нь одоо та нар үзсэн юм уу, харсан юм уу? Нэгэнт газрын асуудал ярьж байгаа бол. Тэгээд өөрсдийгөө эх орончид л гээд байдаг. Энийг бас тодруулах хэрэгтэй. Нэгэнт газрын асуудлыг ярьж байгаа юм та бүхэн бас энэ юмыг бас нэлээн ултай суурьтай бас судалсан барьсан байдаг байлгүй дээ. Тэр тусмаа эх орончид маань.

Г.Занданишатар: Ер нь энэ Монгол Улсын дархан хил, тусгаар тогтнолын аюулгүй байдлыг, Монгол Улсын хилийг 2 хөрш оронтойгоо тогтоосон хилийн хэлэлцээр байгуулснаараа баталгаажсан түүхэн үйл явдал гэж тооцдог. Тийм учраас энэ одоо 2 хөрш оронтойгоо Монгол Улс хилийн ямарваа нэгэн маргаангүй бөгөөд дэлхийн бүх улсуудын энэ хилийн зөрчил дайн байлдаан хилийн маргаантай холбоотой. Ер нь манай хөрш орнуудын хувьд ч гэсэн тэр олон улсын энэ өмнөд тэнгисийн болон бүх хил маргаан бол энэ хилтэй холбоотой. Тэгтэл манай энэ өвөг дээдсийн тухайлбал Цэдэнбал даргын ч гэдэг юм уу тухайн үед батлагдсан түүхэн асуудал бол 2 хөрш оронтойгоо ямарваа нэгэн хилийн маргаангүй бөгөөд хилээ тогтоосон хилийн хэлэлцээр байгуулсан явдал гэж

үздэг л дээ. Тийм учраас энэ хилийн асуудал бол 2 хөри оронтойгоо яриаар нэг маргаангүй бөгөөд Монгол Улсын энэ дархан хил, тусгаар тогтнол баталгаажсан явдал бол НҮБ-аар баталгаажсан ийм түүхэн үйл явдал гэж үзэж болно.

Харин тэрэнтэй холбоотой янз бүрийн газар олгох, ашиглахтай холбоотой асуудлуудыг энэ бол Хяналт шалгалтын түр хороо шалгаж ажиллаж байгаа юм. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Та бид мэдэж байгаа шүү дээ. Ерөөсөө улс оршихуйн үндэс бол газар л гэж. Бидний өвөг дээдэс Их Эзэн Богд Чингис хаан сургачихсан шүү дээ. Их засаг хуульдаа тусгачихсан. Улс оршихуйн үндэс газар шороо, хүн ард гэж хоёрхон багана байна л гэж. Тэгээд энэ газар шороотой холбоотой асуудал, газар нутаг энэ байгаль орчны асуудал бол хүн оршихуйн үндэс болсон энэ чухал асуудалд их онцгой анхаарах ёстой юм. Тэгээд энд бид үе үеийн парламентад бол энэ асуудлыг тавьж ирсэн. Одоо энэ Хөрөнгө оруулалтын хуультай холбоотой асуудал гэхэд тэр 100 мянган долларын босго тавьчихсан байсан. Энэ 20 оны парламентын үед Их Хурлын гишүүд санаачлаад 50 мянга болгож буулгахаар оруулж ирсэн шүү дээ. Тэрийг чинь нэг юм арай гэж эсэргүүцэж байж хэлэлцээгүй. Гэтэл дахиад бүүр босгыг нь намхан болгоод, хэдхэн төгрөг зарцуулаад тэгээд Монголд газрыг 60 дээр нэмэх нь 40 жилээр эзэмших, ашиглах тухай ийм юм хэрхэвч байж болохгүй байна шүү дээ. Энэ асуудлыг Их Хурал дээр хамгийн түрүүнд л байж болохгүй л гэдэг байр суурь асуудлаа илэрхийлсэн. Ийм л юм байгаа юм. Тийм учраас энэ хуулийг бүрэн дүүрэн дэмжиж байгаа.

Энэ D-parliament-н хүрээнд бол энэ иргэд олон түмний саналыг авч байгаа, энэ цахим үндэстэн болж байгаа энэ их

том бодлогын хүрээнд энэ саналыг аваад, энэ хуулийн төслийг төслөөс тэр 60, 40 гэдэг 100 жилээр гадаадынханд өгөх энэ заалтыг хасаж байгааг бүрэн дүүрэн дэмжиж байгаа гэдгээ хэлье. Ерөөсөө би түрүүн хэлсэн шүү дээ. Энэ байгаль орчны асуудал доройтоод байна, энэ цөлжилт хэрээсээ хэтэрлээ. Энэ байгаль орчны тэнцвэрийг хадгалах, тэр ойн сан бүхий газраа хамгаалъя, усны эхээ, усны сав дагуу газраа хамгаалъя. Тэгээд л ийм асуудлыг тавихаар би түрүүн хэлсэн шүү дээ, ерөөсөө энэ үе үеийн парламент бол энэ рүү хуруугаа байтугай хумсаа хөдөлгөх ч дургүй ийм улсууд суугаад байдаг. 2 бүлэг улсууд гэж би хэлээд байгаа шүү дээ. Би ихэнхийг нь хэлж байгаа юм биш. Гэхдээ энийг чинь Урт нэртэй хууль гээд батлагдсан. Энийг нэлээн сэглэсэн. Тэгээд энэний үр дүн ямар байна вэ, энийг бүүр тусгайлан Их Хурал дээр нэг сонсох шаардлагатай байгаа гэдэг би саналаа хэлье.

Дараагийнх нь юм бол харин энэ Засгийн газраас авч байгаа нэг чухал шинэчлэл бол энэ газрынхаа хэвлийн баялгийг өөрснөө тандан судалгаа, энэ урьдчилсан хайгуулын юмнуудыг хийх зорилгоор 1 сая га газар буюу нийт газар нутгийнхаа 5 орчим хувийг нь Засгийн мэдэлд аваад, ингээд нууцын зэрэглэлтэйгээр газрын хэвлэлийнхээ баялгийг тандан судлахтай холбоотой энэ зорилт тавьж байгаа их чухал байгаа юм. Тэгээд энийгээ нийгэмд бусдад ойлгуулж байгаа энэ мэдээллээ хүргэх юман дээр их онцгой анхаарах ийм шаардлагатай байгаа юм.

Цаашилаад хэлэх юм бол ерөөсөө тэр 97 оны Ашигт малтмалын хуулиар энэ байгалийн баялаг, хэвлийн баялаг, энэ газар лицензтэй холбоотой юмыг ингээд зүгээр тараагаад өгчихсөн. Энэний хорттой үр дагавар бол өнөөдөр ч тасраагүй байгаа учраас одоо энэ Ашигт малтмалын хууль дээр энийг онцгойлон анхаарах хэрэгтэй. Байгаль орчиндоо хохиролтой, энэ цөлжилтийг хурдасгаж

байгаа, тэгээд малчдын амьдрах энэ бэлчээрийг талхалж гүйцээж байгаа, тэгээд ямар нэгэн улсад болоод орон нутагтаа үр өгөөж байхгүй ийм жижиг уурхай ийм юмнуудаас салах хэрэгтэй. Хайгуулын лицензийг өгөөд л, ашиглалтын лиценз болгох шилжүүлэх бол алга урвуулахын дайтай энэ 30 жилийн хугацаанд энэ 30-аад жилийн хугацаанд ингэж явж ирлээ шүү дээ. Ийм бодлогын юмнуудаа бид засах хэрэгтэй. Тэр анх шинэ харилцаанд шилжсэн 93 оноос хойш энэ 13 оны Их Хурлын шийдвэр, өнөөдрийн энэ орж ирж байгаа ийм газартай холбоотой юманд туйлын анхаарал болгоомжтой байхгүй бол энэ улс орон чинь ер нь оришгүй, ер нь хэцүү байдал болно шүү. Улс орнууд чинь ерөөсөө л газар нутгаа тэлэх тухай асуудал энэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Эдийн засгийн байнгын хорооны дарга Цэдэндамбын Цэрэнпунцаг санаачлагч. 1 минут гэж байхгүй. Асуулт, хариулт тодорхойгүй л бол юу яана.

Ц.Цэрэнпунцаг: Хариулчихъя. Бат-Эрдэнэ гишүүн ерөнхийдөө санал хэллээ. Энэ хуулийн өөрчлөлт бол хуульд өөрчлөлт оруулж байгаа гол цаана нь байгаа гол шалтгаан сая түрүүн ч би хэлсэн хөрөнгө, энэ газрыг татварын бус ийм дэмжлэгээр дэмжлэг үзүүлэх зорилгоор бид нар ашиглах ёсгүй. Энэ бол энэ ийм гэж үзэж байгаа учраас энэ дээр бид нар энэ Хөрөнгө оруулалтын хуулиас энийг хасъя, энэ зүйл, заалтыг хасъя гэж оруулж ирж байгаа юм.

Дээрээс нь угаасаа Үндсэн хуультай зөрчилдөх ийм эрсдэлтэй, мөн Улсын Их Хурал, юу газрын Газрын тухай хуультай зөрчилдөж байгаа зөрчилдөх ийм эрсдэл гарч ирж байгаа. Яагаад гэвэл Хөрөнгө оруулалтын хууль өөрөө ерөнхий хөрөнгө оруулагчийг дотоод, гадаадын гэж ялгаагүй ингээд орж ирж байгаа учраас. Дотоодын хөрөнгө оруулагчид байх юм энэ зөрчил гарахгүй. Гадаад,

гадаадын хөрөнгө оруулагч, гадаадын иргэн харьяалал Монгол Улсын, гадаадын харьяалалтай иргэн байх юм бол энэ дээр ийм зөрчил үүсэх ийм эрсдэлүүд үүсэж байгаа учраас л энэ хуулийн зөрчлийг арилгаж байгаа ийм үр дүн гарах юм.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна.

Б.Бат-Эрдэнэ: Түрүүн цаг багтаагүй юм. Алтанхуяг гишүүн бол яг тодорхой болсон явдлыг хэлээд байна л даа. Засгийн газар Их Хурал руу саналаа өгөөд байхад энэ стратегийн орд газруудыг Их Хурал дээр орж ирээд шал өөр болчихдог гэж. Яг түүний тодорхой жишиг бол энэ Ноён уулын 70 тонн алтны тухай асуудал байсан. Энэ Урт нэртэй хуулиар ашиглаж болохгүй байгаа учраас Сентерра Гоулд-ын нөхдүүд энэ Их Хурал дээр намын бүлгүүдэд танилцуулж байсан. Бид нар бол үйлдвэрийн бааз нь бэлэн байна, хөрөнгө санхүү нь бэлэн байна. Ерөөсөө тэр Урт нэртэй хуулийн дагуу стратегийн ач холбогдолтой ордод л аваад өгөөч. Тэгэх юм бол бид нар ашиглалтаа явуулъя, Монголын Засгийн газрын эзэмших хувийг бүүр хангалттайгаар өгье гээд ийм асуудал яриад л Их Хурал руу 2 мянгаас 12-оос 16 оны Алтанхуягийн Засгийн газрын үеийн юм ярьж байна шүү дээ. Зандаахүүгийн Энхболдын даргалж байх үеийн Их Хурлыг ярьж байна. Тэгээд Их Хурал руу ороод л 1 сарын дараа хүрч ирэхээр зэрэг Монголын төр бол ийм хэмжээний хөрөнгө мөнгө гаргах арга байхгүй. Тийм учраас энэ Сентерра Гоулд-д бүрэн хэмжээнд шилжүүлж ашиг.../минут дуусав/

Г.Занданшатар: Тийм. Ер нь тэр үед бид нар Улсын Их Хурлын гишүүд байгаагүй л дээ Улсын Их Хурлаар. Та бүхнийг Улсын Их Хуралд байхад л тэр энэ хууль ч тэр, тэр наад стратегийн орд газрын асуудлууд ч гэсэн шийдэгдсэн юм байна лээ шүү. Энийгээ бас сайн үзэж

харах хэрэгтэй. Тэр өөр үед. Одонгийн Цогтгэрэл гишүүн. Алга байна, тасаллаа. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ Хөрөнгө оруулалтын хуулиас энэ заалтыг хассанаар гадаадын иргэн, аж ахуйн нэгжид газар олголтыг зогсоочихно гэж би харахгүй байна л даа. Яагаад гэхээр гол харилцаа чинь Газрын тухай хууль дээр байгаа. Тэгээд өнөөдрийн энэ харилцаа яаж яваад байгаа гэхээр шууд гадаадын иргэнд газрыг олгохгүйгээр өнөөдөр хамгийн өндөр үнэ хэлсэн мөнгөтэй хүн газрын дуудлага худалдаагаар авч байгаа. Тэгэхээр тэрний цаана Монгол иргэдийг оролцуулаад дараа нь цаад яг жинхэнэ эзэмшигч нь гадаадын иргэн байх ийм харилцаа яваад байгаа юм. Энийг яаж ер нь иж бүрэн утгаар нь зогсоох юм бэ? Тэгэхгүй бол одоо энэ хуулиар ингээд гадаадын иргэн, аж ахуйн нэгжид газар олгохгүй юм байна гэдэг ингэчихлээ. Энэ харилцаа ингээд иж бүрэн шийдэгдлээ гээд ойлгох юм шиг боловч яг цаанаа жинхэнэ мөнгөтэй хүмүүс бол Монгол иргэдийг газрын дуудлага худалдаа иргэн, аж ахуйн нэгжийг оруулж авхуулчхаад цаана нь өөрөө газрын эзнээр ашиглаж эзэмшээд суугаад байх энэ харилцаа яг иж бүрнээр ингээд бас зогсохгүй нь. Тэгэхээр энэ Газрын тухай хуульдаа бас энэ харилцааг хязгаарласан зохицуулалтыг нь давхар оруулж ирэхгүй байсан юм уу гэж би хууль санаачлагчаас асууж байна. Уучлаарай хоолой сөөчхөөд бас ингээд.

Г.Занданшатар: Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн Эдийн засгийн байнгын хорооны дарга, хууль санаачлагч.

Ц.Цэрэнпунцаг: Өнөөдөр бид нар Газрын хууль дээр холбоотой асуудлыг энд оруулж ирээгүй. Зөвхөн Хөрөнгө оруулалтын хууль дээр байгаа газарт нь газрын харилцааг зохицуулсан тэр зүйл, заалтыг нь хасаж, одоо байгаа Газрынхаа ерөнхий хуультай ингээд зөрчлийг нь арилгая л гэж оруулж ирж байгаа юм. Тэгэхээр цаашаа энэ дахиад

яригдах зүйл байх. Тусдаа яригдах зүйл байх л гэж бодож байна.

Г.Занданшатар: Тэгээд энэ 1 дүгээрт Үндсэн хуулийн зөрчилтэй, 2 дугаарт Газрын тухай хуулийн зөрчилтэй гэдгээ хэлсэн тийм ээ. 2 дугаарт Цэрэнпунцаг гишүүн бас Эдийн засгийн байнгын хорооны даргаар ахлуулсан энэ газрын харилцаатай холбоотой, ашигт малтмалын лицензтэй холбоотой асуудлыг хянан шалгах ажлын хэсэг байгуулаад Хяналт шалгалтын түр хороо байгуулах бэлтгэл ажлыг хангах бүхий ажлын хэсэг байгуулаад энэ хүрээн дээр газрын сан, ашигт малтмалын лиценз, санд дата цуглуулаад программчлал ашиглаад хиймэл оюун ухаанаар хяналт шалгалтын бэлтгэл ажлыг Улсын Их Хурлын хяналт шалгалтын газраас зохион байгуулж хийж байгаа. Энэ хүрээнд маш олон асуудлууд ил тод болж байгаа. Энэнээс зарим нь хууль хяналтын байгууллагуудад шилжигдээд шалгагдаж байгаа. Жишээлбэл Цэндийн Сандаг-Очир гишүүний хэлсэн тэр Монгол Улсын иргэний нэрээр гадаадын иргэд газар Өмнөговь аймагт авч тусгай зөвшөөрөл авсан байсан асуудлыг хууль хяналтын байгууллага шалгаад тогтоогоод, холбогдох этгээдүүдийг эрүүгийн хариуцлагад татаад хянан шалгаж байгаа гэсэн мэдээллийн зэрэгцээ энэ ашигт малтмалын лицензийн хувьд ч гэсэн тэр дамлан худалдаалдаг хэсэг бүлгүүд, мөн энэ ашигт малтмалын лицензтэй холбоотой маш том хяналт шалгалтын ажил явагдаж байгаа бөгөөд энэ чиглэлээр ажлын хэсэг Хяналт шалгалтын түр хороо байгуулах санаачилга гарсан. Энэ дээр Сандаг-Очир гишүүн, бусад гишүүд их идэвхтэй гарын үсгээ зураад Хяналт шалгалтын түр хороо байгуулаад, энэ дээр бас идэвхтэй санаачлаад оролцоод ажиллахыг бас уриалж байна. Энэ ер нь хяналт шалгалтаар л тогтоогдох асуудлууд. Хуулиар гэхээр, хуульд бол энэ бүгд хориглосон заалтууд байгаа юм.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Дэмжсэн, дэмжээгүй үг хэлэх гишүүн байна уу? Бейсен гишүүн, Бат-Эрдэнэ, Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ нарын гишүүд үг хэлнэ. Дараа нь санал хураалт явуулах тул гишүүд чуулганы танхимд цуглаарай. Буланы Бейсен гишүүн үг хэлнэ.

Б.Бейсен: Энэ Хөрөнгө оруулалтын тухай хуулийг дэмжиж байгаа юм. Гадаадын хөрөнгө оруулалт орж ирээд бас эх орны хөгжилд нэлээн сайн л байх. Гэхдээ энэ газрыг нь нөгөө 100 жилээр олгоно гэдэг авч хаясан гээд л ойлгоод байгаа шүү дээ. Одоогийн энэ бичил уурхайнууд байна, том, том уурхайнууд байна. Энийг чинь олон Тавантолгой шиг олон хувааж эзэмисэн гадаадын иргэд их байна. Хэрвээ газар ололтын юугаар эд нар орж ирчхээд газар орныг нь ухааж төнхөөд бүх баялгийг нь аваад явчих боломж бас байгаа юм шиг байна. Тийм учраас энд анхаарах шаардлагатай.

Жишээлбэл Баян-Өлгий аймгийн Цэнгэл сумын тэр алт чинь эзэн нь Хятад шүү дээ. Тэр дулаан арын хар тугалганы эзэн нь мөн Хятад. Тэр Улаан-Уулын Вольфрам мөн Хятад. Дандаа нэг нэгэндээ дамлаад зардаг ийм ноцтой асуудлууд байж байгаа. Энд Эдийн засгийн яам, энд Уур уурхайн яам бол анхаарч бас Засгийн газрын энэ дээр нэлээн бодлоготой хандахгүй бол өнөө Тажикстан шиг болчих вий. Газраа алдана шүү дээ бид нар. Нөгөө талаар газар эзэмшигч нь Монгол иргэн байх ёстой гэдгийг хатуу тусгах хэрэгтэй. Гадаадын иргэнд шилжүүлбэл хуулийн хатуу хариуцлага хүлээлгэнэ гэдгийг эндээ тусгаж өгөхгүй бол энэ газраа алдах аюул бий.

Хөрөнгө оруулалт дээр бүсчилж хөгжүүлэх асуудал дээр нэлээн хилийн дагуу стратегийн чухал аймгууд байж байгаа. Дээр үед чинь Цагааннуурын дамжлага бааз байхад тэнд чинь малын

түүхий эд боловсруулах үйлдвэрүүд ч байсан. Бүх түүхий эд энүүгээр гардаг байсан. Саяын юугаар чинь сая Бямбацогт гишүүн гишүүдийг дагуулаад явсан наад нөгөө Баян-Өлгий аймгийг үндэсний цөөнхөөр нь тусгай болгосон нь гай болох юм шиг байна. Манай аймгийн удирдлагуудаас Улсын Их Хурлын гишүүд нэгийг нь ч дагуулж яваагүй. Наад талын 4 аймгийн бүх удирдлагуудаа дагуулаад явсан байна. Цаашидаа энэ хөрөнгө оруулалтын асуудал дээр яг бүсчлэх дээр манай аймгийг Их Хурлын дарга анхаарч үзэхгүй болохгүй юм шиг байна. Хөрөнгө оруулалт дээр яг тодорхой юуны чиглэлээр гэдэг бүсчлэн хөгжүүлэх асуудал дээр бас нэг тусгаад, хөрөнгө оруулалтын асуудал дээр бүсчилсэн хөгжил дээр уялдуулан оруулах нь зөв байх гэсэн саналыг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар:

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн үг хэлнэ.

Б.Бат-Эрдэнэ: Энэ хуулийг бол бүрэн дүүрэн дэмжиж байгаа. Тэгээд ер нь эх орныхоо газар шороотой холбоотой энэ эрх ашгийг хөндсөн ийм хуулийн зүйл, заалт энэ төсөл санаачилж хэрхэвч болохгүй. Энийг бол ер нь эгнэгт таслан зогсоохгүй бол энэ үе үеийн парламентад ийм санаархал юмнууд явдаг. Түрүүн би яриад байгаа тэр Сентерра Гоулдын тэр Ноён уулын алтыг авахтай холбоотой, стратегийн чухал ач холбогдолтой газруудыг Улсын Их Хурлын тогтоол гаргуулаад, эндээс хавтаслаад гарч байсан тухай 12-оос 16-ны асуудлыг ярьж байгаа юм. Тэгээд тэр үед бол бид Их Хурлын гишүүнээр ажиллаж байсан нь үнэн. Гэхдээ үнэхээр цөөдөж байсан шүү. Тэр цөөдөж байсан ч гэсэн энэний эсрэг их энэ эх орныхоо нийтлэг эрх ашгийн төлөө бид хатуу байр суурьтай ингэж явсан. Энэ илэрхийлсэн байр суурь, эсэргүүцсэн энэ бүх юм бол Их Хурлын архивд байгаа, видео, аудио бичлэг бүх юмнууд нь байж байгаа, бичиг цаасанд энэ нь бичиг

баримтад үлдсэн байгаа. Ийм зүйл юм шүү. Үнэхээр харамсалтай.

Энэ ер нь зүгээр цааш нь ярих юм бол энэ 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар өнөөдрийн бид нар алдааг нь засаж чадахгүй байгаа Оюу толгойн том ордын асуудал, үүний дараа тэр стратегийн ач холбогдолтой орд газруудаа авч чадалгүй алдсан тухай асуудал, энэ Ноён уулын алтны асуудал гээд энэ олон асуудлууд хөвөрч байгаа шүү. Тийм учраас бол тухайн үед ямар байсан гэхээр зэрэг төрийн 3 өндөрлөг бол өөр байр суурьтай. Үнэн өөр байр суурьтай байдаг юм уу, худлаа өөр байр суурьтай байдаг юм уу, тэр нь тусдаа асуудал. Тэгээд энэнээс болоод миний түрүүний хэлээд байгаа энэ том орд газруудын хувь заяа үнэхээр хүнд байдал руу орсон шүү. Харин сайшаалтай нь бол энэ үед ялангуяа энэ сүүлийн 2 бүрэн эрхийн хугацаанд бол төрийн өндөрлөгүүд гэж ярьдаг Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, Ерөнхий сайдууд нэгдсэн нэг байр суурьтай байж байгаа нь энэ эх орныхоо баялагт эзэн байх, энэ газар нутгийн бүрэн бүтэн байдалтай холбоотой асуудлуудад бол ер нь ихээхэн ахиц гарч байгаа шүү.

Тэр оюу, Ноён уулын зовлонт энэ цаг хугацааг бол эцсийн цэгийг нь Хүрэлсүх Ерөнхий сайдын Засгийн газар тавьсан шүү. Ноён уул, Тос тосон бумбын орд, Салхит, Багануур, Эрдэнэт, ингээд Оюун-Эрдэнийн Засгийн газрын үед Занданишатарыг Их Хурлыг даргалж байгаа энэ үед энэ 103 дугаар тогтоол энэ Оюу толгойн эхний нааштай алхмыг бид хийсэн. Энэний цаад талд өчнөөн асуудал байгаа. Энэ бүхнийг бол бид нар цэгцлэх ёстой. Би шаардаад байгаа шүү дээ. Энэ стратегийн ач холбогдолд авахаар ордуудыг хэсэгчилчихсэн, стратегийн ач холбогдолд орохоор ордуудын нөөцийг нь илт бууруулаад, одоо яригдаж байгаа юм Хөшөөтийн орд байна, коксожсон нүүрс, баруун алс хязгаарт байгаа учраас энд анхаарал тавихгүй ингээд яваад байгаа

юм. Энэ бол жишээлбэл 400 сая тонноор тогтоогдсон нөөц өнөөдөр 120 сая тонноор тогтоочихсон тухай асуудал яригдаад байгаа шүү дээ. Ингэж багасгаж байгаад стратегийн ач холбогдол бүхий орд газруудаас гаргадаг ийм олон асуудлууд байгаа юм.

Тийм учраас бол энэ газартай холбоотой асуудал, мөн л 2012-оос 2016 онд энэ Бэлчээрийн тухай хууль оруулж ирээд ингээд бэлчээрийг цаад талд нь хашаажуулах тухай ийм асуудал гарсан. Тэгээд ажлын хэсэг дээр бид нар хөөцөлдөж байгаад энэ Өвөр Монголын яг энэ чиглэлээр мэргэжсэн профессор эрдэмтдийг авчирч хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тэнд үнэхээр энэ Монголын нүүдлийн энэ уламжлалт мал аж ахуй яаж хэрхэн хүнд байдалд орсон талаар маш тодорхой танилцуулгыг хийсэн шүү дээ. Ингэж байж тэр Бэлчээрийн хуультай асуудлыг бид нар зогсоож байсан. Ингээд ярих юм бол өчнөөн олон асуудал байдаг юм. Тийм учраас үе үеийн парламентаас нөхдүүдээсээ хүсэх юм бол энэ улс оршихуйн үндэс энэ газар шороотой холбоотой юман дээр тун хатуу байхгүй бол болохгүй шүү. Ямар санаа оноотой ийм юм оруулаад байдаг юм, энийг бол тэр шалгадаг үздэг байгууллагууд нь хатуу шалгаж байх ёстой гэсэн ийм саналыг хэлье. Энэ хуулийн төслийг дэмжиж байна.

Г.Занданишатар: Гишүүд үг хэлж дууслаа. Дэмжсэн үг хэлсэн гишүүдэд баярлалаа. Санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглая. Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулна. Гишүүдийг дуудаарай. Тэгээд гишүүд дараа нь эсрэг гарчхаад сүүлд нь бас, эсрэг гарчхаад тэгээд сүүлд нь бас энэ тэгсэн, ингэсэн гээд янз бүрийн яриа хөөрөөнд орох вий. Гарчихсан байгаа

гишүүд гадаа ойрхон байвал дуудаарай. Тэгвэл санал хураалт явуулъя.

Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

Энэ санал би дараад байхад эсрэг гарч байна, эсрэг гарсан байна. Тийм учраас миний горимын саналаар энэ хэд хэдэн хүнийх тэгж гарсан байна. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт явуулна.

Гишүүд анхааралтай байгаарай. Энэ санал хураалтыг хүчингүйд тооцох санал хураалт. Тийм хүчингүй болгох.

55 хувийн саналаар өмнөх санал хураалтыг хүчингүйд тооцлоо.

Энэ санал хураалт хүчингүйд тооцсон учраас санал хураалтыг дахиж явуулна.

Байнгын хорооны саналаар Хөрөнгө оруулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томъёоллоор санал хураалт дахиж явуулъя. Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 65 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Энэ хууль үндсэндээ хэрэгжихгүй байгаа. Үндсэн хуулийн зөрчилтэй, Газрын тухай хуулийн зөрчилтэй. Уг харилцааг Газрын тухай хуулиар зохицуулж байгаа бөгөөд Газрын тухай хуулийн 44.5-д гадаад иргэн, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрыг тусгай болзол, нөхцөлийн дагуу ашиглуулах асуудлыг ЗГ журмаар тогтоож хэрэгжүүлэх бөгөөд хугацааг ЗГ тогтооно гэсэн ийм заалттай. Тэр журмын дагуу тэгээд хэрэгжээд явж

байгаа. Энэ заалт хэрэгждэггүй заалт гэсэн үг. Тэгтэл, тийм учраас энэ заалт хүчингүй болох нь зүйтэй гэж бүх тал, холбогдох яам, газруудын лавлагаагаар ч гэсэн хүртэл тэгж дэмжсэн. Ийм учраас сая бас Дашдондогийн Ганбат гишүүн ч гэсэн санал гаргалаа. Эдийн засгийн байнгын хороо бас анхны хэлэлцүүлгээр нь батлах нь зүйтэй гэсэн ийм саналыг бас Байнгын хорооны дарга юу гишүүд гаргаж байна. Тэгээд энийг бас Байнгын хороогоороо хэлэлцэж шийдвэрлэх нь зүйтэй байх.

Ингээд төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Эдийн засгийн байнгын хороонд шилжүүлж байна.

11.23 цагт

Дараагийн асуудалд орно.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал танилцуулна.

Ж.Батжаргал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын нэр бүхий 38 гишүүнээс Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай анхдагч хуулийн төслийг санаачлан боловсруулж, 2024 оны 03 дугаар сарын 24-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.

Уг хуулийн төслийг санаачлан боловсруулах дараах шаардлагууд байна. Эдийн засгийн анхдагч уламжлалт бэлчээрийн мал аж ахуйн тогтвортой хөгжлийг хангах нь дэлхийн бусад орнуудаас ялгарах, ондооших, өвөг дээдсийнхээ өв, нүүдлийн соёл иргэншилээ

хадгалж, хойч үедээ өвлүүлэх, эдийн засгийн бусад салбарын хөгжлийн тулгуур, хүнсний хангамж, аюулгүй байдлын үндэс юм. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтөөс хамаарч ган зуд, байгалийн эрсдэлт болон давагдашгүй хүчин зүйлийн давтамж ойртсон, манай улсын нийт газар нутгийн 76,9 хувь нь ямар нэгэн байдлаар доройтол, цөлжилтөд нэрвэгдсэн байгаагаас бэлчээрийн мал аж ахуйн салбар эрсдэлт байдалтай нүүр тулаад байна.

Манай эрдэмтдийн судалгаа дүгнэлтээр нэн яаралтай зөв менежмент авч хэрэгжүүлбэл доройтсон цөлжсөн бэлчээрийн 80 хувь нь байгалийн жамаараа сэргэнэ гэсэн ийм дүгнэлт байна. Үүний зэрэгцээ бэлчээрийн даац хэтэрснээс мал нь тэжээл, эрдэс, амин дэмийн дутагдалд орон давжаарч, ашиг шим, үнэ цэн буурч байна. ХХААХҮЯ-ны 2018 оны мэдээгээр 2004-өөс 14 онд хонины амьдын жин 1-2 кг, үхрийнх 30 кг-аар буурсан. 1990-2016 онд богийн гулуузын жин 13,9 хувиар буурсан баримт байна. Өөрөөр хэлбэл манай улсын эдийн засгийн гол салбарын нэг болсон МАА маань бүтээмж буурч, үнэ цэн муутай, улсын эдийн засагт оруулах хувь нэмэр улам буурсаар байгааг та бид харж байгаа билээ. Энэ хэрээр малчдын аж амьдралд сөргөөр нөлөөлж, малынхаа тоог нэмэгдүүлэхээс өөр аргагүй байдалд хүрч байна.

Иймд Монгол орны газар зүй, уур амьсгал, бэлчээрийн мал аж ахуйн онцлогоос хамааран Монголчуудын эрт дээр үеэс айл саахалтаараа хүч хөдөлмөрөө нэгтгэн, байгаль цаг уурын хүндрэл бэрхшиээлийг даван туулж ирсэн уламжлалыг өнөө цагийн уур амьсгал, нийгмийн хэрэгцээ шаардлагатай уялдуулж малчдын өөрсдийн үүсгэл санаачилга, оролцоонд тулгуурлан хамтын удирдлага хариуцлагын үндсэн дээр байгалийн нөөц, бэлчээрийг доройтлоос хамгаалах, зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх нь

өнөөдрийн бидний зайлиггүй шийдвэрлэх ёстой, хойшлуулиггүй чухал асуудал болж тулгараад байна. Үүнийг шийдэхийн тулд хууль зүйн хувьд малчдын хамтын зохион байгуулалт, өөрсдийн үүсгэл санаачилгын байгууллагыг эрх зүйн байдлыг нь тодорхойлж өгөх нь ач холбогдолтой гэж үзэж хуулийн төслийг санаачлан Улсын Их Хурлаар хэлэлцүүлж байна.

Малчин өрхийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл нь 5 бүлэг 34 зүйлтэй. Зэргэлдээ нутаг буюу нэг нутаг усны бэлчээрээ хамтран ашигладаг малчин өрхүүд газар нутгийн онцлог, бэлчээрийн нөхцөл байдлаасаа хамаарч 20-оос доошгүй өрх нэгдэж малчин өрхийн анхдагч холбоог байгуулахаар төсөлд тусгасан. Анхдагч холбоо нь гишүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн үйлчилгээг үзүүлэх, байгалийн нөөц, гэрээт бэлчээрийн газрыг зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх гэсэн 4 үндсэн үйл ажиллагаанд гишүүн малчин өрхүүдийг зохион байгуулж оролцохоор тусгасан.

Малчдын сайн дурын энэ холбоо нь ашигийн бус бөгөөд зөвхөн хөдөлмөрөө хорших замаар мал аж ахуйн үйлдвэрлэлийн суурь болсон бэлчээр нутгаа хамгаалах, нөхөн сэргээх, өвөлжилтийн бэлтгэл болон цаг үеийн ажлуудыг хамтын хүчээр зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх юм.

Мөн мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, ашигийн төлөө үйл ажиллагааг нь малчдын өөрсдийнх нь үүсгэн байгуулсан хоршоо, аж ахуйн байгууллагаар нь гүйцэтгүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм. Өөрөөр хэлбэл анхдагч холбоо нь гишүүдийнхээ мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хоршоо, ААН, Хөдөө аж

ахуйн бирж зэргээр борлуулахад зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж, хоршоог хөгжүүлэх хөшүүрэг, түлхэц болохоос гадна малчдын орлогыг нэмэгдүүлэх ач холбогдолтой гэж үзэж байна.

Малчин өрхийн анхдагч холбоо нь суурь нэгж болохын хувьд бүх гишүүдийн хурал түүний чөлөөт цагт тэргүүлэгчид, ахлагч гэсэн удирдлагын бүтэцтэй байх бөгөөд эдгээр институцийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, эрх, үүрэг, түүнчлэн гишүүнчлэлийн талаар төсөлд тусгайлан зохицуулсан.

Бэлчээрийг сумын Засаг даргатай байгуулсан гэрээний үндсэн дээр хуваарьтай ашиглаж, доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалах ажлыг анхдагч холбоо хариуцахаар төсөлд тусгалаа. Сум, аймгийн болон малчин өрхийн нэгдсэн холбоо, доод шатын холбоодын үйл ажиллагааг уялдуулан зохион байгуулалтаар хангах, төрийн бодлого, тухайн шатын бодлогын баримт бичиг, үйл ажиллагаанд малчин өрх холбооны эрх ашиг сонирхлыг илэрхийлэх, саналаа өгөх нийтлэг чиг үүрэг хүлээж байна.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөлтэй хамт Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай зэрэг 12 хууль, Улсын Их Хурлын 2 тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахаар төслүүдийг боловсруулсан.

Та бүхэнд хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн дэлгэрэнгүй танилцуулгыг хүргүүлсэн байгаа.

Хуулийн төслийн талаар 2024 оны 01 дүгээр сард салбарын судлаач, эрдэмтэд, ТББ-ын төлөөлөл, холбогдох мэргэжлийн болон төрийн байгууллагын

төлөөллийг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Түүнээс гадна хуулийн төслийг санаачилсан гишүүд орон нутагт ажиглахдаа малчид, иргэдэд танилцуулж, санал бодлыг нь сонсож, хуулийн төсөлд тусгасан.

Эрхэм гишүүд ээ, Орон нутагт цаг, зудын нэн хүндрэлтэй байгаа өнөөгийн нөхцөл байдал, манай улсын ХАА, түүний дотор амиа аргацаах төдий мал аж ахуйн салбарт бодлого, тогтолцооны шинэчлэл зайлиггүй чухал байгааг батлан харуулж байна. Байгалийн бэрхшээл тулгарсны дараа араас нь арга хэмжээ авах бус малчдын өөрсдийн оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан бэлчээрээ хамгаалах, нөхөн сэргээх, малын ашиг шим, үнэ цэнийг өсгөх, өвлийн бэлтгэлээ хамтын хүчээр сайтар хангадаг байх, малчдыг мэргэшүүлэх, сайн туршлагыг сурталчлах зэрэг чиглэлээр бодлогын арга хэмжээ авах шаардлага тулгараад байна. Эдгээр болон бусад асуудлыг шийдвэрлэх суурь гарц шийдэл нь Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай болон хамт өргөн мэдүүлсэн бусад хууль тогтоомжийн төсөлд туссан гэж үзэж байна.

Малчин, мал, бэлчээр 3-ын харилцан шүтэлцээг хангаж, нүүдлийн соёл, иргэнилийн дархлааг хамгаалж, өвийг ийнхүү хадгалснаар Монгол Улсын тусгаар тогтнол, хүнсний аюулгүй байдал, иргэдийн эрүүл мэндийг хамгаалахаас гадна газрын харилцааны шинэчлэл хоршоог хөгжүүлэх суурь ач холбогдолтой юм.

Иймд Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг та бүгдээсээ хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа, Батжаргал гишүүнд. Хууль санаачлагчид.

Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Гомпилдоогийн Мөнхцэцэг танилцуулна.

Мөнхцэцэг гишүүн танилцуулахын өмнө нэг зүйл зарлан мэдээлье. Монгол Улсад зүүний чиглэлийн залуучуудын байгууллага үүсгэн байгуулагдсаны түүхт 27 жилийн ойн баярын мэндчилгээг үе үеийн Ерөнхийлөгч, дэд ерөнхийлөгч, Удирдах зөвлөлийн гишүүд, Улсын Их Хурлын гишүүд, салбар зөвлөлийн дарга нар нийт манлайлагч нартаа хүргэе. Нэгэн зорилгын дор нэгдэж, улс эх орныхоо төлөө үг үйлдлээрээ цэгцэрсэн ахан дүүс, анд найзуудаараа бахархаж байна. Монголын залуусын зүрхэнд, тархинд Монгол эх орны маргаашийн хувь заяа зураастай. Залуучуудын байгууллагын төлөөлөл нийт Улсын Их Хурлын гишүүддээ бас баярын мэндийг өргөн дэвшүүлье. Учрал, Эрдэнэбат манай Ерөнхийлөгч нар Тэмүүлэн, Булгантуяа нарыг.

Одоо Гомпилдоогийн Мөнхцэцэг гишүүнийг индэрт урьж байна.

Г.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал нарын 38 гишүүнээс 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төсөлд малчдыг хөдөлмөрөө хорших, хамтын үйлчлэл санаачилгын байгууллага болох, малчин өрхийн холбооны эрх зүйн байдлыг зохицуулсан бөгөөд бэлчээрийн нөхцөл байдлаас хамаарч 20-оос доошгүй малчин өрх нийлж холбоо байгуулах, анхдагч

холбоо нь гишүүдийнхээ боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, төрийн мэдээллийн үйлчилгээг хүргэх, малын эрүүл мэнд, үржил, чанар, ашиг шимийг дээшлүүлэх, байгалийн нөөц, гэрээт бэлчээрийг газрын зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг бэлтгэх, борлуулахад дэмжлэг үзүүлэх, бэлчээрийн доройтлоос сэргийлэх, сайжруулах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар хууль санаачлагчдад уг хуулийн төслийг боловсруулсан байна.

Дээрх хуулийн төслийг иргэдийн оролцоог хангах, санал авах зорилгоор Улсын Их Хурлын *d-parliament.mn* цахим сайтад байршуулж, иргэд олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцүүлэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал малчдыг нэгдсэн байдлаар удирдан зохион байгуулж холбоо байгуулах боломжтой эсэх, холбоонд нэгдэн ороогүй малчин өрхийн эрх зүйн байдлыг төсөлд тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн О.Цогтгэрэл Малчин өрхийн холбоо нь ХАА-н хоршоо нэгдлээс онцлог, ялгаатай эсэх, өмнөх нэгдэл хоршоодын үйл ажиллагааны талаар амжилтад хүрээгүй суурь шалтгаанд нь дүгнэлт хийсэн эсэх, малчин өрхийн холбоо байгуулагдсанаар тэдэнд хүртэх эдийн засгийн ач холбогдлыг тооцсон эсэх талаар асуулт асууж, хариулт авсан болно.

Түүнчлэн хуулийн төслийн хэлэлцэх үеэр Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн энэ хаврын чуулганаар мал аж ахуйн салбарын өнгөрсөн 20 жилийн хугацаанд үүссэн тогтолцоо, бодлого, засаглалын байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, бодлогын болон хандлагын өөрчлөлт хийх, малчид үйл ажиллагаагаараа хоршин хамтрах, суурь харилцаа бий болгох, ингэснээрээ байгаль орчинд ээлтэй, бүтээмжтэй,

эрсдэлгүй мал аж ахуйг хөгжүүлэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Мөнхцэцэг энэ хуулийн төсөл нь малчдад тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэх, малчдаас гарсан санал, санаачилгаас үүдэн төрөөс зохицуулалт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал хуулийн төслийн зарим зохицуулалт нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хуулиудтай давхардаж байгаа, төрөөс батлан гаргаж байгаа бодлогын баримт бичигтэй уялдсан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хуулийн төсөлд малчид сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж холбоо байгуулах, төрийн бодлогыг хүргэх, малчдын хамтын менежментийг төлөвшүүлж нийтлэг эрх ашгийг хамгаалах, байгалийн нөөц, бэлчээрийг даацад тохируулан зохистой ашиглах зэрэг харилцааг тусгасан эсэх, Улсын Их Хурлын гишүүн Цэрэнпунцаг малчин өрхийн холбоо байгуулагдсанаараа малчдын хоорондын уялдаа холбоо сайжирч, хяналтын үйл ажиллагаа тодорхой болох, өөрсдийн асуудлыг анхдагч холбоогоороо дамжуулан шийдвэрлэх, төрд уламжлах зэрэг асуудлыг шийдвэрлэхээр хуулийн төслийг санаачилсан гэдгийг дурдлаа.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хуулийн төслийн үзэл санаа, ган зудын нөхцөл бэрхшээлтэй уламжлалт болон фермерийн үйл ажиллагааг эрхэлж байгаа малчин өрхүүдэд туслах хууль, эрх зүйн орчныг тодорхой болгоход чиглэж малчин өрхүүдэд сүргийн бүтцээ зөв зохион байгуулдаг, мал сүргийн сэг зэмийг устгадаг, бэлчээрээ хамгаалдаг байх үүрэг хариуцлагыг тодорхой болгож, үүнээс хамаарч хөнгөлөлттэй зээл тусламжид хамруулах, татварын хөнгөлөлт үзүүлэх зэрэг зохицуулалтыг төсөл тусгаж байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал хуулийн төслийг боловсруулах нийгмийн зайлшгүй шаардлага тулгараад буйг дурдаад, малчдын хамтын менежментийг

төлөвшүүлэх, эрх ашгийг хамгаалах, мал аж ахуйн байгаль орчин, бэлчээрийн даацад нийцүүлэн хөгжүүлэхэд чиглэгдэж байгаа бөгөөд хэлэлцүүлгийн шатад хуулийн төслийг олон талаас нь ярилцаж илүү сайжруулах боломжтой талаар тус тус санал хэлсэн болно.

Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 66,7 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо, толгойн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хориоодын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Амьтны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Байгаль хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээсээ хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу. Тасаллаа. Сарангэрэл гишүүнээр тасаллаа.

Ажлын хэсгийг танилцуулъя.

Данзангийн Лүндээжанцан Улсын Их Хурлын даргын ахлах зөвлөх, Мягмарсүрэнгийн Алтанбагана ШУА-ийн Газар зүй, геоэкологийн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, Бадарчийн Мяхдадаг Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн зөвлөх, Санжспэрлээгийн Энхцэцэг Улсын Их Хурлын Тамгын газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн асуулт асууна. Эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнийг урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Энэ хуулийн төслийг санаачлагчдын нэг байгаа юм. Өмнө нь 2009 онд “Монгол мал” хөтөлбөр малчдын талаар төрөөс баримтлах бодлого гэдэг ийм 2 том бичиг баримт гарсан, бодлого гарсан. Тэгээд энэ 15 жилийн хугацаанд энэ бодлогууд маань тодорхой хэмжээнд үүргээ гүйцэтгэсэн. Цаг хугацааны хувьд ч дуусгавар болж байгаа. Тийм учраас бол ер нь энэ мал аж ахуйн салбар энэ уламжлалт нүүдлийн соёл, иргэнишл, энэ өв соёлоо тээж байгаа, дараа үедээ өвлүүлж байгаа, энэ улс орны оршихуйн дархлаа, баталгаа болсон энэ салбар луугаа яах юм бэ, эдийн засгийн том салбар гэдэг нь ойлгомжтой. Нэг цогц бодлого гаргах ёстой. Энэ гаргах цогц бодлогын хүрээнд өнөөдрийн бидний санаачилсан энэ хууль, мөн бас Улсын Их Хурлын гишүүдийн санаачилсан бид боловсруулж байгаа Малчны тухай хууль, Засгийн газраас Их Хурлаас дэвшигдэж байгаа энэ бодлого зорилтууд нэг болно. Тэгэхдээ өмнө нь батлагдсан энэ хууль бодлогуудын хэрэгжилт, тэнд гарсан алдаа дутагдал, зарим дэвшүүлсэн

зорилтууд хэрэгжээгүй байгаа учир шалтгаан энд бүхэлд нь цогц ийм мониторинг шинжилгээ хийж байгаа гэж ингээж ойлгож байгаа.

Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Хамгийн гол нь би эхний ээлжид өнөөдөр энэ байгалийн гамшигт үзэгдэлд гамшигт нэрвэгдчихсэн байгаа энэ малчин түмний хойшлуулишгүй авч хэрэгжүүлэх энэ арга хэмжээнүүд ерөөсөө л тодорхой 4 асуудал байгаа.

1 дүгээрт, бол саяын ярьдаг энэ цом цогц бодлогын шинэчлэл хийх асуудал тавигдаж байгаа. Одоо тулгамдчихаад байгаа юм бол ерөөсөө л зээл. Энэ амьжиргааныхаа эх үүсвэрээс салсан энэ малчдын амьжиргааг яаж дэмжих юм бэ. Малжуулах, дээрээс нь энэ орлого, ажлын байрыг энийг нь цогцоор нь шийдэхгүй бол хөдөө ямар байдалтай байна вэ гэхээр хүмүүс арга байхгүй шүү дээ. Малаа барчихсан энэ хүмүүс төв суурин бараадаж байна. Замд портёр дээр гэрээ аччихсан явж байгаа малчид, залуучууд зөндөө таарч байна. Гаднаа мал байхгүй гэрээ зүгээр тэр чигээр нь хаячхаад ингээд эзгүй байгаа айл өрхүүд зөндөө байна шүү дээ. Тийм учраас бол яг энэ тулгамдсан асуудал дээр бид нар анхаарлаа тавих хэрэгтэй байна.

Эргээд энэ хуулийн төсөл рүүгээ би эргээд оръё. Одоо бол бидэнд хамгийн их тулгамдаж байгаа олон жил яриад шийдэж чадахгүй байгаа юм бол энэ малчдын залуу халаа яаж бэлдэх юм бэ? Энэ чинь малчин удам тасрах гээд байна шүү дээ. Энэ бол олон хүчин зүйлээс шалтгаалж байгаа. Мэдээж суурьшил, дээр нь шинжлэх ухаан, техник, технологийн дэвшил, хөгжил, дээр нь энэ юу байна, олон хүчин зүйл, хэрэглээ байдал, энэ зах зээлийн нийгэм, олон хүчин зүйлүүд шалтгаалж байгаа учраас энэ төв суурин газар луу шилжих шилжилт хөдөлгөөн их байна.

Манай боловсролын тогтолцоонд байна. Үндсэндээ бол ерөөсөө малчин өрхүүд ээж нь юм уу голцуу л ээж нь байна даа. Төв суурин хүүхдээ аваад бараадчихсан. Ингээд гадаа юу гэрт мал дээр хэн үлдэж байна. Өрхийн тэргүүн үлдэж байгаа ийм нөхцөл байна. Яагаад энэ багийн бага сургуулийг байгуулах, багийн бага сургуулиар боловсрол олж аваагүй гэж хэн хэлээд байгаа юм бэ? Бид нарын энд түүхэнд чинь багийн бага сургуулийг төгссөн шинжлэх ухааны, соёл урлагийн энэ нийгмийн чинь манлайлагч олон хүмүүс төрж гарсан шүү дээ. Энэ дээр бүр нэг онцгой анхаарал тавих хэрэгтэй байна. Энэ бодлого чиглэл ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хууль санаачлагч бөгөөд Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Жигжидийн Батжаргал гишүүн асуултад хариулна.

Ж.Батжаргал: Баярлалаа. Бат-Эрдэнэ гишүүний асуулт дотор 2 зүйл л хөндөгдөж байна л даа. Байгалийн гамшиг энэ давагдашгүй хүчин зүйлийн улмаас хүндрэл амсчихсан энэ малчдын асуудлыг яах вэ гэдэг асуудал яригдаж байна. Улсын Их Хурлын Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо энэ асуудлуудыг авч хэлэлцэж, тов тодорхой тогтоол шийдвэр гаргаж, Засгийн газартаа чиглэл өгөөд, энэ дагуу Засгийн газар, онцгой комиссууд ажиллаад үндсэндээ гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэл дээр бас тодорхой арга хэмжээнүүд аваад ингээд ажилласан гэж ингээж ойлгож байгаа.

Сая Засгийн газраас бас тодорхой чиглэлүүд гарсан. Малчдын зээлийг тодорхой хугацаагаар хойшлуулах, хойшлуулж байгаатай холбогдоод бий болж байгаа зээлийн хүүг төрөөс тодорхой хэсгийг нь даах тухай шийдэл. Ер нь малгүй болж байгаа гэдэг юм уу, малаа их хэмжээгээр хорогдуулчихсан өрхүүдийг малжуулах хөтөлбөрт хамруулах асуудлыг хөдөлмөр эрхлэлтийг

дэмжих чиглэлээр батлагдсан төсөв хөрөнгөдөө багтааж асуудлыг зохицуулах эхний явцын арга хэмжээний чиглэлээр тодорхой чиглэл гарсан.

Мэдээж аливаа гамшиг нөхцөл байдал тодорхой хугацаагаар тасалбар болгож, тов тодорхой дүн мэдээгээ гаргаж ирээд, тэр дүн мэдээн дээрээ тулгуурлаж гамшигийн хохирлыг арилгах, сэргээн босгох арга хэмжээгээ авч хэрэгжүүлдэг ийм жамтай. Малын хорогдол одоогоор хараахан зогсоогүй байна. Цас дөнгөж хайлж, цоохортож байна. Ногоо амсаад гэдэг юм уу үнэрлээд мал нэлээн өөрөө доройтдог. Тийм учраас энэ бүх нөхцөл байдлаа харгалзаж, тодорхой хугацаагаар тасалбар болгож, бүх дүн мэдээгээ тооцож үзээд энэ дээрээ тулгуурласан тов тодорхой арга хэмжээ авна. Энэ чиглэлээр авч хэрэгжүүлэх гээд байгаа арга хэмжээнийхээ талаар бас Засгийн газраас тодорхой саналуудыг танилцуулсан. Энэ хуулийн төсөл өргөн баригдаж орж ирнэ гэж би ингээж ойлгож байгаа. Үүгээр дамжуулж энэ холбогдох яригдаж байгаа асуудлуудыг зөв шийдлийг нь олох тал дээр хамтдаа ажиллах болно гэдгийг танд хэлмээр байна.

Энэ бэлчээрийн мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх тухай асуудал бидэнд чухал зүйл байгаад байгаа юм. Нэн тэргүүн ээлжид ерөөсөө энэ малчдын залуу халааг бэлтгэх тухай асуудал байна. Малчдаа өөрийг нь чадваржуулах тухай асуудал байна. Малчдаа хариуцлагажуулах тухай асуудал байна. Тийм учраас энэ хуулийн төсөл дотор тэр малчдынхаа мэдлэг боловсролыг дээшлүүлэх, харилцан ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг тодруулах уу? 4. Данзангийн Лүндээжанцан Улсын Их Хурлын даргын зөвлөх.

Д.Лүндээжанцан: Өглөөний мэнд дэвшүүлье. Тэгэхээр малчин өрхийн

анхдагч холбоо эхний ээлжид малчдаа анхаарч, тэднийгээ зохион байгуулж, хамтын өөрсдийнх нь засаглал аравтын тогтолцоо маягийн одоо бид 20 өрх гэдгээр тоог нь аваад явж байгаа. Энэ хэлэлцүүлгийн явцад байгаль, цаг уурын онцлог бүх юмнаас шалтгаалах байх гэж ингэж бодож байгаа юм. Тэгэхээр анхдагч холбоо нь малчин өрхийн гишүүнийг боловсрол, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулах, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, тэдгээрт төрийн мэдээллийг хүргэх. Тэр дотроо болохоор малчин өрхийн гишүүний албан болон албан бус сургалтад хамруулах гэж ийм заалт ороод, дагаж гарах Боловсролын ерөнхий хууль дээр болохоор насан туршийн боловсрол гэдгийн үед хамтран ажиллах арга хэмжээ гэснийг малчин өрхийн анхдагч холбоотой хамтран ажиллах малчин өрхийн гишүүнийг насан туршийн суралцахуйн сургалтад хамруулах гэж. Өнөөдөр энэ онлайн зөвхөн энэ дижитал шилжилтийг төв суурин газар гэж ойлгохгүй. Нийт улс даяараа энэ дижитал шилжилтэд шилжинэ. Ийм учраас манай малчид гэрээсээ, сүргийнхээ бэлчээр дээрээс насан туршийн суралцахуйн арга ухаанд хамтарч ажиллах шаардлага байна.

Залуу малчдыг мэргэшүүлэх чиглэлээр аймгийн төв дээрээ сургалт зохион байгуулах ажил ч байна. Дээр нь нэг хэсгийг нь эчнээгээр тэр малчны энэ мэргэжил юм, мэргэшил юм нарийн, энэ чиглэл рүү нь явуулахад чиглэгдсэн энэ заалт орж өгч байгаа ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн асуулт асууна. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн тодруулж асууна, 1 минут.

Б.Бат-Эрдэнэ: Тэгэхээр энэ хуульд бол бид бас олон жил ярьж байгаа, ерөөсөө Монголчуудын хүчирхэг байсны нууц аравтын тогтолцоондоо байжээ гэж энэ Монгол судлаач олон улсын

эрдэмтэд нэг дуугаар хүлээн зөвшөөрсөн байдаг. Тэгээд энэ асуудлыг олон жил тавиад төдийлөн дэмжлэг авахгүй. Тэгээд Баян-Овоо сумын Засаг дарга Баянмөнхийг орон нутагтаа очиж ажиллахад нь санал хэлсэн. Тэгээд би маш богино хугацаанд сумаа аравтын тогтолцоонд оруулаад, сум нь улсын тэргүүний сум болоод олон газраас хүмүүс очиж туршилагыг нь судалдаг. Өөрөө улс орон даяар урилгаар явж ингэж сургагч багшаар ажилладаг.

Их Хурлын дарга бүр зориуд энэ ажлын хэсэг дээр оролцуулж ингэж ажилласан. Энэ тогтолцоо орсон нь бол маш сайн зүйл ээ. Энэ өвлийн хүндрэлийг харьцангуй бага хохиролтойгоор давахад бол тэр тогтолцоо үнэхээр үр дүнд хүрч байна гэж ингэж үзэж байгаа. Тийм учраас ... /минут дуусав/

Г.Занданшатар: Данзангийн Лүндээжанцан дарга хариулна.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр энэ би энэ Хэнтий аймгийн Баян-Овоо сумын аравтын тогтолцоо, дээр нь энийг гардан зохион байгуулсан гавьяат эдийн засагч Баянмөнх агсанд бас энийг дурсах, дурсаж байна. Харамсалтай нь манай энэ хүн тэнгэрт хальсан байгаа. Ер нь энэ тогтолцоогоор эхлээд тийм амаргүй. Энэ сайн дурын үндсэн дээр ашигийн бус тогтолцоо, малчдын өөрийнх нь засаглал. Тэгээд ахлагч гээд тэр 20 айл ч байдаг юм уу хүмүүс ингээд байнга л малчин өрхийн холбооныхоо гишүүдтэй байнга ажиллана. Танайх тэдний өдөр танайх тарилга туулгалтад орно шүү. Малын дархлаажуулалтад хэдэн өдөр орно шүү. Малын халдваргүйтлийн арга хэмжээг ингэж зохион байгуулна шүү. Сэг зэмийг ингэж устгана шүү. Малын хулгай, гэмт хэргээс сэргийлэхийн тулд өдөр болгон нэг айл ээлжилж мотоциклоо унаад байдаг юм уу, приусээ бариад байдаг юм уу, ингээд эргүүлд гарна шүү. Малын гарал үүслийг ингэж тодорхойлно шүү гээд анхан шатдаа багийн засаг дарга

нартайгаа хамтраад, бусад холбоотойгоо хамтраад тэгээд ялангуяа өвөлжилтийн бэлтгэлийг хангах, мөн өвс хадлангийн хуваарьт талбайд тэнд зохион байгуулахад ганц ганцаараа биш бас нэгдээд нэг очоод, мөн тухайн сумд ажиллаж байгаа хоршоонуудад түүхий эдээ анхан шатын боловсруулалт хийгээд ингээд өгнө шүү. Тэр хөдөө аж ахуйн бирж хамгийн гайгүй үнэтэй учраас ингэнэ шүү. Мөн хөдөө сумын ЭМТ-тэй тодорхой гэрээний ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Манай улсад энэ сүүлийн 10 гаруй жилийн хугацаанд яах аргагүй энэ бэлчээр, бэлчээрийн даацын асуудал бол нэн тулгамдаад байгаа асуудал боллоо. Миний бие энэ малчид хамтын зохион байгуулалтад орох энэ бэлчээрийн даацад тохируулаад 15 жилийн хугацаагаар ашиглах энэ хууль, эрх зүйн орчныг дэмжиж байгаа юм, бүрдүүлэх ёс. Тэгэхээр энэ хуулийн төсөлд ер нь мал аж ахуй эрхэлж байгаа мал, түүний ашиг шимийг хүртэж байгаа малчид байхыг бол чухалчилж оруулж өгсөн байж байгаа. Өнөөдөр улсын хэмжээнд 70 гаруй сая мал бүхий эргэлтийн хөрөнгөтэй 300-аад мянган малчин өрх байна гэж ойлгож байгаа. Тэгэхээр бүгдээрээ ер нь яг адилхан малчин өрх. Гэтэл энд бол яг энэ газар тариалангийн бүс нутагт малаа эрчимжүүлж байгаа, нэн ялангуяа эрчимжсэн МАА эрхэлж байгаа хүмүүсийн малчдын эрх ашиг бол энд орхигдож байна гэж харагдаж байна, энэ хууль дээр. Тэгэхээр тухайлах юм бол Сэлэнгэ аймгийн Мандал сумыг аваад үзэхэд тэнд бол нэлээн суурин бүтэцтэй, нэлээн эрчимжсэн тал руугаа хөгжүүлэлт хийх боломж бүхий ийм аж ахуйн зохицуулалттай сумууд нэлээдгүй байж байгаа. Тэгэхээр энэ дээр бол нэн ялангуяа энэ бэлчээрийн мал аж ахуйг бүхэлд нь зохицуулж байгаатай адилхан малчдын энэ бэлчээрийн эрчимжсэн мал

аж ахуйн газрын асуудлыг хуулийн төсөлд тусгайлан тусгаж өгөх нэн шаардлагатай гэж харагдаж байгаа юм.

Дараагийн нэг асуудал бол энэ ногоон тэжээлийн бас л ахиад л газрын асуудал байж байгаа. Тэгээд энэ ер нь хуулийн төсөлд 4 үндсэн чиглэлээр зохицуулалтыг хангахаар байгаа. Тэр дундаа энэ малын эрүүл мэнд, үржил чанар, ашиг шимийг дээшлүүлэх тал дээр бол нэлээдгүй асуудлыг зохицуулж байгаа гэж харж байгаа. Энэ асуудлыг зохицуулаа гээд тэгэх юм бол яалт ч үгүй нийт зардлын 20-30 хувь нь тэжээлд, ногоон тэжээлд зарцуулагддаг. Энэ бол маш том дарамт байгаа. Гэтэл энэ бол шууд газрын асуудлаас шууд хамааралтай асуудал байдаг. Тэгэхээр энэ бэлчээрийн газрыг миний ойлгож байгаагаар энэ хуулийн төсөл дээр бол Засаг даргаатайгаа тодорхой хэмжээний гэрээ байгуулаад, орон нутгийн бэлчээрийн даацын нөхцөл байдлаас шалтгаалаад, тэгээд энэ үүргийн биелэлтэд нь хяналт тавьж явах байдлаар зохицуулалт хийсэн болов чиг зориулалт нь тодорхойгүй байна. Үүнийг би энэ хуулиас олж үзсэнгүй. Тухайлах юм бол ногоон тэжээлийн ч байдаг юм уу, хадлангийн ч байдаг юм уу тийм ээ, энэ бэлчээрийн гээд энэ зориулалтуудыг нь бол тодорхой түвшиндээ бол бас задалж ойлгомжтой хэлбэрээр зохион байгуулалтад оруулах тал дээр бол энэ ажлын хэсэг цаашидаа анхаарч ажиллах нь бас зүйтэй байх гэж бодож байна. Тэгээд энэ тал дээр бас хариулт авмаар байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн, хууль санаачлагч.

Ж.Батжаргал: Өнөрболор гишүүний асуултад хариулъя. Эрчимжсэн МАА эрхлэгч нар малчин гэдэг ангиллаараа энэ хуулийнхаа зохицуулалт дотор ороод явж байгаа. Ганц нэг тодруулах зүйлүүд байхыг үгүйсгэхгүй. Түүнийг нь хэлэлцүүлгийн түвшинд

тодруулчих нь зүйтэй гэж би ингээж ойлгож байна.

Малын тэжээлийн ургамлын тариалалтыг бид их зөв бодож харах ёстой юм. Уг нь энэ таримал ургамлууд өөрийн ургадаг тэр орчин, хөрс, бүтэц бүх юм нь байх ёстой. Түүнийг нь тогтоосон тэр ангиллын талбай дээрээ явдаг ийм жамтай. Гэхдээ бид нарын амьдралын үйл явцаас харахаар зэрэг энэ малын өтөг бууц малынхаа хөлөөр газрынхаа хивгийг дагаад тогтчихож байгаа тэр үүсмэл хөрс буюу бууцны хөлд ногоон тэжээл тариад авч болж байна. Үүнийг нэлээн өргөн хүрээтэй хийх ёстой юм гэж.

2 дахь зүйл нь тэр малын тэжээл тарих гээд байгаа асуудал нь яг тэр тариалангийн газрын ангилалдаа байж байгаа газраасаа авах ёстой юм. Үүнийг нь дагуулаад энэ хууль дотор Газрын хууль дотор нь тусгаад оруулаад өгчихсөн ийм явж байгаа. Энэ хуулиар бүх асуудлыг зохицуулж болохгүй байгаад байгаа. Өнөө тавигдаж байгаа асуудлыг зохицуулж байгаа суурь хуульд нь асуудлыг шийдэх замаар хийж байгаа. Тийм учраас дагуулж өргөн барьсан хуулиудаар зохицуулж байгаа харилцаанууд байгаа.

Энэ Лүндээ дарга энэ тэр гээд энэ ланжгар хуульч нар бас бид нарыг хамаагүй зоргоороо ажиллуулахгүй байгаа. Энэ хуулийн техник, хэллэг, нэршил гэж юм байна. Монголын эрх зүйн салбарын хүрсэн түвшин соёл гэж юм байна. Та хэдийг тэгж бас ч нэг их дур зоргоор чинь энэ хил, заагийг муруй, хазгай дагуулж гишгүүлэхгүй шүү. Бид бас энэ хууль зүйн талынхаа асуудлыг барьж нийцлийг нь хангаж асуудлаа шийднэ гээд. Тэгээд бид хэд нэлээн олон хуульд гар хүрч, ярьж байсан асуудлуудаа цогцоор нь шийдэх гэж энэ дагуулж асуудал өргөн барьсан гэдгийг зориуд хэлмээр байна.

Г.Занданшатар:

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн тодруулж асууна.

Д.Өнөрболор:

Би үндсэндээ Батжаргал даргын тайлбарыг бас ойлгож байна. Гэхдээ бид нар өнөөдөр яг хөрсөн дээрээ буух хэрэгтэй байна. Энэ хууль, эрх зүйн орчин чинь. Өөрөөр хэлэх юм бол малчдын ерөөсөө л тийм ээ, гол асуудал бид нар юун дээр төр дэмжлэг үзүүлэх гээд байгаа вэ гээд тэгэхээр энэ үүлдэр угсааг нь сайжруулъя, ашиг шимийг нь нэмэгдүүлье, зөв менежментээр хангая гэдэг асуудал дээр л төр бодлогоор зохицуулалт хийх гэж байгаа гэж. Малчдад бол ерөөсөө яг энэ чиглэлээр хөгжүүлэлтээ хийгээд, өнөөдөр баян чинээлэг малчин болъё гэж хүсэх юм бол өнөөдөр 4 асуудал байгаад байгаа юм. Тэрний 2 асуудал нь ерөөсөө л энэ газартай холбоотой асуудал байгаад байгаа байхгүй юу. Өөрөөр хэлэх юм бол газраа энэ бэлчээрийн энэ даацтай холбогдуулаад бас тодорхой хэмжээний асуудал шийдэгдэж байгаа юм. Нэн ялангуяа эрчимжсэн мал аж ахуйг эрхэлж байгаа малчдад энэ газрын асуудлыг шийдэх, дээрээс нь ногоон тэжээлийн энэ газрын ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Жигжидийн Батжаргал гишүүн хууль санаачлагч хариулъя.

Ж.Батжаргал:

Тийм ээ, ойлгож байна. Энэ хуулийн төсөлд наад асуудлууд чинь орсон. Тодотгох шаардлагууд байна гэвэл хэдүүлээ хэлэлцүүлгийн явцад нь тодотгоно. Яах аргагүй энэ бэлчээрийн мал аж ахуйг байгалийн эрсдэлээс хамгаалах, энэ өндөр ашиг шимтэй малын ашиг шимийг бүрэн гүйцэд хүртэхэд тэжээл нэн чухал. Тийм учраас энэ рүү бид гол анхаарал төвлөрч байгаа. Тийм ч учраас нэлээн хэдэн заалтаар хөндөж холбогдох хуулиудад нь тов тодорхой оруулсан. Тэгээд мэдээж энэ хуулиар бүх асуудлыг зохицуулахгүй, ойлгомжтой. Орон нутгийн хэрэгцээ, шаардлага бүх

юман дээрээ тулгуурлаж авч хэрэгжүүлэх арга хэмжээнийхээ жил, жилийн хөгжлийн төлөвлөгөө, менежментээрээ бас бодлого зорилтууд нь зохицуулагдаж явна. Тэрийг зохицуулахад л эрх зүйн чөдөргүй л байх ёстой. Бүх юмыг нь нээж өгсөн л байх ёстой. Үүнийг нь л энэ хуулиар бүрэн хийж өгсөн гэдгийг хэлмээр байна.

Г.Занданшатар: Данзангийн Лүндээжанцан зөвлөх, ахлах зөвлөх. Их хурлын даргын ахлах зөвлөх, 4 номер.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр энэ Хэнтий аймгийн Цэнхэр мандал сумын туршлага байна. Тэнд байгуулагдсан малчдын нөхөрлөл, хоршоо, холбооны хүмүүс нэгдээд газар тариалан эрхэлж байсан газраас хаягдсан, атаршсан хэсгийн энд гэрээ хийж, зөвшөөрөл аваад тэжээлийн ургамал тариалсан. Энэ нь жил ирэх тусам нэмэгдээд тэндээ техник технологийн хувьд бас өөрчлөлт хийгээд, ашиг орлого нь нэмэгдээд, бас малчдаа тэжээлээр хангах, ногоон тэжээлээр хангах нөхцөл бас бүрдээд явж байгаа. Энэ мэтчилнээр энэ малчин холбооны өрхийн холбооны газар бэлчээр нутаг дээр тариа тарих арга юу тэжээлийн ургамал тариалах арга байхгүй. Энэ тариалангийнхаа хуулиар зохицуулагдана.

Ногоон тэжээл болон бусад ургамал тариалах асуудлыг тариалангийн хуулиар зохицуулна. Тэр тариалангийн хууль дотор нь харин Өнөрболор гишүүний яриад байгаа үүнийг өргөжүүлж өгөх, нөхцөлийг нь хангаж өгөх энэ асуудлыг анхдугаар хэлэлцүүлгийн явцад нэмж ярьж болох юм. Тэрнээс биш Монгол орон даяар бэлчээртэй болохгүй. Харин сая Батжаргал даргын хэлсэн тэр өвөлжөө, хаваржааны орчин газар дахь малын бууцтай холилдсон үүсмэл хөрсөнд тэжээлийн ургамал, энэ тариалаад нийтдээ Дундговь аймагт тэр бууцныхаа хөлд тарьсан ногоон тэжээл нэг портёр тэжээл авч байгаа байхгүй юу. Энийг

саяхан энэ чиглэлийн эрдэмтэн судалгаагаа хийгээд биччихсэн байна. Тэгэхээр говьд өөрийнхөө бууц дээр ингэж байгаа юм чинь нэгдэж нийлээд хамтарсан хоршоо, дундын хоршоогоороо дамжуулаад тэр газар нь очоод тариад, бусдадаа хуваарилаад, ингэхэд тэжээл хамаагүй хямд өртгөөр энэ малаа эрсдэлээс ... /минут дуусав/

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн асуулт асууя.

Н.Ганибал: Малчин өрхийн эрх зүйн байдлын тухай хууль гээд яах вэ, зүгээр хууль оруулж ирээд хэлэлцүүлж байгаа нь бас сайн хэрэг. Яг энэ хууль дээр ямар асуудлыг шийдэх гээд байгаа юм бэ? Өнөөдөр яг Монголын малчдын өмнө энэ өвөл маш хүнд болдог боллоо. Жил дараалсан ийм үйл ажиллагаанууд цаг агаарын нөхцөл байдлууд харагдаж байна. Энэнээс бид нар яаж гарах юм. Одоо байгаа болчихсон байгаа энэ гаммигаасаа бид нар яаж гарах юм бэ? Энэ асуудал дээр АН-ын бүлгийн зүгээс гишүүдийн зүгээс тодорхой Улсын Их Хурлын тогтоолын төсөл бас дагалдаад бас хуулийн төслүүд өргөн барих гээд чадахгүй байна. Өнөөдрийг хүртэл дарга маань хүлээж авахгүй байгаа. Өчигдөр болж байгаа процессыг харахад Үндэсний баялгийн сангийн тухай хууль Засгийн газраас оруулж өгсөн хууль I хоногийн өмнө өргөн бариад маргааш нь хэлэлцдэг. АН-ын бүлгийн гишүүдийн өргөн барьсан хууль 4 сарын өмнө өргөн барьчхаад, хэлэлцэх асуудалд ордоггүй. Энэ чинь парламент дотроо ийм дарангуйлал тогтоод байгаа юм уу, хаашаа юм бэ, энэ чинь. Үнэхээр энэ Монгол Улсын парламентын засаглалтай улс орон энэ дэгийнхээ дагуу процессуудаа яриад хэлэлцээд шийдлээ олоод явмаар байна. Тэрнээс ямар, бид ер нь ард түмнээс сонгогдсон гишүүд шүү. Тэрийгээ бас хэлчихье. Бидэнд бас хамгаалагдсан эрх байгаа байх. Энэ хурлын дэгт юун дотор чинь оролцоод явах бүрэн эрх байгаа. Тэгээд энийгээ бас эрхээ эдэлмээр байна.

Тэгээд энэ хуулийн хувьд яг юу шийдэх гээд байгаа юм бэ? Яагаад энэ мэргэжлийн Хөдөө аж ахуйн яам нь энэ асуудалдаа орж ирээд, энэ ЗГ чинь ажлаа хийхгүй байгаа юм бэ? Яагаад энэ гишүүд арга ядаад энэ 37, наймуулаа ийм хууль өргөн бариад байгаа юм бэ. Энэ чинь Монгол Улсын ЗГ гэж байна уу. Нүдэн дээр нь бүх юм болохгүй байхад энийгээ засаж залруулах тэр үйл ажиллагааг хиймээр байна шүү дээ.

Өнөөдөр малчид зарсан хэдэн малынхаа мөнгөөр бүтэн өвөлжин тэмцлээ. Тэр мөнгө нь дуусаж байна. Одоо идэх хоолгүй болж байна. Малаа алдсан малчин өрхүүд. Цаана нь эргээд банкны зээл, дэлгүүрт тавьсан өр нь нэхэгдээд тэр хүмүүс сэтгэл санааны гүн хямралд орж байна. Эргээд цаана нь тэд яаж амьдрах итгэлгүй болчихоод байна шүү дээ. Энэ арга хэмжээгээ аваач дээ, энэ Засгийн газар.

Тэгээд бид нарыг ингээд ийм хууль өнөөдөр хэлэлцээд хэзээ болох асуудлын тухай юу яриад байгаа юм бэ. Энэ Баян-Овоо гэдэг сум үнэхээр тэгж сайн ажиллаж байгаа бол бүх эрх зүй, бүх хууль нь байгаа учраас тэнд боломж нь байгаа учраас тэнд үйл ажил нь сайн болсон байлгүй дээ. Тэгээд бусад сумдуудад нь жишээ болгоод тэрийгээ хийе л дээ. Заавал энд хууль болгож оруулж ирэх ямар шаардлага байгаа юм.

Үнэхээр тэр портер, ногоон тэжээл, тэр бууцнаас авдаг бол тэр чинь хүрэхгүй, Лүндээ дарга аа. Нэг л хоногийн хоол шүү дээ, малын. Өнөөдрийн яг нөхцөл байдал дээр нэг төлгийг нэг сар тэжээхэд 50 мянган төгрөг зарж байна. 4 сар тэжээхэд 200 мянган төгрөг зарж байгаа байхгүй юу. Тэгээд тэр төлгөө хэдээр зарж байгаа юм, манай малчид. Дээд тал нь 100 мянгаар зарж чадахгүй л байна шүү дээ. Энэ чинь өөрөөс нь 2 дахин давсан өртгөөр бий болж байгаа бүтээгдэхүүнээ тэр хүмүүс хэдэн

төгрөгөөр зарах юм бэ? Энийг хэдүүлээ бодъё л доо. Эдийн засгийнх нь хувьд.

Өнөөдөр энэ нөөцийн мах гээд олон жил ужгирсан энэ бодлогоосоо хэдүүлээ салмаар байна. Махны үнийг чөлөөлмөөр байна. Энэ малчид өөрсдийнхөө амьдралд ашигтай үрлэг юутай болмоор байна. Арга ядаад л өвс хадлан тэжээлээ бэлдэж чадахгүй, мөнгөгүй. Хэрвээ мөнгөөр бэлдэх юм бол мал нь тэрийг нь идээд дуусгаад өөрийг нь бас өрөнд оруулаад байна. Нөхцөл байдлыг бүгдээрээ ойлгож байгаа, мэдэж байгаа шүү дээ. Тэгээд үнэ цэнтэй мал аж ахуйтай болохын тулд бид нар өнөөдөр тэр жижиг зохион байгуулалт ярих биш, тэр зах зээлийнх нь зарчмуудыг хэдүүлээ нээж өгье л дөө ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал хууль санаачлагч, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга асуултад хариулъя.

Ж.Батжаргал: Тавьж байгаа санал, асуултуудыг бүрэн ойлгож байгаа. Гэхдээ хэдүүлээ бас асуудалдаа их зөв хандмаар байгаа. Би үүнийг хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, хэлэлцүүлгийнхээ түвшинд хэдүүлээ бүх санаануудаа гаргаад, ёстой оюун санаагаа эвлүүлэн зүүж байгаад бас энэ нэг мал аж ахуйн салбарынхаа өмнө тулгамдчихсан асуудлаа шийдэх гарц шийдлээ энэ цаг үед байж болох тэр хэмжээнд нь л гаргачихмаар байгаа юм. Энэ жижиг зүйл биш ээ. Энэ малчдын өөрийнх нь хамтын ажиллагаа, хамтын хариуцлага, хамтын зохион байгуулалт руу орохгүй бол энэ мал аж ахуйн салбарын чинь үндсэн суурь юм нь шийдэгдэж чадахгүй байгаад байгаа юм. Бэлчээр нутгаа зохистой ашиглах асуудал нэг малчнаас үл хамаараад байгаа байхгүй юу. Тэр гол усанд байж байгаа бүх малчид нэгдсэн 1 ойлголттой, энэ бол бид хэдийн малын минь яах аргагүй тогтвортой байх үндэс нь юм гэдэг тэр ойлголт дээрээ нэгдэж чадаж байж л хамтдаа хамгаалж, зөв зохистой

ашиглаж, сэргээж байж л энэ асуудал шийдэгдэнэ. Үүнийг энэ хуулиар бид зохицуулах гэж оролдож байгаа юм.

Мал аж ахуйн салбар өөрөө цаг үеийн олон ажил асуудлуудтай. Тэрийг дан ганц нэг малчин өрх бас дийлж өгөхгүй байна. Бид амьдралаас харж байгаа. Хамтаараа хөдөлмөр зохион байгуулалтаа хийгээд, өвс тэжээлээ бэлтгэдэг, тэр таримал тэжээлээ тарьж хурааж авдаг, мал хуйгаа ноосолж барьдаг юмнуудаа хийх, малаа эрүүлжүүлэх ажлаа зохион байгуулах гээд хийх зүйлүүд олон байна. Үүнийгээ тэр мэргэжлийн байгууллагуудтай нь хамтраад хийх ёстой. Үүнийг энэ хуулиар зохицуулж өгч байгаа юм.

Аж ахуй, бизнесийнх нь үйл ажиллагааг өөрсдийнх нь үүсгэн байгуулсан ашгийн байгууллагаар нь явуулья гэж энэ хуульд тов тодорхой оруулж өгсөн гэдгийг би зориуд хэлье.

Тэгээд яах аргагүй энэ гамшгаас хамгаалах гол асуудал бол олон олон зүйлүүд бий. Түүний хамгийн гол зүйл нь энэ өвөлжилтийн бэлтгэл хангалттай холбоотой. Өвс тэжээлийн нөөц, хашаа саравчны асуудал, малын тарга тэвээрэг, эрүүлжүүлэлтийн асуудал, зөв сүргийн бүтцийн гээд олон зүйлийг ярьж болно. Үүн дээр олон зүйл ярих бололцоо байгаа. Үүнийг ч гэсэн бид энэ холбогдох хууль тогтоомжуудад нь нийцлийг нь хангах замаар шийднэ гэж зориод ингээд л оруулаад л явж байгаа зүйл гэдгийг зориуд хэлье.

Засгийн газрын зүгээс энэ хуульд ороогүй, бариагүй юм байхгүй. ХААЯ-ны холбогдох бүх мэргэжлийн байгууллагуудыг нь, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн хийгээд төрийн бус байгууллагуудыг нь, мэргэжлийн холбоодыг нь авчирч байгаад санал онолуудыг нь бүгдийг нь сонсоод энэ дотор суулгаж шигтгээд оруулсан. Тийм учраас ... /минут дуусав/

Г.Занданишатар: Данзангийн Лүндээжанцан, ажлын хэсэг.

Д.Лүндээжанцан: Ганибал гишүүн, Цогтгэрэл гишүүн нар маань энэ хуулийг санаачлагчаар орж ирсэнд бас талархаж байгаа. Тэгээд бас олон саналууд гаргаж байгаа. Тэгээд анхны хэлэлцүүлгийн явцад хэлэлцүүлгийн явцад энэ дээрээ ажиллана гэж манай Байнгын хорооны дарга Батжаргал дарга хэлсэн байгаа. Тэгэхээр энэ хууль ер нь хэрэг байгаа юм уу гэж яриад байгаа байхгүй юу. Тэгэхээр Улсын Их Хурлын дарга Гомбожавын Занданишатар хөдөө орон нутагт олон удаагийн уулзалт дээр малчдаас өөрсдөөс нь энэ асуудлууд дэвшигдэн гарч ирсэн. Ер нь энэ 30 гаруй жилийн энэ хугацаанд бид энэ хамтын зохион байгуулалтын хамтын менежментийн тогтолцоог авахгүй бол бидэнд цаг хугацаа алга. 2 түрүүн асуулт дээр бодлогын тухай Бат-Эрдэнэ гишүүн ярьж байсан. Тэр 2 бодлогын хэрэгжилтийг дүгнэсэн том дүгнэлтүүд хийгдсэн. Энэ дээр хангалттай хэрэгжсэн гэж үзэхгүй дутагдалтай талуудыг нь зөвлөмждөө заасан. Тэр дотор энэ хамтын менежментийн тогтолцоог оруулахаас өөр арга алга гэдэг ийм дүгнэлтийг эрдэмтэн судлаачид гаргасан байгаа юм.

Ер нь ёс суртахууны доод хэмжээг л хуульчилдаг. Гарцаагүй хамгийн доод хэмжээг. Тэгээд хууль нь тогтвортой хэрэгжээд явахаараа заншил болчихдог. Тэгээд сүүлдээ энэ хуулийн хэрэггүй хүмүүс нь аяндаа ингээд явах ийм л зүй тогтолтой юм. Гэтэл энэ сүүлийн, бид дүгнэлт хийгээд үзэхээр бид хуульчилж байж энэ улс орон даяар энийг нэг журамлаж зохион байгуулж өгч байж энэ цаашаагаа явах юм. Гэхдээ энэ захиргаадалт биш эдийн засгийн агуулга нь дагаж гарч байгаа бусад хуулиуд дотор нь сууж өгч байгаа юм гэж ингэж л хэлмээр байна.

Тэгээд манай академич Бакей, ХААИС-ийн ректор ... /минут дуусав/

Г.Занданшатар: Тийм, энэ мал аж ахуйн уламжлалт тогтолцоонд бас тодорхой хэмжээний шинэчлэл өөрчлөлт хийх шаардлагатай. Энэ цаг уурын өөрчлөлт, нийгэм эдийн засгийн байдал, бэлчээрийн доройтол, залуу малчдын залгамж халаа тасалдаж байгаа явдал гээд маш олон хүчин зүйлээр тодорхойлогдож байгаа. Ийм учраас энэ санаачилга 2 жилийн өмнөөс энэ Улсын Их Хурлын гишүүдийн төсөв хөрөнгөөс ч гэсэн тэр ХААИС-ийн эрдэмтэн судлаачид сая Бакей доктор, Дорж академич нарын талаар ярьж байна, тийм ээ. Тэгээд МУИС-ийн худалдаа бэлтгэлийн тогтолцоо тэр чиглэлээр хийсэн судалгаа Дэлгэржаргал доктор гээд, Ууганбаатар доктор гээд олон доктор, эрдэмтэн судлаачдын сүүлийн 2 жилийн судалгааны үр дүнд өнөөдөр ингээд энэ хуулийн төсөл боловсрогдсон. Энэ бол дунд, урт хугацааны шийдэл.

Яг ойрын хугацааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх шийдэл гарцын хувьд ЗГ төсөл, саналаа боловсруулж байгаа, хэлэлцэж байгаа гэж ойлгож байгаа. Энэ бас ийм чухал асуудал учраас зүгээр энэ улс төрийн яриа хэлэлцээр яриа биш. Энийг саналыг нь аваад, төсөв мөнгийг нь тооцоод, нийгэм эдийн засгийн үр дагаврыг нь тооцоод, ингээд дэг журмын дагуу хэлцэлд орно биз. Дэгийн тухай хуулийг дагуулаад асар их мөнгөний асуудал. Энэ чинь 1,2 их наядын төгрөгийн асуудлыг зүгээр ингээд хэлэлцээд дарга цэрэггүй шийдчихдэг, хоосон их мөнгөний асуудлыг шийдэх ёстой. Харин энэ хүрээндээ бол энэ ойр дунд, хугацааны шийдлийн талаар энэ хуулийнхаа хүрээнд хэлж байгаад, дагуулаад тогтоол санаачлаад хэлэлцээд явж болно.

Ер нь энэ мал аж ахуйн үйлдвэрлэлийг, түрүүн эрчимжсэн МАА гэж яриад байгаа. Эрчимжсэн МАА гэдэг яг онолын нэр томъёо бол интенсив

интенсив файд гэдэг чинь бол бүр маш өндөр үр ашигтай ишмтэй малыг Монголын нөхцөлд энэ Монгол мал аж ахуйг эрчимжсэн МАА болгох боломж маш хэцүү. Уламжлалт мал аж ахуйн үр ашгийг сайжруулах, тогтолцоог сайжруулах л асуудал яригдах ёстой. Өөрөөр хэлбэл жалгын нэг тарсан талын нэг тарсан малчин нөгөө дундад зууны үеийн хэлбэрээрээ энэ цаашаа ингээж зах зээлийн харилцаанд орох, тэгээд уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицох боломж хязгаарлагдмал гэдгийг энэ цас зудын давтамж, ган зудын давтамж энэ бүх нөхцөл байдалд харуулж байна.

Ийм учраас олон улсын турилагыг судлаад, уламжлалт МАА-нхаа турилагыг судлаад энэ хуулийн төслийг манай Батжаргал нарын 38 гишүүн санаачилсан. Өөрчлөлт хийх ёстой. Дунд урт хугацааны шийдэл мөн. Одоо малчид ярьж байгаа шүү дээ. Нөгөө ааруулаа бид 20 мянга хүргэж арайхийж юм заруулж хамгийн өндөр үнэ хүргэдэг. Тэгтэл 70 мянгаар авчихсан байвал яах вэ гээд хотынхон ёстой малчид биднийг шулж байна гээд яриад байх юм. Бид нар хэзээ ч 70 мянгаар ааруулаа зардаггүй, 20 мянгаар өгдөг. Нийслэл дээр мах ёстой малчид бид нарт өндөр үнэтэй зарж байна гэж байдаг. Тэгтэл 4, 5 дахин өндөр үнээр малчдаас авсан үнээсээ өндөр үнээр зарж байдаг. Тэгэхээр нийслэлийн иргэдэд ч гэсэн энэ хууль энэ ач холбогдол цаашидаа хүнсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой. Яагаад гэвэл хямд хүнсээр хангах, цагаан идээ, махан бүтээгдэхүүнээр хангах бололцоо энэ холбоо зохион байгуулалтад орсноороо бас бүрдэнэ. Өөрөөр хэлбэл нийт малчдын 80 хувь нь 500 хүртэл толгой малтай байгаа юм. 5 хувь нь 1000-аас дээш толгой малтай байдаг. Тэгээд энэ малчид чинь 500 хүртэл малтай мал эдийн засгийн скиллийн хувьд, хэмжээний хувьд эдийн засгийн харилцаанд өөрсдөө оролцох боломжгүй субъект гэж боломжгүй эдийн засгийн харилцааны нэгж байгаа юм.

Тийм учраас энийг чинь эргэлтэд оруулахын тулд холбоожиж байж, нэгдэж байж тэрийг харин ааруулыг нь нэгдсэн журмаар бэлтгээд, өөрсдөө Улаанбаатарт ирээд зарах юм бол 20 мянган төгрөгөөр Улаанбаатарын иргэдийг ч хангаж болно, өөрсдөө 30 мянган төгрөгөөр зарагдаад ашигтай явж болно. 30, 40 мянгаар дунд нь.

Мал мах ч гэсэн эрүүл саруул, маш чанартай махыг харьцангуй хямд үнээр Улаанбаатарын иргэдэд нийлүүлэх, малчдадаа бас илүү орлоготой байхыг. Дунд нь байгаа нөгөө гинжин сүлжээ болгонд нэмүү өртөг шингээж байгаа биш энэ дамлан худалдаж байгаа юм шиг процесс байна. Зөвхөн ченжүүдийн ч буруу биш. Энэ олон тээвэр ложистик, худалдаа, зохион байгуулалтын олон асуудлууд алдагдсан байгаа. Тийм учраас Шинэ Зеланд ч байна уу, Солонгос, Япон ч байна уу энэ бүх дэлхийн улсууд ХАА хоршоо холбооны энэ зарчмаар хөгжжөөд, дэргэдээ банктай байна мал аж ахуйн банктай байна, малчдын банктай байж болно. Малчдын даатгалын тогтолцоотой байна. Ийм цогц тогтолцоог бүрдүүлэхэд энэ хуулийн зорилго шинэчилж байгаа юм гэдгийг буруу ойлголт байгаа учраас надаас асуусан учраас асуултад хариулж байна. 4 минутад.

Наянтайн Ганибал гишүүн тодруулж асууя. 1 минут.

Н.Ганибал: Яах вэ, санаачилга гаргаж байгааг нь дэмжээд байгаа байхгүй юу. Энэ асуудлыг даван туулах зайлиггүй шаардлагатай. Тэгээд уг нь Бат-Эрдэнэ гишүүн, Тэмүүлэн гишүүн бид хэд санаачлаад яг бодит шийдэлтэй хууль оруулж ирсэн. Харамсалтай нь хөрөнгө оруулалтын хуулийнхан бид хэдийг дагуулж аваачиж тонгоронгуутаа манай хуулийг хэлэлцүүлэхгүй ингээд баллаад хаячихсан байхгүй юу. Түүн дээр яг малчин өрхийг ногоо тарих, тэр ногоон тэжээл

тарих боломжоор нь бүрэн хангах тийм хууль байгаа байхгүй юу. Энийг бас оруулмаар байна. Хэрвээ яг энэ хууль та нар цааши нь батлаад явбал.

Бид нар бодит шийдлүүд хэрэгтэй байгаа юм, бодит шийдлүүд, Батжаргал гишүүн ээ. Тэрнээс хийсвэр юмнуудаа хэдүүлээ нийлүүлээд одоо байгаа хууль дээр байгаа юмнууд чинь бүгдээрээ ингээд болохгүй болчихоод л бид нар мухардалд л орчихоод байна шүү дээ. Үүнийхээ гарц гаргалгааг хэдүүлээ өөрөөр хайя гэнгүүт байгаа хуулиудаа эргээд нэг жсоохон анхдагч холбоо энээ тэрээ гээд нэмээд ингээд л асуудлыг шийдчихнэ гэж бодоод байх юм. Энэ чинь шийдэл биш байхгүй юу. Хэрвээ зүгээр ... /минут дуусах/

Г.Занданшатар: Батжаргал гишүүн хариулъя. Тэр хууль нь Газрын хуультай гээд ажлын хэсэг байгуулагдсан л байгаа гэж ойлгосон шүү дээ. Түүнийг энэтэй хамт хэлэлцээд явчих бололцоотой юм уу.

Ж.Батжаргал: Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 3 хуулийн төсөл байна. Энхбаяр нарын гишүүдийн өргөн мэдүүлсэн 1 байна. Тэмүүлэн, Бат-Эрдэнэ гишүүн, Ганибал энэ тэрийн өргөн барьсан 1 байна. Тогтохсүрэн нарын өргөн барьсан 1 байна. Ингээд 3 бий. Гурвууланг нь нэгтгэж хэлэлцэх тухай шийд гараад ажлын хэсэг гарсан. Эргээд бүх юмыг судлаад үзсэн чинь зарим нь Үндсэн хуулийн заалттай зөрчилдөөн болж өгөхгүй байгаа. Тэр Энхбаярын өргөн барьсан хууль энэ тэр дээр. Тийм учраас тэрийг нь хасаж шийдлийг нь зөв гаргая гээд манай Байнгын хорооны ажлын алба дээр асуудлууд яригдаж байгаа юм бий.

Хэдүүлээ хэлэлцээгүй байхад нь янз бүрээр яриад яах вэ. Гэхдээ өвөлжөө болгоны дэргэд 2 га газар дээр гэдэг юм уу, 1 га газар дээр ногоон тэжээл тарьчихдаг юм бас байхгүй. Энэ бол одоо юу гэдэг юм. Туулаас хойших бүс нутагт гарч

магадгүй. Тэрнээс урагшаа хэцүү байхгүй юу. Тэгэхээр зэрэг энэ хууль өөрөө улсын хэмжээнд үйлчлэх хууль учраас тэр тариалангийнх нь хуулийн зохицуулалт дотор нь шигтгэх хэлбэрээр асуудлаа шийдэх нь зөв болчихоод байгаа юм. Тийм учраас бид нар ингэж наад хуулийн чинь нийцэл юмнуудыг мэргэжлийнх нь улстай бас ярилцаад хараад орсон эд шүү. Тэрнээс энд ямарваа нэгэн шийдэгдэлгүй юм оруулж ирчхээд та хэдтэйгээ яриад байгаа зүйл биш ээ. Тийм учраас энэ тийм ээ, харин байгаа. Харин наад дотор чинь байгаа. Харин тэгээд тэр тариалангийн хуулиар зохицуулах ёстой юм байна гэдэг нь тэр байхгүй юу. Бас бүсчлэлээр явах ёстой юм байна лээ.

Г.Занданшатар: Тоо ярина гэсэн, тоо байхгүй ээ. Жамбын Батсуурь гишүүн.

Ж.Батсуурь: Малчин өрхийн холбооны эрх зүйн тухай байдлын хууль гээд орж ирж байна. Тэгээд энэ хуулийг хараад байхад тийм ахицтай бодит нөхцөл байдлыг авч гарчихаар зүйл үндсэндээ харагдахгүй байна. Эргээд нөгөө хамтрал коммун, нэгдэл хоршоо руугаа л орох тийшээгээ л хандаж байна. Хуучны кинонуудыг үзмээр байна. “Хүргэн хүү”, “Тууврын замд” гээд. Энэ нөхцөл байдал энэ хуулиас ингээд үнэртэж байна. Ер нь нөхцөл байдлыг ярихын тулд ард түмэн бүгдээрээ мэдэж байгаа шүү дээ. Малчид өөрсдөө мэдэж байгаа. Мал маллахаа марксизмаар заалгахгүй гээд хэлчихсэн. Хамгийн гол нь малчид юу хүсээд байна вэ гэхээр бид нарын ажилд битгий оролцооч, бидний үйлдвэрлэж байгаа мах махан бүтээгдэхүүний үнийг битгий ингээд төрөөс бариад байгаач ээ, чөлөөлөөч ээ, нөгөө ноос ноолуур юуг борлуулахгүй, бусад хилийн цаана болонгуут хэдэн 10 доллар болоод байхад өнөөдөр боодол бохины чинь үнэ хүрэхгүй байна. Та бүхэн хэрвээ санаж байгаа бол 14 онд байна уу, 15 онд ЗГХЭГ-ын дарга Мөнхбат орж ирээд нэг юугаар, арьсаар боодол бохь ч авч чадахгүй байна гэж

байсан. Өнөөдөр хэвээрээ л байж байна. Чадна гээд хэлж байсан.

Тэгэхээр асуудал юу вэ гэхээр ерөөсөө малчид төрөөс ерөөсөө юм гуйдаггүй. Хэрвээ энэ энэ жилийн зудыг ч гэдэг юм уу, өмнөх жилийн зудыг даван гарья гэсэн бол мах нь үнэтэй, ноос ноолуур нь үнэтэй байсан бол заавал хоршоолоод хамтрал, коммун болоод ч байх юм байхгүйгээр өөрсдөө түрдэг трактортайгаа, өөрсдөө өвс бэлчээрээ хангачих боломж нь байсан. Төрөөс зориудаар малчдыг ядуугаар амьдруулчихаад, зориудаар, зориудаар гэж байна шүү. Махных нь үнийг өсгөхгүй, нийслэлийнхнээсээ айгаад. Ноос ноолуурыг нь хил гаргаж үнэтэй болгохгүй. Арьс ширийг нь нэг Дарханы гэнэ үү, хаанахын юм болонгуут л та нарынх алт мөнгө болно гээд 10 жил ярилаа, 8 жил ярилаа, өнөөдөр хэвээрээ. Ингээд зориудаар ядуу амьдруулчихаад энэ сонгууль дөхөөд ирэнгүүт Малчдын өрхийн эрх зүйн байдлын тухай хууль гэж нэг гол шиг юм гараад та нар ёстой нэг янзын сайхан амьдарна гэж. Үгүй. Марксизм зааж байх МАН зааж байх үед малын тоо 25 сая байсан. Малчид өөрөө мэдээд үйлдвэрлэлээ явуулахаар 70, 80 сая хүрч байсан, одоо 70 80 сая хүрсэн малаа эдийн засгийн эргэлтэд оруулъя гэнгүүт нь төр боомилж байгаа энэ хар савраа л татаад авчих гэж байгаа байхгүй юу. Төрийн оролцоогоо хангаад л татчих юм бол тэртээ тэргүй хөдөө аж ахуйн салбар сэргэх гээд байх чинь. Ахиад бид нар та нарын амьдралыг зааж өгнө өө. Та нар хамтрал коммун хоршоо нэгдэл рүү ор оо, ингэх юм сайхан амьдарна гэж. Сайхан амьдрахгүй гэдэг нь өнгөрсөн 100 жилээр батлагдчихсан шүү дээ.

Өнөөдөр зах зээлийн нийгэмд тэр фермер мундаг баян хүмүүс. Төр нь оролцохгүй зүгээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүд нь олон улсын дэлхийн зах зээлээр л зарагддаг болчих юм бол төрөөс юу ч гуйхгүй, малчид. Энэ эдийн засгийн нөхцөл байдлыг нь л хангаж

өгөхгүйгээр марксизм заана, МАН заана, манай нам заана гээд байх юм улам л ядууруулаад байна. Одоо үүнийгээ хуульчлах гэж байна.

Тэгээд 1 юм ярингуут л ерөөсөө тийм хөтөлбөр ийм төлөвлөгөө. Өнөөдөр малчдын суурь үзүүлэлтийг хангахын төлөө өнөөдөр малчдын зээлийг яах юм, бүр огт малгүй болчихоод байгаа хэдэн 100 мянган малчдыг яах юм. Зээлийн хүүг царцаасан гэсэн худлаа, хойшлуулсан гэсэн худлаа. Өнөөдөр малгүй болсон, ядарсан, тэвдсэн, дээр нь өдөр болгон банкнаас утасдаад төр нь дарамталж байгаа юм. Дарамтаа л больчих гэж байна шүү дээ. Бүх салбарт празит хорхой шиг ингээд төрийн дарамт, МАН-ын дарамт шаагаад орчихсон. Тэгээд тэр нь хачиг шиг бариад ард түмнийг ядууруулаад байгаа болохоос л зүгээр хууль нь дутаад ард түмэн ядуу амьдраад байгаа юм байхгүй ээ. Тэгэхээр эдийн засгийн нөхцөл байдалд нь хангасан ийм ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн, хууль санаачлагч асуултад хариулна.

Ж.Батжаргал: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Батсуурь бид 2 хөдөө орон нутагт бас нэгж толгойлж байсан улсууд. Наад цаадахаа нэлээн мэднэ. Амьдралын жаргал зовлон дундуур малчидтайгаа, ард түмэнтэйгээ хамтдаа явсан улсууд. Шийдэх ёстой юмнууд байна уу гэвэл байгаа юм аа. Энэ хууль ямарваа 1 нэгдэл, коммун үнэртэхгүй. Энд хөрөнгө хоршоогүй.

Өнөөдрийн хөдөө орон нутагт болж өгөхгүй байгаа наад хөдөлмөр, зохион байгуулалт, хөдөлмөр, хоршилтын чинь юмыг, тэр Монголчуудын уламжлалт айл айлын амь нэг, саахалт айлын санаа нэг гэдэг энэ үзэл санаа дээр нь тулгуурлаж зохион байгуулалтын юмыг нь, эрх зүйн үндсийг нь хийж өгч байгаа юм. Энэ өөрөө сайн дурын үндсэн

дээр. Ингээж байж хамтын менежментийнх нь асуудлыг шийдэх юм гэдгийг хэлье.

2 дугаарт, мал аж ахуйн бүтээгдэхүүний үнэ цэн оруулах тухай асуудал яах аргагүй бид нар дэлхий нийтээрээ даяаршчихсан, нэг хавтгайжчихсан байгаа үед цаадуулынхаа бас шалгуур шаардлагыг давдаг орчноо л бүрдүүлэх ёстой юм билээ. Тийм учраас та бид хэд хамтдаа Мал, амьтныхаа эрүүл мэндийн тухай хуульд томоохон өөрчлөлт оруулаад хамгаалагдсан аж ахуйн асуудлаа шийдэж өгсөн. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийхээ гарал үүслийн мөшгөлтийн системийг бий болгох хэн ч эргэлзээгүйгээр юмыг нь авч болох энэ нь эргээд үнэ цэнд нь нөлөөлж болох тухай асуудлаа шийдсэн.

3 дахь зүйл, мал аж ахуйн салбарын үйлдвэрлэлээ боловсруулах салбарын үйлдвэрлэл нь гүйцэж өгөхгүй байгаатай холбоотой үнэ цэн орж чадахгүй байгаад байгаа юм байгаа юм. Бид ноолуурыг бараг 2, 300 мянга хүрдэг юм гэж байхгүй. Дэлхийн зах зээл дээр угаагаад самначихсан ноолуур 115 доллар байгаа байхгүй юу. Тэгэхээр чинь зэрэг наадах чинь бид нар энэ түүхий ноолуурыг тэгж үнэд оруулж чадахгүй шүү дээ. Боловсруулалтын түвшнийг нь л ахиулж байж л үнэ цэн оруулж чадна. Тийм учраас энэ тал руу нь бодлого чиглэлээ Их Хурал шийдлээ гаргаад зүтгүүлээд яваад байгаа. Та бид хэд хамтдаа байж байгаад хялгас ялгахгаас дээш боловсруулалт хийсэн ноос, ноолуурыг гадагш нь гаргая гэдэг зарчим бариад тэрний үр дүнд Европтой тогтсон харилцаа өргөжсөөд, энэ хэдэн үндэсний аж ахуйнууд чинь овоо холбогдоод, тэр хэмжээгээр энэ ноос, ноолуур чинь тогтвортой, бас нэг үнэ нь үл ялиг өсөх хандлагатай ингээд байгаад байгаа юм. Ийм сайн зүйлүүдээ цааш нь энэ тусгаар улс мөн л юм бол энэ мал малчид гэдэг юм уу, энэ хөдөө аж ахуйн салбарынхаа ажиллагсдын салбарынхаа

хөгжлийг хангах эрх ашгийг нь хангаж ишийдлээ хийх ёстой энэ хүрээнд нь л хийгээд явж байгаа зүйл ээ. Малын махны үнэ та бид 2-ын ярьснаар энд нэг хотын хэрэглээний махыг барья гэдгээр баригдчихдаг бас зүйл биш байхгүй юу.

Г.Занданшатар: Жамбын Батсуурь гишүүн тодруулж асууна. 1 минут. Жамбын Батсуурь гишүүн нэг минут тодруулчих.

Ж.Батсуурь: Тийм, сүүлийн 20, 30 жил яг л таны энэ хэлж байгаа үгийг л хүмүүс хэлсээр байж байгаад л энд хүрчихлээ л дээ. Яг үнэндээ хилийн цаана 1 кг мах 36 мянга байна. Тэгсэн мөртөө гаднаас өнөөдөр Монголын баячууд нэг ийм хуруун чинээ загасны махыг хуруун чинээ шүү дээ 7 мянга, 10 мянгаар идэж байна. Эдийн засгаа чөлөөлөөч дээ. Аль нөгөө социалист эдийн засагтай Хятад орон аль 80, 90-ээд оноос эдийн засгаа чөлөөлчихсөн. Бүх малчид нь өнөөдөр хангалуун сайхан амьдарч байгаа учраас төрөөсөө юм хүсэхгүй байна. Өнөөдөр хадлан бордоо, тэжээлд төр оролцохгүй байж болно. Хамгийн гол нь малчдын үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлийн, олон улсын зах зээлийн үнэд л оруулаад өгөөч гэж байгаа юм. Арьс шир, үгүй ээ, үгүй, арьс, шир. Арьс шир аль 16 онд л янзын гоё болгоно гэсэн өнөөдөр хэвээрээ л байна шүү дээ. Хог хаяж байна. Энэ нөхцөл байдлаа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Хэдүүлээ бас сонгуулийг зөв хийнэ ээ. Сонгуулийн сигнал дуугарчихсан хойно улс төрийн оноо цуглуулах гээд илүү дутуу бас хэдэн биедээ үг шидэх хэрэггүй. Хэдүүлээ амьдралаа мэднэ. Энэ дотор захиргаадалтын гэдэг юм уу, дарамтын нэг ч үг байхгүй. Уни, 1.

2 дахь зүйл. Яах аргагүй хэдүүлээ энэ аж ахуйнуудаа босгохын тулд, үнэ цэн оруулахын тулд, өрсөлдөх чадварыг нь нэмэгдүүлэхийн тулд хийх ёстой юмнуудаа хийх ёстой. Тийм учраас тэр Мал, амьтны эрүүл мэдийн тухай хууль. Хялгас ялгаснаас дээш боловсруулалт хийгээд гаргах тухай асуудал энэ тэрийг чинь ишийдээд яваад байгаа. Үүний үр дүн нь гараад яваад байгаа гэдгийг зориуд хэлье.

Байгалийн давагдашгүй хүчин зүйл болж, ямар үр дүн гарсан юм гэж чи өөрөө өөрөөсөө асуу, наадхыгаа. Чи өөрөөсөө асуу.

Г.Занданшатар: Өөрөөсөө асуу гэж байна. Цэвэгдоржийн Туваан гишүүн.

Энэ үр дүн юунаас гарсан бэ? 19710 аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэлийн маш олон асуудал байгаа шүү. Цэвэгдоржийн Туваан гишүүн. 5 секунд дутуу байсан та 10 болгочихлоо.

Ц.Туваан: Энэ малчин өрхийн нэгдсэн холбоо гээд энэ Ганибал гишүүн хэлнэ лээ. PR-ын шинжтэй гээд, товчлолыг нь харахаар мөнх гээд байгаа юм л даа. Яах вэ, ийм зүйлүүдийг бид хэд бас ярьж болно. Тэгэхдээ 1 жоохон ул суурьтай, бүх арга хэмжээгээ сайн судалж байж оруулж ирмээр байна. Яам хаана байгаа юм, ЗГ хаана байгаа юм, тэд нарын үгийг бас сонсмоор л байна шүү дээ.

Энэ хуулийн танилцуулга дотор малчид малын тооны араас хөөцөлдөж байна гээд биччихсэн байгаа. Малын тооны араас төр хөөцөлдүүлээд байгаа юм. Яагаад гээч. Байгаа хэдэн 500 мал нь зараад зараад амьдралд нь хүрэхгүй байгаа учраас тэд нар үнэгүйгээр нь бэлчээр лүү орж байж, малынхаа тоог 1000 хүргэж байгаа юм. Тэгэхээр энийг төр малын тооны араас өөрөө хөөцөлдүүлээд байгаа юм. Үүнийгээ больчихмоор байна.

2 дугаарт, энэ төрийн албан хаагчдын, төрийн үйлчилгээний албан хаагчдын тэтгэвэр нэмлээ л гээд байна. Энэ чинь үнийн өсөлтдөө залгигдчихна. Хөдөө орон нутагт хүмүүс яаж амьдраад байгаа гэхээр мах өрддөггүй тулдаа, одоо борц гараад ирсэн тулдаа ер нь амьдрал тогтож байгаа шүү, яг яс юман дээр. Тэрнээс биш тэр нэг жоохон юм нэмчхээд амьдрал сайжраад байгаа юм байхгүй. Тэгэхээр энэ мал бүхий иргэд яах юм. Энэ дотор чинь ямар зохицуулалт орсон юм. Сумын төвийн иргэд яах юм. Эд нар чинь хөөрхий нэг хамаатан дээрээ мал бүхий иргэн гээд хэдэн мал маллуулаад тэрийгээ нядалж идээд л хөөрхий гүрийгээд л байж байгаа шүү дээ. Багш, эмч нар бүгд ялгаагүй. Тэгэхээр энэ хүмүүсийн эрх ашиг хаана орох юм.

2 дугаарт, энэ сүүлийн үед энэ мал аж ахуйг эрчимжүүлнэ, малын ашиг шим гээд. Энэ бас хүнд шүү. Одоо ийм байгалийн гамшиг зудтай байгаа энэ нөхцөлд малыг эрчимжүүлнэ гэдэг, малын мах ийм хямдхан байхад түүхий эд нь ямар ч үнэгүй байхад, тэрийг эрчимжүүлж яаж чадах юм. Ийм амьдралгүй юм ярьдгаа бас болимоор байна. Малын ам руу мөнгө хийж мөнгө хийх юм улам л ядуурна. Тэрний баталгаа нь энэ зудын үед малчид өвс тэжээл байгаа мөнгөөрөө, ямааныхаа арьсыг хуулаад тэжээл авч өгөөд дийлэхгүй байгаагийн чинь нөхцөл байдал энэ шүү дээ. Тэгэхээр миний хэлэх гээд байгаа зүйл энэ дээр жоохон амьдралтай хандъя, өшөө судалгаа юм хийе ээ, малчдаа оруулъя, хөдөөгүүр явъя, яамыг нь оруулъя ингэж шийдье.

Нэг шийдэл байгаа. Энэ маш амархан шийдэл. Малчид махаа үүрээд Эрээн орж чадахгүй, ноосоо үүрээд тэр бусад улсад аваачиж зарж чадахгүй, ноолуураа аваачаад тэр Итали хүргэж чадахгүй. Үүнийг хүргэдэг тэр дэд бүтцийнх нь асуудлыг нь шийдээд, үнийг нь чөлөөлөөд л өгчих. Эхний ээлжид энэ

холбоо гэхээсээ өмнө энэ асуудлаа бас ярьчихвал яасан юм бэ. Тэртээ тэргүй Холбооны эрх зүйн байдлын тухай хууль чинь орж ирж л байгаа юм байна шүү дээ.

Дараагийн нэг асуудал нь энэ. Яг энэ хууль ярихаас өмнө бид нарын өргөн барьсан юм яачхав, Занданшатар дарга аа. Нөгөө товоо би асуугаад байна. Одоо ерөнхийдөө гуйж нэлээн үзэж байгаа. Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхэд энэ тогтоолын төсөл санаачлах байдаг юм бол АН-ын гишүүдийн санал санаачилсан юм яачхав. Хөрөнгө оруулалтын тухай хууль өгөөд маргааш нь парламент руу орж ирээд байдаг, бид нарынх өгөөд 45 хоноод байхгүй байна.

Малжуулах хөтөлбөрийг яаж хийх юм. Малгүй болсон иргэдийн амьжиргааг яах юм, энэ хот руу орж ирэх нүүдлийг яах юм гээд.

Г.Занданшатар: Туваан гишүүн ээ, ер нь манай Улсын Их Хурлын гишүүд энэ сөрөг хүчин гэдэг сөрөхийн нэр биш л дээ. Ган зуд болсны дараа матрын нулимс унагаа л сонгуулийн улс төр хийхээ боливол таарна. Энэ урт хугацааны шийдлийг эрдэмтэн судлаачид бодож боловсруулаад, хуучин шинэ олон улсын туршилага чиглэлийг гаргаад ийм хууль санаачилж байхад энийг зүгээр л жадлан эсэргүүцэх байдлаар ханддаг чинь таарахгүй ээ. Дэлхийн цаг уурын өөрчлөлт, нийгэм эдийн засгийн нөхцөл байдал чинь энд өөрчлөлтийг шаардаад байна. Энэ урт хугацааны шийдэл, ойрын хугацааны шийдлийг нь Засгийн газраас өргөн барина. Энэ дээр чинь малын тоо нэмэгдүүлээд байна гэсэн юм байхгүй шүү дээ. Малын тоо яагаад нэмэгдээд байгаа юм. Яагаад гэвэл малын ашиг шим, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүн чинь борлогдохгүй байна шүү дээ. Яагаад борлогдохгүй байна? Малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээ боловсруулах бүх үйлдвэрүүдийг нь дампууруулаад, хувьчлаад, устгаад, урагшаа хил, гааль руу гаргаад байхгүй болгочихсон. Түүхий

эд, худалдаа бэлтгэлийн бүх тогтолцоог нь нураагаад унагаагаад хаячихсан. Тэгээд тэр ноолуур, арьс шир, ноос ноолуурыг хэн зарж байна. Ченжээр дамждаг. Хуучин худалдаа бэлтгэлийн тогтолцоо байхгүй болчихсон. Үндэсний үйлдвэрүүд байхгүй болчихсон. Энэ чинь энэ их захгүй бодлогын чинь алдаа болохоос биш энэ хуулийн буруу гэж юу нь яриад байгаа юм.

Дэлхийн Шинэ Зеландын, Солонгос, Швед, дэлхийн бүх улсын туршлагыг судлаад эрдэмтэн судлаачид ийм хуулийн төсөл боловсруулчихсан байна. Тэр хууль тогтоол санаачилсан бол ажил хэрэгч хяналт хэрэгтэй. Эдийн засгийн тооцоо судалгаа, нийгэм, эдийн засгийн үр дагавар, ямар юм хийх гээд байгаа юм. Тэр тэгээд Дэгийн тухай хууль санаачлуулаад нэг хуулийн цоорхой ашиглаж байгаа юм шиг Засгийн газрын саналыг авах хэрэгтэй. Энэ дээр чинь ХААЯ холбогдох байгууллагууд оролцоод энэ санал төслөө боловсруулчихсан байна. Ингээж урт, дунд хугацааны ойрын шийдэл гарахгүй бол ган зуд болохоор л болохоо болилоо тэгье, тэгье гээд л юу яадаг.

Тийм учраас энэ малчдаа үнэн сэтгэлээсээ дэмжиж байвал энэ малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнийх нь борлуулалтын систем, зохион байгуулалтын систем, энэ малчдын зээл, санхүүжилтийн систем, хоршоо холбох системийг нь дэмжсэн ийм зохицуулалт хийж байна шүү дээ. Та маш буруу ярьж байна. Малчдыг ингээж үл тоомсорлож муу хэлж болохгүй. Малчид яаж Итали руу ноолуураа зарж чаддаг юм гэж, чадаж байгаа шүү дээ. Хоршоод холбоод Ховдын тэр хоршоо хар. Италид ноолуураа малчдынхаа хоршооны ноолуурыг нэгтгээд холбоо болоод нэгтгээд авчраад Улаанбаатарт угаалгаж, самнуулаад Италид гаргаж байгаа. Италид очоод зургаа авхуулаад ингээд гаргачихсан байгаа юм. Энийг үз, судал та нар. Хуулиа уншаагүй. Италид гаргаж байна.

Одоо томоохон компаниудтай хамтраад махны том үйлдвэрүүд бий болоод, түрүүчийнхээ гадаадад экспортод гаргаж байна. Гадаад экспортод махаа гаргах гэхээр чинь мал нь эрүүл биш гээд байна шүү дээ. Малын эрүүл мэнд чинь нийтээр ашигласны тулд малчдын нийтлэг эрх ашиг сонирхлыг хамгаалдаг ийм холбоо байх нь ХАУТ-ын хууль, Үйлдвэрчний эвлэлийн тухай хууль гээд. Тэгтэл МАА-н Монгол улс энэ малчдаа дэмжсэн ийм хуультай байхад яагаад эсэргүүцээд байгаа юм? Улс төрждөггүй юм гэж бас байна шүү.

Цэндийн Сандаг-Очир гишүүн. Хууль санаачлагч Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны дарга Батжаргал гишүүн. Та надаас асуусан учраас би хариуллаа. Та асуусан тэр хууль яасан гэж?

Ж.Батжаргал: Туваан гишүүний асуултад хариулъя. Хуулийн төсөл дотор малын тооны хойноос хөөцөлдөж байгаа учир шалтгааныг бичсэн. Мал тэжээл, эрдэс, амин дэмийн дутагдлаас болоод давжаарч байна. Ашиг шим нь буурч байна. Үнэ цэн нь буурч байна. Үүнээс хамаараад амьдрал ахуйгаа авч явахын тулд малын тоогоо өсгөхөөс өөр аргагүй болчихоод байна гэдгийг дурдсан. Тэгээд тэрийгээ засах шийдэл нь энэ хуулиараа суурь харилцаа нь зохиогдох юм гэж ингээж оруулж ирж байгаа юм гэдгийг хэлье.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг тогтвортой хөгжүүлэх ёстой. 2 зүйл бий. Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйгаа тэр нутгийн шилмэл омог дээр нь тулгуурлаж цаашаа хөгжүүлж явна. Газар тариалангийн бүс нутагтаа өндөр ашиг шимтэй малаа хөгжүүлнэ. Энэ 2-ын хослолоор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдэж, тэр хэмжээгээр хүнсний хангамж аюулгүй байдал ч бий болно, хүнс хөнгөн үйлдвэрийн салбар ч хөгжинө гэж ингээж харж явж байгаа.

Үүгээр улс орны эдийн засгийн тэлэлт нь бий болно, экспорт нь бий болно, валютынх нь дотогшилох урсгал нь бий болно гэж ингэж харж бүх юмнуудаа хийж яваа гэдгийг зориуд хэлмээр байна.

Дараагийн нэг хэлсэн зүйл. Цалин хөлс юмнууд нэмлээ. Үр дүн нь юу байгаа юм бэ гэдэг асуудал яригдаж байна. Энэ дан ганц энүүгээр бүх асуудлыг хараад байгаа юм биш ээ. Бид улс орныхоо эдийн засаг нийгмийн хөгжлийг тогтвортой хангах үүднээс тов тодорхой бодлогын олон арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж ажилласан. 2023 оны жилийн эцсийнхээ гүйцэтгэлээр эдийн засгийн өсөлт 7 хувьтай, инфляц 8 хувьтай, валютын чинь нөөц 5,2 тэрбумтай. Энэ хэмжээгээр Монгол төгрөгийн худалдан авах чадвар нь чангарсан. 120 гаруй төгрөгөөр буурсан юм билээ. Юу нөгөө валютын хани. Ингээд үүгээр дамжиж энэ нэг дотооддоо үйлдвэрлэж чадахгүй импортоор оруулж ирээд байгаа бараа бүтээгдэхүүний чинь үнэ цэнээр дамжиж очоод байгаа хэрэглэгчдийн хүндрэлд бага ч гэсэн нөхцөл байдлыг нь дээрдүүлнэ.

Дээр нь бид нар энэ эдийн засгийн жоохон бий болсон үр дүн буюу орлого нэг 30 хэдэн хувиар давж орсон. Үүнийгээ төрийн албан хаагчдынхаа цалин хөлс, өндөр настнуудынхаа тэтгэвэр тэтгэмж рүү бас энэ нөхцөл байдалтай нь уялдуулж 04 сарын 01-ээс нэмэлт хийсэн. Энэ тийм бага нэмэлт биш бас бололцоотой нэмэлт. Энэ амьжиргаа юманд нь бас тодорхой дэм болно гэж ингэж харж байгаа. Тэр битгий хэл бид энэ хот хөдөө ... /минут дуусав/

Г.Занданиатар: 1 минут Туваан гишүүн тодруулж асууя.

Ц.Туваан: Дарга аа, тэр микрофон ашиглаж энэ гишүүдийн бүрэн эрх ...

Г.Занданиатар: Дэгийн тухай хууль тодруулж асуухгүй байгаа учраас та. Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Энэ ийм уудам нутагтай, газар нутагтай уулын ам жалгаар ганц нэгээрээ буучихсан байгаа энэ бэлчээрийн уламжлалт мал аж ахуйгаа эрхэлж байгаа малчин айл өрхүүдээ хэрхэн яаж зохион байгуулалтад оруулах асуудал л байгаа юм л даа. Тэгээд ерөөсөө энэ ганц нэгээрээ буучаад байгаа нь өөрөө энэ малчин айл өрхүүдийн байгаль, цаг агаарын ган зудын эрсдэлд орох үндэс суурь болоод байгаа юм. Үндэс суурь нь. Ганц нэгээрээ буучаад байгаа юм. Тийм учраас энэ бэлчээрийн уламжлалт мал аж ахуйг эрхэлж байгаа энэ малчдыг 5, 10-аар нь суурин, хагас суурин ийм хэлбэрт шилжүүлж байж энэ хоршооны утга агуулга иж бүрнээрээ гарч ирнэ гэж би хувьдаа ойлгож байгаа юм. Тэрнээс одоогийнх ишг ганц нэгээрээ буучаад 4, 5 км-ийн зайтай байгаа айл өрхүүд арваараа, хориороо нийлээд хоршоо байгуулаад явна гэхээр наадах чинь яг амьдрал дээр буухад хэцүү байгаа юм.

Арваараа, хориороо, хагас суурин хэлбэртэй байж байж бие биеийнхээ ажилд тусалдаг, дэмждэг, бүл хүчтэй болж байж тэр өвс тэжээлээ бэлдэх, малынхаа угаалга, тарилгыг оруулах, хадлан бэлчээрээ бэлдэх, хот хүрээ явах, өвдөж хавдах, улсууддаа нэгийгээ эмчлүүлэх гээд ерөөсөө энэ асуудлууд чинь ганц нэгээрээ байгаад малчин айл гэхэд өнөөдөр авгай, нөхөр 2 л байгаа. Өөр хүн хүчгүй байгаа учраас байгаль, цаг агаарын энэ эрсдэлд хүчин мөхөстөөд байгаа юм. Нааш, цаашаа төвтэй холбогдож явж чадахгүй болчхоод байна. Замаа гаргаж чадахгүй болчхоод байна. Өвсөө хадаж чадахгүй болчхоод байна. Тийм учраас ерөөсөө энэ энэ хагас суурин хэлбэртэй байж болдоггүй юм уу. Ингэж байж бүтээгдэхүүнээ, сүү, цагаан идээгээ боловсруулах, борлуулах, бэлтгэх хүн хүчтэй болно. Ингэж байж эдийн засгийн

эргэлтэд оруулна. Ингэж байж ган зудын байдалд нааш цаашаа явах гээд эдийн засаг, цаг хугацааны асар их нааштай үзүүлэлтүүд гарна гэж би хувьдаа ойлгож байгаа.

Тийм учраас энэ хориороо хоршино гэдэг ч бас ихдэж байна гэж харж байна. Тав, арваараа хоршоо байгуулаад явах асуудал байна. Тийм учраас энэ малчдын ойлголт хандлагыг өөрчлөх асуудал бас их чухал байна. Ганцаараа яваад энэ ган зудын байдлыг давахгүй нь гэдгийг ойлгуулах асуудал чухал байна. Ерөөсөө хүчээ хамтарч нэгтгэе ээ. Таваараа, арваараа бууя, мал ахуйгаа бүгдээрээ хүчээ нэгтгэж хариулъя аа. Угаалга, тарилгаа, хадлан өвс тэжээлээ бэлтгэе гэдэг энэ ойлголт хандлагыг өөрчлөхгүйгээр энэ хоршооны асуудал цаашидаа одоогийнх шигээ уулын аманд жалга довоороо ганц ганцаараа буучихсан тохиолдолд хурлаа хаана хийх юм, асуудлаа хаанаа ярих юм гэдгээс авхуулаад асуудлууд үүснэ ээ.

Тийм учраас цаашидаа ер нь энэ хагас суурин хэлбэртэй, ер нь бол энэ амаар нь тэр хоршоонд тэр газрыг нь тэгээд давуу байдлаар олгодог юм уу яадаг юм. Ийм байдлаар явж байж энэ хуулийн, энэ хоршооны асуудлууд цаашидаа иж бүрэн утгаараа явах бололцоо боломж бүрдэх юм болов уу гэдгийг би бас хувьдаа бодож байна. Энэ дээр хууль санаачлагч нар бас юу гэж бодож байна вэ гэж.

Нөгөө талаар энэ “Хүргэн хүү” кинон дээр гардаг шиг Жамц баян шиг нэгдэлд хоршоонд орохгүй айл өрхүүд байвал яах вэ? Орсон айл өрхүүдийн хоорондын зөрчлийн асуудал үүсэхээр байна. 1 нэгнийгээ орсон ороогүйгээрээ цаашидаа бас малчдын дунд асуудал үүсэж, чи би дээ хүрэх, бие биеийгээ тууж хөөх асуудлууд гарвал яах ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ажлын хэсэг 4. Данзангийн Лүндээжанцан доктор.

Д.Лүндээжанцан: Тэгэхээр Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Энэ байна шүү дээ. Хоршооны хууль хэлэлцээгүй байгаа, 1 дүгээрт. Хоршоо чинь суман дээрээ нэг юм уу, 2, 3 төрөлжөөд, тэгээд дундын хоршоо гээд ингээд сайн ажиллаж байгаа хоршоонууд Монгол Улсад олон байна. Түүрүн Ховдын хоршоо ноолуураа Италид гаргаж байгаа тухай Их Хурлын дарга ярьж байна шүү дээ, жишээ татаад. Гэтэл, гэтэл энэ бол хоршоо биш зохион байгуулалт, холбоо юм аа, холбоо юм. Зөвхөн малчдын өөрсдийнх нь засаглал юм. Манай Монгол Улсын байгаль цаг уурын бүс, бүслүүр, бүс болгоноор өөр өөр байна. Энэ Сандаг-Очир гишүүний яриад байгаа бол хангайн бүсэд зарим газраа таарч болох юм. Өнөөдөр айлуудыг нэгтгэж ирүүлээд хоршоо маягаар нэгдэл маягаар зохион байгуулах тухай ойлголт энэ хуульд байхгүй ээ. Яах вэ, зэргэлдээ оршиж байгаа, тийм үү, айл саахалтын нэг голын нэг голынхон гэдэг тогтолцоогоор нэг 20 айл, 20 гэдэг тоон дээр нэлээн яриа болсон байхгүй юу. Гэтэл зарим газар нээрээ говийн бүсэд 20 айл нэгдээд зохион байгуулалтад ороход хүндрэлтэй байж магадгүй. Хангай газар бол хялбар дөхөм байж магадгүй. Аравтын тогтолцоогоор манайх бүр төр засаглалын тогтолцоо хүртэл байсан шүү дээ, аравтын тогтолцоо. Тэгтэл дараа нь 20 гэдэг асуудал гарч ирсэн. Энэ бол засаг захиргааных.

Одоо бид нар малчид өөрсдөө зохион байгуулалтад орох энэ чиглэлийн юм, хөдөлмөрөөрөө хорших тухай асуудал юм. Тэр таны хэлсэн эрсдэлээс хамгаалахын тулд өвөлжилтийн бэлтгэлээ хангахын тулд тэр нэг 20-оод айл нийлээд тэр ахлагч нь дунд нь яваад, зохион байгуулаад хоршоонуудаар сумд ажиллаж байгаа ААН-ээр дамжуулаад, хадлангийн талбай гээд байна шүү дээ. Тусгай хуулиар зохицуулчихсан тэр

талбайнууд байж байгаа. Өөр сумын нутагт, өөр аймагт хүртэл байна л даа. Очиж хадах шаардлага гарна. Энд нь хүчээ зохион байгуулаад тэгээд хадлан бордоо, өвөлжилтийнх нь бэлтгэлийг хангахад оролцож өгөх ийм зүйлүүд, тэгээд таны яг саяын ярьдаг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх. Өнөөдөр зохион байгуулалтад орж чадсан тийм холбоо нөхөрлөл дээр бол малын өвчин эмгэг хүртэл гарахгүй байгаа байхгүй юу. Бие биедээ хяналт тавьж чадаж байна. Танайх энэ урьдчилан сэргийлэх тарилга туулга дархлаажуулалтад танайх үлдлээ шүү, нүүж ирж байгаа отрынхноос өвчин авчихвал та нар хариуцна шүү гээд нэг нэгэндээ хүртэл шаардлага тавьдаг. Ийм л болох зүг рүүгээ явж зохион байгуулалтад орж байгаа юм. Зарим нь газар нутгийн хувьд өргөн дэлгэр учраас хүндрэл бэрхшээл гарах ч тохиолдол бий. Энэ нь бас бэлчээрийн даацад сайн нөлөөлөх ч тал ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жадамбын Бат-Эрдэнэ гишүүн.

Ж.Бат-Эрдэнэ: Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль гээд орж ирж байна. Миний бие бас энэ хууль санаачлагчийн нэг л дээ. Тэгэхээр яг энэ цаг үе хугацаанд, сая бол маш хүнд өвөл боллоо. Сая хүнд хавар боллоо. Мал аж ахуйг яаж өөрчлөх ёстой юм, яаж шинэчлэх ёстой юм гэдэг асуудал бол бид нарын бүр нэн тэргүүний асуудал боллоо шүү дээ. Энэ асуудлаар нэлээн олон удаа ярьж байсан. Мал гэдэг хувийнхаа, малчны асуудал, хувийн малтай нэг их яриад байх юм байхгүй, зах зээлийнхээ асуудлаар шийднэ гэсэн ийм хандлага ийм байдлаар бол бид нар өнөөдрийг хүртэл ирлээ шүү дээ. Зөндөө асуудлуудыг ярьж байсан. Тэгээд л дандаа хаягдаад л явж байсан.

2022 онд жишээ нь цаг уурын өөрчлөлтөд дасан зохицсон мал аж ахуйг хөгжүүлэх асуудлаар бас тодорхой хэмжээний бодлого Улсын Их Хурал дээр

орж ирж байсан. Яалаа, та бүхэн мэдэж байгаа шүү дээ, бид нар дэмжээгүй л унагаад л явуулж байсан шүү дээ. Тэгээд өнөөдөр ийм цас зуд болонгуут бүгдээрээ бид нар малчдадаа хайртай болоод явчхаж байгаа байхгүй юу. Уг нь бол бид нар энэ чинь зөвхөн малчдын асуудал биш байхгүй юу. Энэ бол цаад утгаараа бол Монгол Улсын хүнсний аюулгүй байдал, хүнсний хангамжтай холбоотой асуудлууд байхгүй юу даа. Нэг хэдхэн малчны асуудлыг л бид нар яриад байгаа юм шиг тойроод л хэрүүл хийгээд байх юм.

Одоо удахгүй магадгүй энэ хавар Улаанбаатар хотод махны үнэ нэмэгдээд явна, харж байгаарай. Яагаад гэхээр нийлүүлэлт байхгүй байхгүй юу. Бидний өнөөгийн байгаа МАА чинь угаасаа энэ шүү дээ. Намар 10, 11 сард байдгийгаа боломжтойгоо бүгдийг нь нядлаад л мах болгоод хадгалчихдаг. Хавар болохоор махны хомсдол бий болдог. Хавар нь үнэхээр хүнд байгаад, цас зудтай байгаа тохиолдолд бол өшөө бүр хүндрэл, хомсдол бий болдог. Тэгээд Улаанбаатар хотод нөгөө махных нь үнэ нэмэгддэг ийм л асуудал болж байгаа шүү дээ. Бид нар ийм л амьдралыг л эргэн тойроод байгаа шүү дээ.

Тэгээд үнэхээр малчны, Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль гээд анхных нь ийм хууль орж ирж байна. Үнэхээр бололцоотой, дэмжээд явах ёстой гэж ойлгож байгаа. Би жишээ нь, энэ Монголын мал аж ахуйг бол зэрлэг МАА гэж хэлээд л бас л буруудаж л байсан. Яг үнэндээ бид нар зэрлэг мал аж ахуйтай л явж байгаа шүү дээ. Одоо ингээд малчдынх нь холбоотой асуудлууд орж ирж байна. Малтай холбоотой асуудал, малчидтай холбоотой асуудал, мал аж ахуйн шинэчлэлтэй холбоотой асуудлууд ингээд л ар араасаа орж ирж байна. Үүний ар дээр Малчны тухай хууль байгаа байх аа. Тэр орж ирнэ. Тэгээд дээрээс нь Засгийн газраас бас МАА дээр холбоотой тодорхой асуудлууд орж ирнэ.

Ингээд ядаж бид нар яг энэ цаг үетэй уялдаатайгаар энэ хүндрэлийн ар дээр бол нөгөө зовлон үзсэн чавганц ямар ямар асуудал шийддэг гэдэг билээ, түүнтэй адилхан жишээ нь яг энэ хүнд нөхцөл дээр бид нар энэ мал аж ахуй дээр бид нар тодорхой асуудлуудыг шийдээд шийдээд явчих хэрэгтэй шүү дээ.

Тийм болохоор энэ Мал малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль гэдэг бол үнэхээр зөв зүйтэй хууль ороод ирлээ гэж бодож байгаа. Малчдынхаа эрх ашгийг хамгаалах, мал аж ахуйгаа дээшлүүлэх, бид нар нэн тэргүүнд яриад байдаг залуу малчид байхгүй боллоо гэж байгаа. Хэн мал маллах вэ гэдэг асуудал бидний өмнө тулгарч байгаа. Тэгэхээр залуу малчдаа яаж бэлдэх юм.

Дээрээс нь ер нь бол яах вэ, энэ сөрөг хүчнийхэн манай хэдийн яриад байгаа зүйл дээр би нэг зүйлийг бол дэмжээд байгаа юм. Эцсийн эцэст мал аж ахуйгаа бид нар бас босгохын тулд цаад утгаараа бол мал нь эргэлтэд орж байдаг, мал мах нь эргэлтэд орж байдаг, гадаад экспортынхоо нийлүүлэлтийг бид нар хаалгаа нээх, экспортоо нэмэгдүүлэх ийм л асуудлуудыг бид нар шийдэх ёстой шүү дээ. Тэгвэл явж явж бид нарын өнөөдрийн шийдэх гээд байгаа энэ асуудлууд чинь аяндаа тэр малчид руу ороод ирнэ. Аяндаа малчид чинь өөрсдөө хөл дээрээ босоод ороод ирнэ. Эдийн засгийн хувьд бол хүчин чадалтай боломж бололцоотой болоод ирнэ. Тэр үедээ бол нөгөө нэг хаашаа хороо, бүх сав суулгаа бол засаад залруулаад шинэчлээд явах ийм боломж бололцоо нь олгочихно. Нэг шуурга боллоо, хамгаа тавиад ... /минут дуусав/

Г.Занданшатар: 1 минут.
Хариулт хангалтгүй л тодруулж асууна гэсэн байгаа. Тийм зарчим, дэг нийтлэг баримталж байгаа. Санал байна уу.

Баагаагийн Баттөмөр гишүүн.
Цогтгэрэл гишүүн алга байна, тасалъя.
Баагаагийн Баттөмөр гишүүн.

2 гишүүн асуулт асуусны дараа санал хураалттай. Гишүүд чуулганы танхимд цуглая.

Б.Баттөмөр: Өнөөдрийн энэ хөдөө аж ахуйн байдал, ялангуяа мал аж ахуйн байдал бол хамтарч ажиллаж, төрийн оновчтой бодлого, зохицуулалт бол үнэхээр шаардлагатай байгаа нь харагдаж байгаа шүү дээ. Бид хүрсэн түвшинээсээ л буурчхаад байгаа юм. Ер нь аливаа хөгжил гэдэг маань бол цаашидаа урьд нь байгаа ашигтай зүйлүүдээ цаашиаа хөгжүүлж, шинэ зүйл хийж, ашигтай зүйлүүдийг санаачилж ингэж л явж л хөгжилд хүрдэг жамтай. Тэгэхээр бид нарынх байхгүй л байгаа юм л даа.

Энэ дэлхийн хамгийн аз жаргалтай улсууд амьдардаг тэр Скандинавын орнууд, Шведийн хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд ирээд танай тэр нэгдлийн зохион байгуулалт бол их зөв хэлбэр байжээ. Харамсалтай нь, та нар татан буулгасан байна гэсэн ийм зөвлөмжийг бидэнд өгсөн байгаа. Тэгээд ер нь нэгдэл гэдэг нэр нь хүмүүст таалагддаггүй байсан ч гэсэн тэрийг өөр нэрээр нэрлээд, малчид өөрсдөө хөдөлмөрөө хоршоо явах ийм боломж бидэнд байсан байхгүй юу. Өнгөрсөн хугацаанд. Тэр битгий оролц, та нар оролцоод байна л гээд л ингээд л зарим хүмүүс яриад байгаа байхгүй юу. Төр ерөөсөө оролцоогүй шүү дээ. Хаячихсан шүү дээ. Нөгөө эрэлт нийлүүлэлт нийцнэ. Эрэлт нийлүүлэлт нь зохицуулна гээд хаячихсан. Тийм учраас бол энэ дээр их бодолтой, бид нар ярьж хийхгүй бол болохгүй байгаа юм.

Нөгөө Монголчууд ярьдаг шүү дээ. Нөгөө цувж явсан барнаас цуглаж суусан шаазгай дээр гэж. Хамжихгүй бол амжихгүй гэж бас Монголчууд ярьдаг. Тийм учраас өнөөдөр хөдөө аж ахуйн

үйлдвэрт малчдын амьдралыг өөд нь татах энэ зохистой ажил амьдралыг бий болгоход төрийн оновчтой зөв бодлого, зохицуулалт хэрэгтэй байгаа юм аа. Тийм учраас энэ хуулийг санаачилсан, би санаачлагч гишүүний нэг мөн. Тэгээд энийг бол ингээд цаашаа дэмжээд, ингээд цаашаа аваад явах ёстой гэж ингэж байгаа.

Хоршооны хууль гээд бас өргөн баригдаад яах вэ, Хоршооны хуульд өөрчлөлт оруулах тухай ингээд л явж л байгаа л даа. Тэгэхээр энэ хуулиараа зохицуулж байгаа харилцаа бол бусад хуулиар зохицуулсан харилцаатай давхцал үүсэхээр байна гээд ЗГ санал өгчихсөн байсан. Энийг хэр зэрэг анхаарч үзэж байгаа вэ? Би Лүндээ даргаас энийг асууя гэж бодъё бодож байгаа.

Анхдагч хуулийн хувьд бол бас хуулийн төсөл боловсруулах энэ шаардлага хангахгүй байна гэсэн ийм 2 гол шаардлагыг Засгийн газар өгсөн байгаа юм. Тэгэхээр энэ хуульдаа та нар энийг яаж зохицуулъя гэж бодож байгаа вэ гэсэн нэг ийм асуулт байна.

Энэ ер нь энэ холбоонд бол мэдээж бүх малчид элсээд явчихгүй л дээ. Тэгээд ямар ч байсан олон хоршоо холбоод, холбоо үүснэ. Тэгэхээр энэ холбоо хоорондын харилцаа ер нь ямар байх юм бол доо? Холбоонд ороогүй улсуудын хоорондын харилцаа ямар байгаа юм бол доо. Тэгээд энийг би бас анх энэ хуулийн төсөл дээр гарын үсэг зурж, санаачлахдаа бас энийг хэлж байсан юм. Тэгээд энийг яг та нар юу гэж бодож, яаж тооцож байгаа юм бол доо гэж ингэж асуулт байгаа юм. Ийм асуулт байгаа юм.

Энэ ерөөсөө хамгийн хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хамгийн том эрсдэл бол юу гэхээр ерөөсөө газрын асуудал, бэлчээрийн асуудал байгаа юм. Энэ бэлчээрийн зохицуулалтууд ер нь хоорондоо энэ хоршоодын, холбоодын

хооронд, холбоонд ороогүй улсуудын хоорондын энэ зөрчил энэ бэлчээр дээр гарах юм биш байгаа гэсэн, бэлчээрийн асуудлыг л зөв бид нар зохицуулж чадах юм бол энэ хууль амжилттай цаашаагаа явна аа. Ер нь энэ хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд нэг жалгын нэг тарчихсан байгаа малчдыг бол тодорхой тийм зохион байгуулалтад оруулж, хамтарч хөдөлмөрөө хорших, бүтээгдэхүүнээ тэр зах зээлийнх нь тэр сүлжээнд нь хүргэж худалддаг энэ харилцааг л бий болгохгүй бол хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд өнөөдөр үр ашиг гарахгүй.

Сая ингээд л гурил гээд л ярьж байгаа. Явж явж ченжүүдийн гараар дамжаад л сүлжээд л ложистик гэж явсаар байгаад л энэ чинь өндөр үнэтэй болчихож байгаа шүү дээ. Одоо ноолуурын асуудал байна, махны асуудал байна. Энэ Монгол Улсын жишээ нь, энэ эдийн засгийн инфляцын гол эх үүсвэр нь энэ мах, гурил, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн дээр байгаа байхгүй юу. Тэгэхээр өнгөрсөн 30 жилийн хугацаанд бид нар энэ сүлжээг бол байгуулж чадаагүй, хаячихсан. Тэгэхээр малчид бол энэ холбоогоо үүсгээд ингээд ирснээрээ энэ сүлжээгээ үүсгэдэг, зөв л юм руу л явж байна л гэж ойлгож ... /минут дуусав/

Г.Занданшатар: Данзангийн Лүндээжанцан доктор хариулъя.

Д.Лүндээжанцан: Баттөмөр гишүүний асуултад ажлын хэсгээ төлөөлж хариулъя. Манай ажлын хэсэгт Монгол Улсын ХААИС, Хөдөө аж ахуйн шинжлэх ухааны академи, тэгээд МУИС, ШУТИС, Шинжлэх ухааны академи, олон эрдэмтэн, судлаачид мал аж ахуйн чиглэлийн хүрээлэнгүүдийн хүмүүс оролцсон. Дээр нь малчидтайгаа ёстой их санал солилцсон.

Яг Баттөмөр гишүүний ярьдаг асуудлуудыг ярьдаг юм байна. Мал бүхий иргэд яах юм бэ. Улаанбаатарт эзэн нь байдаг 5, 6 мянган малтай энэ компанийн

эздийн малыг яах юм бэ гэх мэтчилнээр олон асуудал. Дээр нь ингээд нөхөрлөл юу, Малчдын холбоонууд байгуулагдчихсаны дараагаар шинэ хүмүүс орох гээд Улаанбаатараас ч юм уу, төв суурин газраас малчин болох гээд ирэхээр тэд нарыг яах вэ гэх мэтчилний асуултуудыг жагсааж бичиж байгаад энэ зохицуулалтуудыг нь хийж өгөхийг оролдсон. Энэ дотор шууд тэгээд ирвэл ингэнэ гэсэн зүйл байхгүй ч гэсэн жил болгон сумын Засаг даргатай тэр малчдын холбооныхон бэлчээр эдэлбэрийн газрын гэрээ байгуулна, зураглалууд нь гарна. Тэр дотор бусад ороогүй малчдынх нь бэлчээр ингээд хуваарлагдаад бас тэр нь бэлчээрийн хуулиар бас зохицуулагдах зүйлүүд бий.

Тэгээд, ер нь цаашидаа бид ер нь зохион байгуулалтад ороод хамтраад ган зудын эрсдэл, байгалийн эрсдэлээс сэргийлэхийн тулд, мал сүргээ авран хамгаалахын тулд, үүлдэр угсааг нь сайжруулахын тулд, ашиг шимийг нь нэмэгдүүлэхийн тулд, үнэ өртгөөс орлогоо дээшлүүлэхийн тулд юу хийж болох вэ гэдэг бүх л зүйлээр хамтарч ярилцдаг, зөвлөлддөг, бие биедээ хяналт тавьдаг, шаардлага тавьдаг, зовлон жаргал тохиолдсон үед нь хамтарч хуваалцдаг ийм л коммунисти маягийн ийм нөхөрлөл бол хэрэгтэй байна. 30 жил 1932-оос хамтрал коммунист 60 он хүртэл явсан нэг үе байна. 60 онд нэгдэлжих хөдөлгөөнөөс 91 он явсан нэг үе байна. Гэтэл 30 хэдэн жилд энэ малчдын, мал аж ахуйн хамтын менежмент гэдэг юм орхигдчихсон байна. Үүнийг л олж харж хуульчилж өгөх нь зүйтэй гэж УИХ удирдлагаас үүрэг өгсний дагуу энэ байна шүү дээ, өнөөдөр зудын дараа орж ирж байгаа зүйл биш. Энэ сүүлийн 2 жил яригдаж, судлагдаж, сүүлийн 5 сар энэ дээр ажилласан. Ингээд ямар ч байсан орж ирж байгаа юм.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууна.

Б.Баттөмөр: Ер нь бол Монгол Улсад энэ малын сүргийн бүтэц алдагдаад малын чанар муудчихсан байгаа шүү дээ. Малын чанар муудсан нэг жишээ нь энэ байгалийн энэ гамшигийг сөрөх чадвар бол муудчихсан. Тэгээд цаашаагаа чанар муудна гэдэг маань үр ашиг муудаж байгаа. Үр ашиг муудна гэдэг бол нөгөө бүтээмж гэдэг юм бас байхгүй, буурч байгаа. Энэ бүтээмжийнхээ бууралтыг өнөөдөр яаж байна гэхээр малчид малын тоогоо л нэмэгдүүлж байгаа. Малын тоо нэмэгдсэн нь бол байгальд сөргөөр нөлөөлдөг ийм л зүйл болчихсон байгаа юм л даа. Тэгээд энэ болгоныг ингээд зүгээр зах зээлд найдаад хаячих юм бол ямар ч үр дүн гарахгүй.

Монголын төрийн бодлого, төрийн оновчтой зохицуулалт л гэж дутагдаад байгаа юм л даа, Монгол Улсад бүх салбарт. Тэгээд манай зарим улсууд төр битгий оролц л гээд байгаа юм. Тийм юм дэлхийд хаана ч байхгүй.

Г.Занданшатар: Санал хэллээ. Даваажанцангийн Сарангэрэл гишүүн асуулт асууна.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Байгалийн гамшиг, цас зуд нэг л өдөр малчин хүний олон жилийн хөдөлмөрийг, амьжиргааны эх үүсвэрийг үгүй хийдгийг бид нар бүгд харж байна л даа. Тийм ч учраас энэ Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль орж ирлээ гэж ойлгож байна.

Улсын Их Хурлын гишүүд маань энэ асуудалд өөр өөрийн байр суурийг илэрхийлж байна. Би энийг сайн хэрэг гэж бодож байна. Маргаан гэхээсээ илүүтэй. Асуудалд өөр өөрийн өнцгөөс хандаж байгаа байх. Эцэстээ бид нэг л юмны төлөө явж байгаа учраас хууль санаачлагч, эрдэмтэн мэргэд, ажлын хэсгийнхэн анхааралдаа аваад, цаашид улам боловсронгуй болгох талд нь анхаарах нь зүйтэй байх гэж бодож байна.

Миний хамгийн гол хэлэх гэж байгаа зүйл бол тэр Батсуурь гишүүн ч хэлсэн, Сандаг-Очир гишүүн маань ч хэлсэн. Малчдыг зохион байгуулалтад оруулахыг хэн ч эсэргүүцээгүй байна. Харин хэрхэн яаж хоршоо болгон зохион байгуулах юм, хэн нь санаачлах юм, хэн нь хэнтэйгээ нийлэх юм гэдэг нэг тийм амьдралд хэрэгжих тэр боломж үндэс суурь нь бас 1 дүгээрт, харагдахгүй байна.

Хоёрдугаарт, энэ яг малчдын хүссэн хүлээж байгаа зүйл мөн үү, үгүй юү. Үүнийг маань та нар бас нэг хариулаад өгөөч гэж.

Хоёрдугаарт, энэ цаг зудын дараа Батжаргал гишүүн ээ, нэг ийм хотын иргэдээс ч ер нь нэлээн тийм яриа түлхүү гарсан нь юу вэ гэвэл ерөөсөө Монгол Улсын малын тоо их байна. Эрчимжүүлсэн мал аж ахуйг хөгжүүлбэ, ерөөсөө фермерийн аж ахуй руу орё гэж. Үгүй ээ, энэ хэр зөв хандлага юм бэ. Яах вэ, мал, мал гэдэг хувийн өмч, ойлгож байна. Тэгэхдээ энэ малчид маань Монгол Улсын нийт иргэдийг өдөр тутмын хүнсний гол бүтээгдэхүүнээр нь хангаж байгаа. Хамгийн гол манай малчдын маань үүрэг юу вэ гэвэл өргөн уудам нутгаа эзэндээ байлгах, хамгаалах төрийн функцийг хуваалцаж байгаа. Тийм учраас тэдний маань маллаж байгаа малыг бид Үндсэн хуулийн хамгаалалтад оруулж авч үздэг гэж бодож байгаа юм. Тэгэхээр энэ хандлага ер нь сүүлийн үед их цухалзаж байгаа учраас манай ажлын хэсэг болон хууль санаачлагчид юу гэж үзэж байгаа юм бэ гэдгийг би бас асуумаар байна.

Хамгийн гол нь бүс нутаг болон аймгийн онцлогт тохирсон, эрсдэлээс хамгаалах тэр менежмент, тэр зохион байгуулалт л би хамгийн чухал гэж бодох юм. Тэр хаашаа хороо нь байдаг юм уу, юу байдаг юм. Энэ сургалтууд нь нэлээн хэрэгтэй байгаа юм биш үү?

4 дүгээрт, хэлэх гээд байгаа зүйл. Уг нь энэ цаг зуд чинь гэнэт бий болоогүй шүү дээ. Энэ дээр Цаг уурын эрдэм шинжилгээний газар, хамгийн гол нь ХХААЯ, орон нутгийн засаг захиргаа үүнийг яагаад урьдчилан сэргийлүүлэх, мэдээлэх, тийм ээ, бас энэ эрсдэлээс хамгаалах багахан ч гэсэн боломжийг бүрдүүлэх чиглэлд нь малчидтайгаа хамтарч ажиллаагүй вэ? Үүнийг хамгаалсан ийм хууль, эрх зүйн өөрчлөлтийг та бүхэн маань төсөлдөө оруулж байгаа юу? Энэ 4 асуултдаа би хариулт аваад, тодруулъя гэж бодож байна. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Хэн хариулах вэ? Батжаргал дарга хариулъя.

Ж.Батжаргал: Малчин өрхийн холбоонд байгуулах үйл ажиллагаа энэ хуулиар зохицуулагдчихсан л даа. Манай малчид өөрсдөө. Ерөөсөө энэ бэлчээрийн мал аж ахуйд гэдэг юм уу энэ нүүдлийн мал аж ахуйд нэг л суурь зарчим байгаа юм. Бэлчээрээ бид нар дундаа ашиглаж байгаа. Тийм учраас нэг гол усаараа амь санаагаа нэгтгэх тухай асуудал байгаа. Тийм учраас тэр үзэл санаа дээр нь тулгуурлаж энэ хуулийн үзэл санаа бууж ирсэн гэдгийг зориуд хэлэх ёстой гэж, 1.

2 дахь зүйл. Бүс нутгуудад янз бүр, янз бүр юмнууд байгаа. Бид нэгдсэн 1 зохицуулалтын тухай ярьж байна. Бүс нутагтаа нийцэх байдлаараа асуудалдаа хандаад явах ёстой. Тэгэхээр тэр орон зайг нь бид энэ хуульдаа бий болгож өгч чадсан гэдгийг хэлэх ёстой болов уу гэж бодож байна.

Үгүй ээ, ер нь цаг үе өөрчлөгдөж байна. Түүнийг дагаад мэдээж бүтээмжийн тухай, үр ашгийн тухай асуудал яригдах ёстой. Тийм учраас бид нар энэ мал аж ахуйн салбараа өөрийг нь бүтээмжтэй үр ашигтай салбар байлгах тухай асуудал байгаа. Гэхдээ хэт туйлширч боломгүй ээ. Тэгэхээр зэрэг

тодорхой газар тариалангийн бүс нутагтаа тэр өндөр ашиг шимтэй эрчимжсэн МАА буюу тэр суурин мал аж ахуйгаа хөгжүүлж болно. Бусад бүс нутагтаа бид яах аргагүй энэ байгаль, цаг ууртаа дасан зохицсон, тэсвэр чанартай, тэгээд бас үр ашиг арай ахиу өгч болдог тэр нутгийн шилмэл омог дээр нь тулгуурлагдсан мал үржлийн үйл явц нь явагдаад, тэгээд энэ нүүдлийн мал аж ахуйнхаа үйл ажиллагааг тогтвортой хадгалах ёстой. Энэ бол бид нарын өв соёлоо, амьдралын хэв маягаа хадгалж хойч үедээ өвлүүлэх үйл явцын маань л нэг. Үүнийг би ингэж л энэ л талаасаа ойлгодог гэдгийг хэлье.

Гамшиг аливаа юмнууд гэнэт ирэхгүй л дээ. Угаасаа зун нь ямар байсан, түүнийг дагасан намаржилт, тэгээд өвөлжилт, хаваржилтын л тухай л асуудал байгаа. Тэгэхдээ жилээс жилд ний нуугүй үнэнийг хэлэхэд байгалийн хадлан бэлтгэх, барих юмнууд хумигдаж байгаа. Хадлан авдаг байсан бүс нутгуудын асуудал өөрөө хадлан бэлтгэж авахад тийм бололцоогүй байдал руу ороод байгаа. Тийм учраас бид зөрүүлээд таримал тэжээлээр малынхаа тэжээлийн бааз суурийг хангаж авах тухай л асуудал байгаа. Энэ рүүгээ бүх нийтийн анхаарлыг чиглүүлээд явж байгаа. Ингэхийн тулд хүн болгон дуртай газраа хагалаад тэжээл тарь гэж хэлж болохгүй байгаа юм. Тэр таримал тэжээл чинь өөрөө бас ямар хөрсөнд ургадаг вэ, ямар технологи ашигладаг вэ, яаж арчилж хамгаалдаг вэ гээд өөрөө нарийн ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Ажлын хэсэг нэмж хариулъя. Ажлын хэсгийн ахлагч Лүндээжанцан хариулъя. 4 номерын микрофоныг өгье. 4 номерын микрофоныг өгье.

Д.Лүндээжанцан: Сарангэрэл гишүүний асуултад хариулъя. Түүний өмнө талд Баттөмөр гишүүн бас нэг давхцалын тухай асуусан байгаа. Тэгэхээр

энэ давхцал энэ салбарт ер нь мал аж ахуйн салбарт хамгийн их гол рольтой үйлчилж байгаа 18 хуулийн жагсаалтыг ингэж гаргаж байгаад, тэгээд давхцалыг нь ингэж харсан. Тэгэхэд байна шүү дээ, энэ анхдагч хууль учраас гол зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэл 4 үндсэн чиглэлийг бол бичихэд тэр хуулиудаас зарим заалтууд наашаа орж ирнэ ээ. Гэхдээ тэр хийх ажлууд нь юм чинь оруулахаас аргагүй байна шүү дээ. Гэхдээ тэр болгоныг яг тэр байдлаар нь хуулахгүй ээ. Хууль зүйн техникийн хувьд нэр томъёог нь жигдлэх ийм асуудлууд байсан гэдгийг хэлье.

Хоёрт нь, энэ Сарангэрэл гишүүний энэ асуултын хувьд яг тантай санал нэг байгаа юм. Үнэндээ бид байна шүү дээ, одоо бодлого гаргаж болно, үзэл баримтлал хийж болно, ярьсаар байгаад хугацаа алдчихсан. Одоо дахиад 6 жил болоход байна шүү дээ, Монголын бэлчээрийн даац тэр нүүдлийн МАА оршин тогтноход хэцүү болчих гээд байгаа байхгүй юу. Одоо үүнийг цаг мөчтэй уралдаж нэг юм хийж чадаад, энэ холбогдох хуулиуддаа өөрчлөлт оруулаад хийж чадвал бас нэг 70, 80 хувийг нь эргээгээд байна шүү дээ, тийм үү, бас бүрэн сэргэдэггүй юм гэхэд тэр бэлчээрийн талхлагдлаас хамгаалаад энэ нүүдлийн мал аж ахуйн насыг уртасгах боломж байна гэж үзэж байгаа учраас бидэнд, манай Монгол Улс үнэхээр бахархмаар өвөг дээдэс маань үлдээжээ. Өргөн уудам газар нутагтай тулдаа өдий хүргэчихсэн байхгүй юу. Бусад оронд аль насанд зүйл дуусаад нүүдлийн МАА түүх болоод хоцрох байсан. Энэ манай хөршүүдийн туршилагаас тэр манайхан телевизээр харж л байгаа байх ... /минут дуусав/

Л.Мөнхбаатар: Хариулт хангалттай юу.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Тэмүүлэн гишүүн, Бейсен гишүүнээр

тасаллаа. Төсвийн байнгын хороон дарга Ганзоригийн Тэмүүлэн үг хэлнэ.

2 гишүүн үг хэлсний дараа санал хураалт явагдах тул гишүүд танхимд орж ирье.

Г.Тэмүүлэн: Тэгэхээр энэ Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хууль би өөрөө бас яг энэ хуулийн төслийн санаачлагчийнх нь хувиар тодорхой хэд хэдэн зүйлүүдийг бас хэлье хэлье гэж бодож байна.

Тэгэхээр үндсэндээ бол Монгол Улс өөрөө энэ мал аж ахуйн орон. Манай эдийн засгийн маань тулгуур салбар болсон энэ салбарыг бас бид нар бодлогоор төрийн зүгээс дэмжих зайлиггүй шаардлага бол байгаад байгаа.

Нөгөө талдаа бид нар энэ салбарынхаа эрх ашгаас гадна энэ салбарт ажиллаж байгаа энэ 300 мянган малчдын эрх ашгийг хамгаалах, дээрээс нь юу гэдэг юм, энэ үйлдвэрлэлийг дэмжих бодлого, энэ салбарт ажиллаж байгаа хүмүүсийн боловсрол, эрүүл мэнд болоод нийгмийн баталгаа, амьжиргаа орлогыг нь дэмжих энэ цогц бодлогын шийдлийг бол нэг талдаа гаргах зайлиггүй шаардлага бол байгаа. Энэ дээр ний нуугүй Монголын ард түмэн бүгдээрээ энд сууж байгаа Улсын Их Хурлын гишүүд ч гэсэн бүгдээрээ би бас хүлээн зөвшөөрч байгаа гэдэгт итгэлтэй байгаа. Тэр дундаа энэ жилийн цаг уурын нөхцөл байдал, зуд турхны дараа бол бид нар маш том бодлогын өөрчлөлт, хандлагын өөрчлөлт, шинэчлэлтийг бол энэ салбарт бол зайлиггүй эхлүүлэх шаардлага байна л гэдэг зүйл бол байгаа.

Тэгэхээр төрөөс нэг талдаа энэ үйлдвэрлэлийг дэмжих, мал аж ахуйн салбарыг дэмжих, хүнсний бааз суурь болсон энэ салбарыг тулгуур салбарыг бодлогын хүрээнд дэмжих шаардлагын хүрээнд бол бид нар энэ хамтын санаачилга хоршил нэгдлийг бий болгох

зайлиггүй шаардлагатай байгаад байгаа юм. Хамтын хоршил болоод нэгд ер нь аливаа энэ хамтын хүч, хамтын оролцоо, хамтын менежмент, хамтын зохион байгуулалт гэдэг бол дандаа амжилтад хүрдэг. Нэгдсэн, нийлсэн, хорисон, хамтарсан, эвлэлдэн нэгдсэн болгоноос бол дандаа л амжилт гардаг. Бизнес ч тэр, аль ч салбарт ялгаа байхгүй. Тэгэхээр ерөөсөө бид нар зөвхөн зүгээр энэ холбооны тухай хууль, энэ 300 мянган малчид бүгдээрээ нэгдэж нийлж эрх ашгаа хамгаалдаг болооч ээ. Бодлого зарчмаа, үзэл баримтлалаа гаргадаг болгооч ээ. Энэ дээр суурь асуудлуудаа гаргаж тавьж төр засагтаа хүргэдэг болгооч л гэдэг суурь зарчмын хүрээнд бол бид нар энэ хуулийг бол дэмжиж байгаа юм. Энэ бол цэвэр мал аж ахуйн салбар дотроо малчдын энэ засаглал тогтолцоог бүрдүүлж байгаа, өөр өөрсдийнхөө эрх ашгийг хамгаалахын төлөө эвлэлдэн нэгдэж нийлэх энэ л суурь зарчмыг тавьж гарч ирж байгаа юм.

Өнөөдөр газар тариалангийн холбоо гэж байгаад байна. Газар тариаланчид ч нэгдэж нийлж асуудлаа төр засагтаа хүргэж байна. Засгийн газарт хүргэж байна. Уяачдын холбоо гэж байгаад байна. Өөрсдийнхөө дур сонирхлын үндсэн дээр, өөрсдийнхөө сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж, нийлж салбарынхаа асуудлыг гаргаж шийддэг энэ суурь засаглал тогтолцоо бол 1 дүгээрт, зайлиггүй шаардлагатай.

Би 2 дугаарт, энэ засаглал тогтолцоо бол зүгээр суурь асуудал. Нөгөө талдаа бид нарын хувьд манай гишүүдийн маань асуугаад байгаа зүйл бол яриангүй үнэн. Бид бүхний хувьд энэ малчны энэ ажил амьдралыг нь бид нар яаж дээшлүүлэх юм бэ? Амьжиргаа орлогыг нь бид нар хэрхэн дэмжих юм бэ? Энэ эрүүл мэнд, нийгмийнх нь баталгааг нь хэр хэрхэн хангах юм. Мэдлэг, боловсролыг нь хэрхэн дэмжих юм. Энэ малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний чанарыг хэрхэн

нэмэгдүүлэх юм гэдэг энэ асуудлуудыг бол бүгдээрээ гаргаж ирж тавиад байгаа. Тэгэхээр үүнийг бол шийдэх шийдэл нь бол ирэх 7 хоногт бид нар энэ Малчны тухай хууль гэдэг хуулийн төслийг бол өргөн барихаар ингээд хуулийн төслийг боловсруулаад явж байна. Цогцоороо Малчны тухай хууль тэр энэ холбооны тухай хууль тэр нэг талдаа бол энэ өөрөө том бодлого болоод засаглал тогтолцоо, эрх зүйн орчны томоохон бодлогын өөрчлөлт болно.

Ингэж байж бол цаашидаа бид нар энэ Монгол Улсын мал аж ахуйн салбар тогтвортой оршин тогтнох, эдийн засгийнхаа үр өгөөж болоод малчин хүний хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх боломж бололцоо бол суурь энэ бодлогын бичиг баримтуудын хүрээнд бий болно гэдгийг бол би бас онцлон хэлэх гэсэн юм.

Тэгээд гишүүд энэ үндсэн дээр бас хуулийн төслүүдийг бүрэн дэмжиж байгаа гэдэгт итгэлтэй байгаа. Дараагийн 7 хоногт ч гэсэн орж ирэх Малчны тухай хуулийн цогц бодлогын төслийг ч гэсэн та бүхэн бас дэмжээрэй гэдгийг бас эцэст нь уриалж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Л.Мөнхбаатар: Ганзоригийн Тэмүүлэн гишүүн дэмжиж үг хэллээ. Хууль санаачлагчдын нэг байгаа. Одоо Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен үг хэлнэ. Дараа нь санал хураалт явагдана шүү.

Б.Бейсен: Энэ Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм. Энэ хуулийн хэрэгжилтийн асуудал бас учир дутагдалтай байна. Сум, багийн түвшинд. Одоо ер нь хуучин багийн төв гээд байсан, багийн дарга, эмч, малын эмч нар бүгд цалинтай ажилчин шүү дээ. Гэтэл багийн төвийн тэр төв гэж байхгүй болсон. Багийн дарга ч гэсэн нэг цалинтай малчин, мянгат малчин болсон зарим нь. Багийн эмч ч нэг уулын мухарт,

малын эмч ч нэг уулын мухарт, төвлөрсөн юм байхгүй. Бодит байдал ийм байгаа. Тийм учраас үүнийг хуучин багийн энэ үнэхээр нэгдсэн холбоо байгуулах гэж байгаад багийн төвийг нэгтгэн шинэчлэх асуудал дээр анхаарахгүй бол болохгүй нь ээ.

Эмнэлгийн тусламж авахад, зарим нэг тодорхойлолт авахад, тэгээд малчдынхаа л айлын мухарт явдаг. Багийн төв гэж тодорхой бичиг баримт бүрдүүлэх тийм газар байхгүй.

Нөгөө талаар энэ томоохон багийн төвийн малчид эмнэлгийн тусламж авч чадахгүй, их эмчийн салбартай байсан тэрийг нь татан буулгаад хаячихсан. Та бүгд Таван богд явж байсан байх. Хөх хөтөл баг гээд байдаг, 3 мянган хүн амтай. Их эмчийн салбартай байсан, соц нийгмийн үед. Сургуультай, цэцэрлэгтэй тэнд. Сургуульд нь 460 хүүхэд сурдаг, дотуур байранд 180 хүүхэд байдаг. Гэтэл их эмчийн салбарыг нь татан буулгаад, аймгийн төв рүүгээ юу сумын төв рүүгээ нэгтгэчихсэн. Ялангуяа багийн төвүүд дээр аптека байхгүй. Эрүүл мэндийн салбар эмийн салбар 100 жил болоход багийн төвд эм байхгүй. Хөнгөлөлттэй эмээ авахын тулд сумын төв орох юм уу, аймгийн төв ордог. Тэгээд эмнэлгийн тусламж авах энэ эрхийг нь сэргээхийн тулд үүнийг бас энэ хуульдаа тусгаж өгөх нь зөв байх гэдэг асуудал хэлье.

Малчдын хадлан хадах эрхийг тусгай хамгаалалттай газар гэдэг утгаараа төлбөр төлж хаддаг болсон. Ачит нуурын сав газраас Ногоон нуур, Баян-Өлгий аймгийн ихэнх сумд хадлан хаддаг. Гэтэл тусгай хамгаалалттай газар Увс руу оруулчихсан. Газар нутаг нь яах аргагүй Баян-Өлгий аймгийн газар нутаг. Тэгсэн мөртөө татвар төлөөд хадлан хаддаг. Хуучин соц нийгмийн үед та бүгд мэдэх байх, тэнд Ногоон нуурын тэжээл аж ахуй гээд байсан. Тийм учраас ийм асуудлыг шийдэхгүй бол болохгүй нь

ээ. Баяннуур сумд мөн адилхан. Одоо энэ Эрдэнэбүрэнгийн УЦС гэдгээр 400-аад айлын хадлан юунд орох гээд байна. Усан доогуур орох гээд байна. Одоо 400-аад айлын хадлангийн асуудал энэ ойрын хэдэн жил шийдэгдэхгүй л дээ. Тийм, өвс тэжээл тариалах газар ч байхгүй. Энэ асуудлуудыг яах юм тэгээд. Ер нь ийм юмнуудыг хуулийн төсөлд тусгахгүй бол сая миний ярьдаг тэр Улаанхус сумын Хөх хөтөл баг, Цэнгэл сумын Загаст нуур баг эд нар их эмчийн салбарын асуудлыг салбарын яамтай тохирч байж, хүн амын тоогоор нь их эмчийн салбар байгуулж өгөхгүй бол болохгүй. Жишээлбэл Ногоон нуур сумын Ховд баг, Улаанчулуу баг их эмч, одоо бид нар жилийн энэ 4 жилд төсвийг нь батлаад эмнэлэг нь баригдсан мөртөө их эмч байхгүй. Төсөв нь хуваарилагдахгүй, ард иргэд эмнэлгийн тусламж авахгүй ийм байдалд байна. Аймгийн төв рүү явж байна, 90 км яваад аймгийн төв рүү орж байна шүү дээ. Энэ асуудлыг бас хуульдаа тусгаж өгөөд, Лундээжсанцан дарга аа, бас анхаарахгүй бол энэ эрх зүйн байдлын тухай хууль дээр чинь тодорхой хэмжээгээр тусгахгүй бол бас эрх нь зөрчиж байгаа асуудал байгаа шүү гэдгийг хэлье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд үг хэлж дууслаа.

Одоо санал хураалт явуулна. Гишүүд танхимдаа орж ирээрэй. Бүлгийн дарга нар ирцээ бүрдүүлье.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч, дэмжсэн, дэмжээгүй үг хэлж дууссан.

Одоо санал хураалт явуулна.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Байнгын хорооны саналаар Малчин өрхийн холбооны эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын

засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Малын тоо толгой, албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Боловсролын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Хориооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Амьтны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгалийн ургамлын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчныг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Тогтоолд нэмэлт оруулах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёолоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулъя.

22 гишүүн дэмжиж, 59,5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороонд шилжүүлж байна.

Одоо Даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Одонтуяа дарга хурал чинь бэлэн биз дээ, тийм ээ.

14 цагаас Ерөнхий сайдын мэдээлэл.

Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын Пи Си 2022 үнэлгээний Монгол Улсын үр дүн бодлогын зөвлөмжийн талаар Ерөнхий сайдын мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны

сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан танилцуулна. Энэ мэдээлэл дээр.

14 цаг хүртэл завсарлалаа.

ЗАВСАРЛАГА

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын чуулганы үдээс хойших хуралдаан эхэллээ. Монгол Улсын Ерөнхий сайдын мэдээллийг хэлэлцэнэ. Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA 2022 үнэлгээний Монгол Улсын үр дүн бодлогын зөвлөмжийн талаар хэлэлцэнэ ээ. Энэ зөвлөмжийн бодлогын зөвлөмжийн талаар БСШУ-ны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан мэдээлэл хийнэ. Таныг индэрт урьж байна. Ажлын хэсгийг оруулаарай. Ажлын хэсгийн гишүүдийн нэрсийг аваад ир. Энх-Амгалан сайдыг индэрт урьж байна.

Л.Энх-Амгалан: Улсын Их Хурлын дэд дарга,

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас зохион байгуулдаг суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA-22 үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаар Улсын Их Хурлын чуулганд мэдээлэл хийе ээ.

Монгол Улс 2050 онд нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлт, иргэдийн амьдралын чадвараар Азид тэргүүлэгч орнуудын нэг болох зорилго бүхий алсын хараа-2050 урт хугацааны хөгжлийн бодлогыг баталж тус бодлого хэрэгжих суурь нөхцөлийг бүрдүүлэх эдийн засгийн тусгаар тогтнол бие даасан байдлыг хангах шинэ сэргэлтийн бодлогыг Засгийн газраас дэвшүүлэн хэрэгжүүлж байна аа.

Эдгээр урт хугацааны бодлого эдийн засгийн шинэчлэлтийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжих эсэх нь манай улсын хүний нөөцийн бүтээмж мэргэжилтний чанараас ихээхэн хамаарна аа. Энэ утгаараа ч Монгол Улс боловсролын хүртээмжээр өндөр орлоготой улсуудын ижил түвшинд хүрэхийг зорьж байна. Энэ чиглэлээр хийгдсэн олон улсын судалгаа тайлан мэдээнүүд хангалттай байдаг. Тухайлбал Дэлхийн банкнаас 2022 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын иргэдийн боловсролд хамрагдсан хугацаа нь 13.2 жил байгаа нь дундаас доогуур орлоготой орнуудын дунджаас давж өндөр орлоготой орнуудынхаас бага зэрэг дээгүүр байна аа.

Харин боловсролын чанарын үзүүлэлтээр олон улстай харьцуулсан судалгаа мэдээлэл хязгаарлагдмал байсаар ирсэн. Монгол Улсын Засгийн газрын 2020-оос 2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.3-д ерөнхий боловсролын сургалтын чанарыг дэлхийн жишигт нийцүүлэх зорилгоор олон улсын PISA үнэлгээнд хамруулж үндэсний чанарын үнэлгээний тогтолцоог бэхжүүлнэ гэсэн зорилтыг тусгасан бөгөөд Монгол Улс боловсролын чанараа олон улстай харьцуулах түүнд нөлөөлж буй хүчин зүйлээ бодитой тодорхойлох, үр дүн, баримт нотолгоонд суурилан тулгуурлан бодлогын арга хэмжээ авч хэрэгжүүлэх зорилгоор олон улсын суралцагчийн сурлагын амжилтын үнэлгээ, PISA-22-т анх удаа оролцоо. PISA үнэлгээг эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллага 2020 оноос эхлэн 3 жил тутам зохион байгуулж ирсэн бөгөөд суурь боловсрол эзэмшсэн 15 настай суралцагч танхимаар олж авсан математик, унших болон байгалийн ухааны мэдлэг чадвар амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа, тухайн улсын боловсролын тогтолцоо энэ чадварыг ямар хэмжээнд олгож байгааг тандан судалдаг сурлагын амжилтын олон улсын үнэлгээ юм аа.

Энэ удаагийн үнэлгээгээр үнэлгээ PISA-22-т 81 улс оролцсон бөгөөд 2022 оны 4 сарын 5-аас 5 дугаар сарын 15-ны хооронд 15 настай 7-оос 12 дугаар ангийн сурагчдаас унших математик, байгалийн ухаан, бүтээлч сэтгэлгээний компьютерт суурилсан шалгалтыг 2 цагийн хугацаатай зохион байгуулж авсан. Монгол Улсын хэмжээнд түүврийн аргаар сонгогдсон 196 сургуулийн 7276 суралцагч уг шалгалтад хамрагдаж математик, байгалийн ухаан унших, бүтээлч сэтгэлгээний даалгавар, сурлагын амжилтад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох асуулгыг хийж гүйцэтгэсэн. Үнэлгээнд хамрагдсан суралцагчид нь Монгол Улсын өөр өөр бүс нутаг, байршил, хот, аймаг, сум, сургуулийн хэв шинж буюу төрийн, хувийн, ерөнхий мэргэжлийн боловсролын сургуулиудыг төлөөлөн оролцсон. Монгол Улсын PISA-д оролцох ажлыг Дэлхийн банкнаас санхүүгийн дэмжлэг, эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын техникийн дэмжлэгтэйгээр зохион байгуулсан. Монгол Улсын гүйцэтгэлээс дараах дүгнэлтүүд гарч байна аа.

Үүнд:

Математик оролцогч 81 орноос Монгол Улс 425 оноогоор 47-д жагсаж байна. Монголын суралцагчид Тайланд, Гүрж, Узбекистан, Камбож зэрэг харьцуулагч орноос хамаагүй өндөр оноо авсан төдийгүй жишиг улс Казахстантай харьцуулахад гүйцэтгэл өндөртэй байна аа. Гэсэн хэдий ч Монгол 15 настай суралцагч PISA-д оролцож байгаа эдийн засаг хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагуудын орнууд болон Азийн орнуудын үе тэнгийнхний дунджаас нэлээд хоцорч байгаа тул цаашид сурлагын амжилт ахиулах бодлогын арга хэмжээг цаг алдалгүй хэрэгжүүлэх шаардлагатай байна аа. Монгол сурагчдын 50 орчим хувь буюу математикийн суурь түвшин болон Левел

2-т хүрэхгүй байна. Энэ нь Монголын 15 настай 2 сурагчийн нэг нь математикийн суурь түвшинд хүрээгүй байна гэсэн үг юм. Энэ нь эдийн засаг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагын дундаж 9 хувь, Азийн орнуудын дундаж 11 хувьтай харьцуулахад Монгол Улсын сурагчдын дөнгөж 2.3 буюу 160 орчим нь л Top 5, 6 үнэлгээнд үнэлэгдсэн байна аа.

Унших чадвар болон байгалийн ухаан Монгол Улсын 15 настай сурагчид унших чадварын гүйцэтгэлээр 378, байгалийн ухааны гүйцэтгэл дээр 412 оноо авсан нь Эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллагын унших чадварын дундаж үнэлгээ 476 Байгалийн ухааных 485 болон Азийн дундаж унших чадвар 427 байгалийн ухааных 447-оос харьцуулахад хамаагүй доогуур үзүүлэлттэй байна аа.

Монголд унших чиглэлээр 3 суралцагч тутмын нэг, байгалийн ухааны чиглэлээр 2 суралцагч тутмын нэг нь анхан шатын мэдлэг эзэмисэн байна. Эдгээр үр дүн эдийн засаг хамтын ажиллагааны хөгжлийн байгууллагуудын орнуудын дунджаас хамаагүй доогуур байгаа энэ үзүүлэлтээр 4 сурагч тутмын 3 нь унших чадвар болон байгалийн ухааны аль алиных нь үндсэн мэдлэгийг эзэмисэн байна аа. Эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагуудын гишүүн орнудаас ялгаатай нь Монголд сурагчид унших чадвараа топ гүйцэтгэлийн түвшинд ороогүй гээд байгалийн ухаанаар цөөн сурагчлалд энэ түвшинд үнэлэгдсэн байна аа.

Сурагчдын сайн сайхан байдлын үнэлгээгээр Монголын 15 настай хүүхдүүд ерөнхийдөө амьдралдаа сэтгэл хангалуун байдаг бөгөөд эдийн засаг хөгжил хамтын ажиллагааны хөгжлийн байгууллага болон Азийн дундаж орнуудын үе тэнгийнхээс хамаагүй илүү амьдралын сэтгэл ханамжтай байгаа дүн гарлаа. Гэсэн хэдий ч эдийн засаг хөгжлийн хамтын ажиллагааны

байгууллагуудын орнуудын үе тэнгийнхэнтэй харьцуулахад Монголын сурагчдын 9.7 нь үе тэнгийнхний гадуурхалд тогтмол өртдөг, 21.3 нь ямар нэгэн байдлаар гадуурхалд өртдөг гэж хариулсан байгаа нь эдийн засаг, хөгжлийн хамтын ажиллагааны байгууллагуудаас өндөр, харин Азийн түвшинээс бага үзүүлэлттэй гарсан байна аа.

Боловсрол дахь тэгш байдал Нийслэлийн суралцагчид аймгийн төвийн суралцагчдаас, аймгийн төвийн суралцагчид сумын суралцагчдаас 3 чиглэл тус бүрээр дээгүүр үзүүлэлт үзүүлсэн нь сумын сурагчид хотын сурагчдаас даруй 2 жилийн сургалтын хоцрогдолтой байна. Гэсэн хэдий ч энэ ялгаа нь эхний байдлаар аймаг, хот, сумдын сурагчдын нийгэм эдийн засгийн ялгаатай байршлаас шалтгаалж байна аа. Үндсэндээ Монгол Улсад хотын болон хөдөөгийн сургуулийн ялгаа гарсан байна гэж бид нар ойлгож болно. Хувийн сургуулиудын сурагчид төрийн өмчийн сургуулийн сурагчдаас математик, унших чадвар, байгалийн ухааны гэсэн 3 чиглэлээр 10-аас дээш оноогоор илүү байсан ч математик байгалийн ухааны чиглэлээр хувийн болон төрийн өмчийн сургуулийн ялгаа статистикийн хувьд чухал биш үзүүлэлттэй байгаа бол нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг тооцсоны дараа төрийн өмчийн сургуулийн сурагчид, хувийн сургуулийн үе тэнгийнхнээсээ унших чадвараар хамаагүй өндөр байна. Сургуулийн өмнөх боловсрол нь нийгэм, эдийн засгийн ололт амжилтын зөрөөг арилгахад туслах ба эдийн засаг, хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагуудын орнуудын үр дүнтэй адил. Монголын сургуулийн өмнөх боловсрол дор хаяж нэг жил хамрагдсан сурагчид хамрагдаагүй үе тэнгийнхнээсээ илүү гүйцэтгэлтэй байсан. Гэсэн хэдий ч Монгол Улсын хувьд сургуулийн өмнөх боловсролд хамрагдаагүй эсвэл нэг жилээс бага хугацаанд хамрагдсан 15 настай сурагчдын эзлэх хувь 19 хувь, эдийн засаг

хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага Азийн дундэсийн 6 хувь ба 14 хувьтай харьцуулахад илүү байна аа.

Хүний нөөц болон материалын эх сурвалж.

Чадварлаг багшлах боловсон хүчин дутмагаас болж сургалтын чанар хангалтгүй байдаг сургуулиудад суралцдаг Монголын 15 настай суралцагчдын эзлэх хувь 38 хувь байгаа нь Эдийн засаг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага болон Азийн дундэсийн 25 хувьтай харьцуулахад өндөр байна аа. Монгол Улсын сурагчдын дийлэнх нь 60 хувиас дээш нь сургалтын хэрэглэгдэхүүн материаллаг дэд бүтцийн дутмаг чанаргүйгээс болж сургалтад саад болж буй сургуулиудад суралцдаг байна. Энэ нь Эдийн засаг хөгжлийн хамтын ажиллагааны байгууллага 30 хувь, Азийн дундэжаас 40 хувиас хамаагүй өндөр байна аа. Үүнтэй адилаар манай улсын ихэнх сурагчдын 80 хувь нь дижитал хүний нөөц хомс, чанар муутай захирлуудтай сургуулиуд байдаг гэж үнэлэгдлээ.

Эдийн засаг хамтын ажиллагааны байгууллагууд болон Азийн дундэжаас энэ үнэлэмж үлэмж өндөр байна аа.

Нийгэм эдийн засгийн нөхцөл бололцоо тааруу сурагчид боловсрол эзэмшүүлж буй болон аймаг сумдын сургуулиудын дийлэнх нь цаашид сургалтын ажиллагаандаа шаардлагатай хэрэглэгдэхүүн болон материалын хомсдол эсхүл чанар муутай хэрэглэгдэхүүн ашиглах байдалд өртөх магадлал өндөр байна аа. Монгол Улсад нэг суралцагч суурь боловсрол эзэмшихэд 12600 доллар зарцуулж байгаа нь 81 орноос доороосоо 3-д бичигдэж байна. Гэтэл манай улсаас хэд дахин илүү мөнгө зарцуулдаг улсуудын 15 настай хүүхдийн математикийн гүйцэтгэлд Монгол хүүхдүүдээс доогуур байгаа дүгнэлт үнэлгээнүүд бас гарсан. Нэг хүүхдэд суурь

боловсрол эзэмшүүлэхэд 75 мянган доллароос багагүй мөнгө зарцуулдаг улсуудын хувьд зарцуулсан мөнгө математикийн гүйцэтгэлийн хооронд хамааралтай байгаа нь манай улс боловсролд илүү мөнгө зарцуулах тусам хүүхдийн гүйцэтгэлд өсгөх боломжийг илтгэн харуулж байна аа.

Боловсролд бага хөрөнгө зарцуулах нь дээр дурдсан боловсрол, дэд бүтэц, дижитал нөөцийн хомсдол, чанар хангалтгүй байгаа нөхцөлд хүргэж болзошгүй байна аа. Гэхдээ нэг сурагчид ноогдох зардал бага байгаа хэдий ч Монголын сурагчид тооцоолсноос илүү сайн гүйцэтгэлтэй гарсан.

Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар:

Монгол Улсын Засгийн газраас PISA-2022 оны шалгалтын үр дүнд үндэслэн улсын хэмжээнд боловсролын чанарыг сайжруулах хот хөдөөгийн сургуулийн ялгааг арилгах, сурагчдын бүлгүүдийн амжилтын зөрөөг бууруулах зорилгоор дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна аа. Цэцэрлэг ЕБС-ийн суралцагчдын эх хэл болон унших суурь чадварыг сайжруулахад чиглэсэн зорилт арга хэмжээний төлөвлөгөө батлан хэрэгжүүлэх.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд үнэлгээний үр дүнг тусган хөтөлбөрийн шинэчлэлд оруулах.

Хот хөдөөгийн боловсролын чанарын ялгааг арилгах чиглэлээр ЕБС-д байгалийн ухаан, математик, англи хэлний цахим сургалт цахим сурах бичиг контентын сан нэвтрүүлж, хүртээмжийг нь нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх.

PISA-22 үнэлгээний үр дүнд үндэслэн зорилтот сургуулийн цахим дэд

бүтэц, ухаалаг тоног төхөөрөмж, байгалийн ухааны лаборатори, хэрэглэгдэхүүнээр хангах.

Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжлийн байгууллагатай хамтран боловсролын үнэлгээний тогтолцоог шинэчлэх, цахим үнэлгээг нэвтрүүлэх зэрэг арга хэмжээ авах болно.

Монгол Улс PISA үнэлгээнд оролцоноор 15 настай суралцагчдын эзэмшсэн мэдлэг чадвар амьдралд практикт хэрхэн хэрэглэж байгааг бодитой тодорхойлж үндэсний хэмжээний мэдээллийн сантай болох.

Өөрийн орны боловсролын чанарыг дэлхийн бусад оронтой харьцуулах арга туршилагаас суралцах.

Үр дүнд тулгуурлан боловсролын бодлого шинэчлэлтийн чиглэл, төлөвлөлтийг тодорхойлох, мэргэжлийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх дэмжлэг үзүүлэх, Дагалдах асуулгын хүрээнд хүн ам зүй, нийгэм эдийн засаг, боловсролын салбарын өөрчлөлт шинэчлэлт нь суралцагчдын сурлагын амжилтад хэрхэн нөлөөлж буйг илэрхийлэх зэрэг боломж бүрдэж байгаа юм аа.

Дээрх арга хэмжээг авч хэрэгжүүлснээр сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA үнэлгээнд 2025 онд дахин хамрагдах бэлтгэл ажлыг үндэсний болон орон нутгийн түвшинд гарахаар төлөвлөн ажиллаж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайдад баярлалаа.

Мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ.

Таныг индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дэд дарга,

Эрхэм гишүүд ээ,

Суралцагчдын сурлагын амжилтыг үнэлэх олон улсын PISA-2022 үнэлгээний Монгол Улсын үр дүнгийн талаарх Ерөнхий сайдын мэдээлэл хийгдэж байна аа. Сурч боловсрох эрх нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон суурь эрх бөгөөд хувь хүний бүтээлч байдал төдийгүй улс орны нийгэм эдийн засгийн хөгжлийн нэн чухал ийм үзүүлэлт, хүчин зүйл ээ.

Тэгвэл өнөөдөр Монгол хүүхэд бүрд чанартай боловсрол эзэмшиж чадахгүй ийм боломж нөхцөлийг төрийн бодлогоор бий болгоогүй байна гэдэг олон улсын судалгаа тов тодорхой хариулт өгчээ. PISA буюу олон улсын суралцагчдыг үнэлэх хөтөлбөрийг эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн байгууллагаас 3 жил тутам зохион байгуулдаг. 15 настай сурагчид танхимаар олж авсан мэдлэгээ эх хэлээрээ уншиж ойлгох. Математик болон байгалийн ухааны мэдлэг чадвараа амьдрал дээр хэрхэн хэрэглэж байгаа. Эдгээр чадварыг олон улсын боловсролын чадварыг тухайн улсын боловсролын тогтолцоо хэр хэмжээнд олгож байгааг тандан судалдаг. Ийм онцлогтой үнэлгээ. Унших чадварын хувьд манай улсын судалгаанд оролцсон 3 сурагч тутмын 2 нь юу уншсанаа ойлгохгүй байна гэнэ ээ.

Монгол Улсаас уншсан зүйлээ бүрэн дүүрэн ойлгодог өөрөөр хэлбэл унших чадвараараа топ гүйцэтгэлийн түвшинд нэг ч сурагч 7 мянган сурагчаас нэг ч сурагч ороогүй. Гэтэл бусад орны сурагчдын 7 орчим хувь нь энэ топ үзүүлэлтэд хангагддаг. Ийм дүнтэй юм байна. Байгалийн ухааны хувьд манай

улсын 2 сурагч тутмын нэг нь анхан шатны мэдлэггүй гэж гарсан байна аа.

Монгол Улсын энэ байгалийн шинжлэх ухааны хувьд Монгол Улсын 500 сурагч тутмаас нэг сурагч, 500-аас 1 сурагч тэр чадвартай гүйцэтгэл гэдгийг хийж харагдсан байна. Энэ нь олон улсын дундаж 7.5 байдагтай харьцуулахад манайх 0.2 хувь гэсэн үг ээ. Үүнээс үзвэл манай байгалийн ухааны суурь боловсрол бүрэн хэмжээнд үнэндээ дампуурчээ. Ийм нөхцөлд шинжлэх ухааныг хөгжүүлэх инженерчлэлд технологийн чадварлаг хүний нөөцийг бий болгож томоохон төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх гэдэг зүйлийн тухай ярихад үнэндээ хэцүү болж байна аа.

Математикийн судлагдахууны хувьд үнэлгээнд хамрагдсан 7 мянга гаруй Монгол хүүхдийн 51 хувь нь муу гэсэн дүн авчээ. Энэ нь PISA үнэлгээний нэг ба 2 дугаар түвшин буюу математикийн анхан шатны мэдлэггүй бараг энэ чинь 1, 2 дугаар шатны үнэлгээ гэдэг чинь 10 түвшинээс 1, 2 дугаар түвшний тухай ярьж байгаа. Энд 4 аргын тоогоо нэмж хасах төдийхөн байна гэсэн үг юм байна. Энэ чинь 15 настай Монгол Улсын 9 дүгээр ангийн хүүхдийн тухай яриа. 100 суралцагч тутмын ердөө 2 нь агуулгаа бүрэн эзэмшсэн ур чадвартай гэж гарчээ. Монгол сурагчид математикт тааруу үнэлэгдсэний нэг шалтгаан нь сурагчид эргэцүүлэн бодох юмсын учир шалтгааныг олох чадвар хангалтгүй гэж олон улсын үнэлгээнд дурджээ. Мэдээлэлд манай улсын нэг сурагчид суурь боловсрол эзэмшүүлэхэд дунджаар 12608 ам.доллар зарцуулдаг бөгөөд энд авч буй үнэлгээ нь өндөр төсөв зарцуулж байгаа зарим орнуудаас сайн байна гэж бас дурджээ. Ингэж сурлагын үр дүнгийн муу байдлаар зарцуулж буй төсөвтэй жиших замаар зөвтгөх нь учир дутагдалтай. Нэг сурагчид манай улстай адилхан төсөв зарцуулдаг хэр нь илүү сайн үнэлгээ авсан Вьетнам зэрэг орнуудын жишээ нь сургалтын чанарыг дээшлүүлэхэд зөвхөн

төсөв мөнгө бус удирдлага, зохион байгуулалт, хандлага, бодлого чухал болохыг бас харуулж байна аа.

Энэ мэтчилэн PISA үнэлгээ нь манай улсын суурь боловсрол гүн хямралд орсныг илтгэн харуулж байхад Засгийн газар эерэг сайн байгаа мэтээр танилцуулж байгаа нь туйлын хариуцлагагүй үйл явдал аа.

Ер нь төр засаг, яам нь ард түмэндээ таашаа мэдээлэл өгч боловсролын үнэлгээний байгууллага нь сургуулиудаа өөдрөгөөр үнэлж багш нар нь сурагчдадаа өргөсөн дүн тавьж бие биеэ хуурснаар асуудал шийдэгдэхгүй ээ.

Өвчний оношийг буруу тайлбарлах эсвэл нуун дарагдуулах бус шаардлагатай эмчилгээг нэн даруй хийдэгчлэн бодлогын цогц арга хэмжээ авахыг эрх баригчдаас шаардахаас өөр аргагүй. 2016, 2020 оны Улсын Их Хурлын сонгуульд бүх шатны боловсролын үйлчилгээний чанар үр дүнг үнэлэх боломжтой болгож стандартад суурилсан боловсролын тогтолцоог бүрдүүлнэ ээ. Хүн бүр чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж тэгш хамар хамруулах тогтолцоог бүрдүүлнэ ээ гэх мэтээр 2016, 2020 онуудад амлаж үнэмлэхүй эрх авсан Монгол Ардын нам боловсролын тогтолцоог сайжруулах, сургалтын чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар үнэндээ дорвитой ажил хийгээгүй. Энэ судалгаа олон зүйлсүүд бэлхнээ харуулж байна. 8 жил гэдэг бол иж бүрэн шинэчлэл хийж үр дүн нь гарахуйц хугацаа гэж олон улсын байгууллагууд үздэг юм байна. Гэвч энэ хугацаанд эрх баригчид Боловсролын сайдаа энэ 8 жилийн хугацаанд 5 дахиа сольсноос өөр үр дүн нь харагдахгүй байна.

2019 онд НҮБ-ын БСШУ-ны байгууллагаас буюу Юнейскоогоос манай улсын боловсролд дүн шинжилгээ хийсэн тайланд боловсролын тогтолцоогоо зөвхөн хэсэгчлэн өөрчилж тохиргоо

хийгээд үр дүнгүй ээ. Харин эрс хувирган өөрчлөх шаардлагатай. Энэ янзаараа үргэлжилбэл маш ээдрээтэй том сорилтуудтай Монголын боловсролын тогтолцоо тулгарна гэдгийг ийм анхааруулсан зөвлөмж дүгнэлтийг 2019 онд өгч байжээ. Мөн тэр тайланд Монголын боловсролын тогтолцоо нь өрсөлдөөнт эдийн засгийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна гэж дүгнэснийг өнөөдөр хөдөлмөрийн зах зээл дээрээс чадвартай ажилтан хайгаад олж чадахгүй байгаа бизнес эрхлэгчид бас бодит яс махаараа мэдэрч энэ үр дүнгүүд илт харагдаж байна аа.

Эцэст нь хэлэхэд Монгол Улсын боловсролын тогтолцоог эрс өөрчлөн байгуулах бодлогын цогц арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн зүгээс бас үзэж байна аа.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Цогтгэрэл даргад баярлалаа.

Ерөнхий сайдын мэдээлэл хийхтэй холбогдуулан оролцож байгаа ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Боловсрол шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Ханджавын Батжаргал, БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын дарга Пүрэвдоржийн Оюунаа, Боловсролын үнэлгээний төвийн дарга Лхагвасүрэнгийн Ганбат, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч Хажидмаагийн Отгонбаатар нар оролцож байна.

Мэдээлэлтэй холбогдуулан Боловсрол, шинжлэх ухааны сайд болон ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж үг хэлэх цөөнхийн гишүүд нэрсээ өгье. Батсуурь гишүүнээр. Одонгийн Цогтгэрэл, Салдангийн Одонтуяа дарга оръё. Тэгээд төгсгөлд Одонгийн

Цогтгэрэл даргыг тавьчих. Ингээд Цогтгэрэл даргаар тасаллаа. Батсуурь гишүүн асуултаа асууя.

Ж.Батсуурь: Хэдэн минут билээ.

Л.Мөнхбаатар: 5 минутад багтааж асуулт асуултаа асууна.

Ж.Батсуурь: Энх-Амгалан сайдын хэлсэн ярьсан зүйлийг бас сонслоо. Тэгээд Ерөнхий сайдын асуулгад бол ер нь Ерөнхий сайд л орж ирж байх ёстой. Бид нар 4 жил Ерөнхий сайдыг нэхээд үндсэндээ орж ирсэнгүй л дээ. Тэгээд Ерөнхий сайдын мэдээлэл биш бараг л салбарын сайдын мэдээлэл болгож өөрчилмөөр л болох тал руугаа л хандаж байх шиг байна. Энэ жишээ нь ингээд энэ 4 жил бараг дуусах гэж байна. Энх-Амгалан сайдын хувьд бол одоо бүрэн эрхийн хугацаа 3 сар орчим болоод дуусах гэж байна. Тэгээд мэдээж ийм том бүтцийг хамарсан энэ том газар нутгийг хамарсан энэ зүйлийг бас тийм ч амархан басаж өндийлгөчих нь хялбар биш л байх. Хийсэн ажлуудаа бас ярилаа. Гэхдээ АН-ын бүлгийн дарга Цогтгэрэлийн хэлж байгаа үг бол АН-ын бүлгийнхэн бид нар ярилцаад ер нь нийгэмд боловсролын талаар бодож санаж байгаа дэвшүүлж байгаа зорилтын талаар хэлсэн.

Тийм учраас одоо сайд, сайдын багийнхан цаана байгаа хүмүүстэй энэ дүгнэлт саналыг үйл ажиллагааныхаа хөтөлбөрт оруулж дараа дараагийн Засгийн газрын бодлогын суурь үзүүлэлт болгож ингэж явах зөв байх гэж ингэж бодож байна. Мэдээж хичээж байгаа зүйлүүд олон байгаа. Болж бүтэхгүй байгаа зүйлүүд ч байгаа. Тэгээд би 2 зүйлийг санал юм уу асуулт маягаар хэлье гэж бодож байгаа юм.

Нэгдүгээрт сурлагын чанар. Ингээд боловсрол талаасаа нэг зүйл явдаг. Энийг зөв түвшин авч явахад бол хөрөнгө оруулалтын асуудлууд яригддаг. Тэгэхээр энэ өнгөрсөн боловсролын салбарт хийсэн

хөрөнгө оруулалтуудын чанар гүйцэтгэлийг харж үзээд байхад Боловсролын яаман дээр зарласан тендер хөрөнгө оруулалтууд дандаа чанаргүй байдаг. Урт хугацаанд төсвийн хууль зөрчсөн. Цаашид ч ухах юм бол авлигал хээл хахуульд авчихсан ч байдаг юм уу. Жишээлэх юм бол Сүхбаатар аймагт 2017 онд эхлүүлсэн цэцэрлэгийн барилгууд одоогоор эзэн нь тодрохгүй ингээд алга болчихсон байдаг. Орон нутаг руу эрх нь шилжээд очсон хөрөнгө оруулалтууд бол чанартай хугацаандаа ингээд үйл ажиллагаа нь болоод явчихдаг.

Тийм учраас ер нь энэ эсвэл төрийн худалдан авах ажиллагаагаар нь эсвэл орон нутагт нь эрхийг нь шилжүүлж энэ хөрөнгө оруулалтын асуудлыг шийдэж байхгүй бол цаана нь одоо ард иргэдийн үр хүүхэд олон жилээр хохирох нэг улсын хөрөнгө оруулалтаар эхлүүлсэн объект 5, 10 жилээр хойшлох төсөвт өртөг нь бүүр 3 дахин, 4 дахин нэмэгдэх. Ингээд авлигалын шинжтэй ийм үйл ажиллагаа руу ордог. Тэгээд энийг таслан зогсох тал дээр бас хэн Энх-Амгалан сайд нэлээд хэд хэдэн шийдвэрүүдийг гаргасан. Гэхдээ хойшид энийг бас анхаарах ёстой гэж би яамны Хөрөнгө оруулалтын газар бодлогын газруудад бол хэлж ярьж байгаа юм.

Нөгөөдөх нь боловсон хүчний асуудал байдаг юм. Энэ боловсон хүчний асуудал дээр ийм тогтворгүй томилгоонуудыг дээрээс гар дүрж ордог асуудлаа болиоч гэж хэлэх гэж байна. Жишээ нь Сүхбаатар аймгийн Боловсролын газрын дарга бол гадаадад сургууль төгсөж ирээд бүх амьдралынхаа туршид боловсролын салбарт ажилласан. Тэгээд одоо энэ бүтцийн сургуулийн энэ улирлын амралт ингээд дуусах гэж байдаг. Тэгтэл тэтгэвэртээ гар гээд ингээд шахаад дараагийнхаа томилгоог хийх гээд чичрээд байдгаа боливол яасан юм.

Өнөөдөр Монгол Улсын боловсролын системд чадаж байгаа хүмүүс нь биш, чадахгүй хүмүүс нь орж ирэхлээрээ л ингэж сууриар нь бусниулж байгаа шүү дээ. Олон сургалтын чанарт өөрчлөлт оруулахад маш олон зүйлийн, олон жилийн хөдөлмөр байдаг. Жишээлэх юм бол Сүхбаатар аймгийн ЭЕШ-аараа нийт аймгуудын дунджаас хойгуур байдаг байсан. Гэтэл шат дараалсан арга хэмжээнүүдийг удаан хугацаанд авснаараа элсэлтийн ерөнхий шалгалтаараа Монгол Улсад тэргүүлж эхэлж байгаа юм. Ингэж тэргүүлүүлж эхэлж байгаа Боловсролын газрын даргыг шахан зайлуулж дараагийн хүнийг томилох гээд чичрээд байгаагийн шалтгаан нь юу юм бэ? Ингэж боловсролын салбар руу улс төр ингээд та нарын намын хорооноос ороод байх юм бол яаж хүсэж мөрөөдөж байгаа энэ юу чинь төлөвлөгөө чинь биелэх юм бэ? Яаж боловсролын чанар дээшлэх юм бэ?

Тийм учраас би нийт агуулгаар АН-ын өгч байгаа дүгнэлтийг анхаарч үзээч гэж хэлж байна. Миний хувьд бол хөрөнгө оруулалт боловсон хүчний асуудал.

Л.Мөнхбаатар: Батсуурь гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд хариулъя. Ажлын хэсэг нэмж болно. Энх-Амгалан сайдын микрофоныг өгөөрэй.

Л.Энх-Амгалан: Яах вэ ойлгож байна аа. Сөрөг хүчин учраас сөрөг хүчний дүгнэлт улс төржсөн дүгнэлт байх ёстой гэдэг дээр бол ойлгож байна. Гэхдээ боловсролыг ингэж улс төржүүлсэн улс орон л угаасаа хөгждөггүй юм байна лээ.

Тэгээд энэ PISA-ийн энэ дүн чинь өнгөрсөн 8 жилийн боловсролын тогтолцооны дүн биш. Өнгөрсөн 30 жил тэр тусмаа 2012 оноос эхэлсэн цөм хөтөлбөрийн үр дүн л ингэж гаргаж байгаа шүү дээ. Өнөөдрийн өнгөрсөн оны 15 настай хүүхдүүд гэдэг бол 2012 онд 1 дүгээр анги, 2 дугаар ангид суурь унших,

бичих, математикийнхаа чадварыг нөгөө цөм хөтөлбөрөөр нь эхэлсэн хүүхдүүд л шалгуулж байгаа юм. АН-ын эхэлсэн цөм хөтөлбөр дээр дүн тавьж байна гэсэн үг. Дүн тавьж байна гэсэн үг.

Тийм учраас цаашидаа бид нар АН-ын мөрийн хөтөлбөр, Ардын намын хөтөлбөр гэж байхгүйгээр ямар ч байсан энэ сая Боловсролын багц хууль дээр бид нар Монгол Улс нэг Засгийн газар гарч ирснээр, нэг шинэ сайд гарснаар хөтөлбөрийн шинэчлэл хийдэг асуудлуудыг таслан зогсоосон, таслан зогсоосон. Нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөрийн шинэчлэлд ороход бид нар хөтөлбөрийн үндэсний менежментийн цикл гэдгийг бид нар нэвтрүүлж нэг хөтөлбөр хамгийн багадаа 10-аас 12 жилийн циклтэй хөтөлбөрийн шинэчлэл рүү ордог ийм циклүүд тогтолцооны шинэчлэл хийсэн байгаа юм. Тогтолцооны шинэчлэл. Өмнөх бид нарын сүүлийн 30 жилд хийсэн 10 удаагийн хөтөлбөрийн шинэчлэл хийсэн юм байна лээ шүү дээ.

Бид нар тэгээд хөтөлбөрийн шинэчлэл хийхдээ багшаа бэлдээгүй, сурах бичгээ бэлдээгүй, сургалтынхаа орчныг бий болгоогүй, санхүүжилтийг нь шийдээгүй. Ийм л хуумгай асуудлууд хийсэн учраас өнөөдөр одоо ингээд ийм л нөхцөл байдал гарч байгаа гэж би ойлгож байгаа. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал бол Батсуурь гишүүний асуусан асуултад хариулъя. Энэ Засгийн газрын хийсэн нэг нүүр бардам хэлэх ажил бол энэ цэцэрлэг, сургуулийн хүртээмж болов уу гэж би ойлгож байгаа. Ямар ч байсан Улаанбаатар хотын түвшинд аймгийн түвшинд бид нар энэ сугалааны цэцэрлэгийн тогтолцоог халсан. Өнөөдөр чинь нэг ч хүүхэд цэцэрлэгийн гадна үлдэхгүй байх энэ тогтолцоог халсан. 3 ээлжийн сургуулийн тогтолцоог бид нар халсан. Бас энэ Засгийн газрын хийсэн ажлыг бас зөвөөр нь үнэлж дүгнэх ёстой болов уу гэж бодож байна. Тэгээд бүгдийг хараар

будах, бүгдийг хараар сөргөөр ингэж үнэлэх шаардлагагүй л дээ. Ард түмэн түмэн нүдтэй харж байгаа болов уу гэж бодож байна. Хэн нь юу хийж байгаа, хэн нь ярьдаг хүмүүс, хийдэг хүмүүс гэж жаахан өөр байх ёстой. Боловсролын яам тендерийн яам байхаа больсон Батсуурь гишүүн ээ.

Хуучин Боловсролын яам бол тендерээ баахан зарладаг. Тендерээсээ гарч чаддаггүй ийм яам байсан. Одоо Боловсролын яаман дээр нэг ч тендер зарлагдахаа больсон. Энийг одоо тэр худалдан авах үйл ажиллагааных нь агентлагууд нь зохион байгуулдаг энэ тогтолцоо руу ороод бид нар 2 дахь жилээ болж байна. Тантай санал нэг байгаа юм. Орон нутагт энэ боловсролын салбарын хөрөнгө оруулалтууд олон жилээр хойшилсон. Олон жилээр ашиглалтад орж чадахгүй ингээд үе үеийн Засгийн газар дамжиж байгаа хэд хэдэн объектууд байгаа. Сүхбаатар аймаг дээр ч байгаа, Хөвсгөл аймаг дээр ч байгаа.

Тэгэхээр бид нар сүүлийн 2 жил хийж чадсан юм бол ямар ч байсан энэ тендерт орж байгаа энэ компаниудыг бас нэг жаахан чанартай тендер гэдэг нэг ийм ойлголтуудыг бий болгохгүй бол хамгийн хямдхан тендерт орж ирчхээд тэгээд бодлогоор орж ирж хамгийн хямдханаар тендер зорьж ирчхээд тэрийгээ гүйцэтгэж чадахгүй жил бүхэн төсвийг нь өсгөдөг ийм тендерийн хонгил л үүсгэчихсэн юм байна лээ шүү дээ. Тендерийн хонгил үүсгэчихсэн юм байна лээ.

Тэгэхээр энийг бид нар тогтолцооных нь хувьд шинэчлэхээс ийм өөр арга байхгүй гэж 1 дүгээрт бодож байгаа.

Хоёрдугаар асуудал боловсон хүчний томилгооны асуудал та хөндөж тавьж байх шиг байна.

Сая Боловсролын багц хуулиар бид нар энэ засаглалын, боловсролын засаглалыг бид нар мэргэжлийн засаглалд шилжүүлэх ийм бодлогыг бид нар хэрэгжүүлж эхэлж байгаа. Хуучин бол аль суманд аль нам ялнаас шалтгаалж цэцэрлэг, сургуулийн удирдлагыг тухайн намууд тавьдаг байсан. Энэ тогтолцоог бид нар халж байгаа. Сүхбаатар аймгийн Боловсролын газрын даргын асуудлыг та ярьж байх шиг байна. Тэтгэвэрт гарчихсан хүн шүү дээ. Тийм учраас тэтгэвэрт гарсан тэтгэврийнх нь өөрийнх нь.

Л.Мөнхбаатар: Тодруулга байхгүй. 5 минутдаа багтааж асуугаад хариулах дэгтэй байгаа. Салдангийн Одонтуяа дарга асуултаа асууя.

С.Одонтуяа: Би энэ цаг үеийн байдлын талаар нэг ноцтой зүйл асууя. Та өөрөө мэдэж байгаа. Энэ нийгэмд энэ СУИС дээр маш ноцтой асуудал үүслээ шүү дээ. Үе тэнгийнхний дээрэлхэлт, гадуурхалт, хүний эрхийн зөрчил, гэмт хэргийн чанартай ийм үйлдлүүд гарч байгаа. Тэгээд энэ бол гэнэт сүүлийн үед гарчихсан биш энэ бүүр ужгирчихсан их олон жилийн өмнөөс гарч байсан гэж байна.

Тэгэхээр та сайд болоод энэ асуудлыг ер нь мэдсэн үү. Ямар арга хэмжээ авсан бэ гэдэг дээр танаас асуумаар байна. Яагаад гэхээр энэ хүүхэд залуучуудын энэ хүмүүжил, төлөвшил, ёс зүйн асуудал чинь мэдээж тэр айлын эцэг эх гэр бүлийн хүмүүжил төлөвшилөөс шалтгаална.

Нөгөө талаасаа энэ чинь төрийн бодлогын л ерөөсөө толь шүү дээ. Нийгмийн толь. Бид нар ямар нэг зөв бодлого явуулж байвал тэр хүүхдүүд чинь зөв л өсөж хүмүүжнэ. Тэгэхээр энэ Засгийн газар бол ерөөсөө энэ хөтөлбөрүүд энэ залуучуудаа энэ ёс зүйтэй болгох, залуучуудаа төлөвшилтэй болгох, хүмүүжилтэй болгох дээр би маш

олон хөтөлбөр санаачлаад төсөвт суулгах гээд оруулаад ирэхээр хасчихдаг. Хөтөлбөр санхүүжүүлэхгүй ээ. Та байшин барь эсвэл хөшөө дурсгал барь тэгвэл төсөвт суулгана л гэдэг.

Тэгээд тэрний чинь гор гарч байгаа байхгүй юу. Энэ дээр нэг их улс төржөөд байгаа ч юм алга. Ерөөсөө төрийн бодлого ямар байна залуус тийм л байдаг. Тэгэхээр бид нар энэ үнэт зүйлийнхээ дарааллыг буруу тогтоочхоод байгаа юм. Хамгийн том үнэт зүйл чинь Монгол хүүхэд, Монгол залуучууд, Монгол гэр бүл. Тэгэхээр энд ерөөсөө мөнгө зардаггүй. Тэгээд би танд 2022 оны 12 сарын 27-нд асуулт тавьсан.

Энэний хариулт ирэхэд бол маш ноцтой түвшинд оччихсон юм байна лээ. Энэ сургуулийн орчны гадуурхалт маш өндөр түвшинд байгаа. Тэгээд энэ судалгааны дагуу би Баянгол дүүрэг дээр очиж ажилласан. Захирлууд, нийгмийн ажилтнуудыг цуглуулаад, Иргэдийн хурлынхныг цуглуулаад Засаг даргатай уулзаад энэ талаар яаралтай арга хэмжээ авъя гээд бид нар өөрсдийнхөө түвшинд ажилласан. Би танд өнөөдөр дахиад бас нэг асуулга тавилаа. Асуулт тавиад энэ ажил сайжрахгүй болохоор асуулга тавьсан. Чуулган дээр хариу сонсохоор.

Тэгэхээр энэ асуудлаа ер нь таслан зогсоох түүнээс урьдчилан сэргийлэх талаар яг ямар ажил хийсэн бэ? Энэ оюутан сурагчдын хүмүүжил зан үйлд нөлөөлөх, тэдгээрт хууль эрх зүйн мэдлэг мэдээлэл олох талаар та ер нь ямар ажлууд хийв ээ? Энэ дээрээ ер нь төсөв хөрөнгө яаж зардаг юм бэ? Энэ чинь их олон жил ужгирсан асуудал байна шүү дээ. Зөвхөн нэг сургууль дээр л шүгэл үлээж байгаа байхгүй юу. Гэтэл бусад сургууль дээр байхгүй гэх магадлал байхгүй. Таны ирүүлсэн судалгаа бол маш нарийн хийсэн судалгаа байсан. Тэр судалгаагаар бол маш өндөр гарсан.

Тэгэхээр энэ чинь нийгмээрээ бид нар нэг сенсац гарахад ингэж сандардаг биш, урьдчилан сэргийлэх ажлуудыг хийж байх ёстой. Тэгээд Боловсролын багц хуулийг баталлаа. Бүх төсвийг чинь баталж өглөө. Энэ талаар л танаас тодорхой мэдээлэл авмаар байна. Тэгээд бид нар ер нь энэ гадаадаас бүх зүйлийг авч чадаад байгаа юм л даа. Мөнгө байхгүй бол зээлчихдэг юм. Тоног төхөөрөмж байхгүй бол авчихна. Ажиллах хүч байхгүй бол бас авчихна. Ганц авч чадахгүй юм чинь яг энэ зөв хүмүүжилтэй, төлөвшилтэй, ёс суртахуунтай, өрсөлдөх чадвартай, эх оронч үзэлтэй, эрдэм боловсролтой, эрүүл чийрэг бие бялдартай залуучуудыг, хүүхдүүдийг. Энэ хүүхдүүдийг өсгөж хүмүүжүүлдэг энэ Монгол ээжүүдийг бид нар хаанаас ч авч чадахгүй. Тэгээд танай Засгийн газар бол энэ дээр ерөөсөө мөнгө зардаггүй.

Тийм учраас энэ дээр бол маш гомдолтой байдаг. Тэгэхээр цаашидаа бид нар бол ингэж явж болохгүй ээ. Монгол гэдэг чинь бас нэг том айл шүү дээ. 2012-2016 онд би хөтөлбөр санаачлаад л төсвийг нь батлуулаад л хүүхэд залуучууд зөндөө арга хэмжээ хийдэг л байсан. Тэгэхээр ингээд хэтэрхий ингээд хүнээ бодоогүй ийм нийгэмд бид нар энэ залуучуудыг амьдрүүлж болохгүй. Залуучууд чинь дайжаад дайжаад гарчихлаа.

Тийм учраас энэ дээр та тодорхой хариулт өгөөч ээ. Би өнөөдөр гэнэт асууж байгаа биш. 2 жилийн өмнө бас тан руу бичээд бас нэг энэ дээр дорвитой өөрчлөлт гаргах гээд бас хичээж байсан хүний хувьд одоо яг юу хийсэн юм бэ гэдгийг нэг асуучихмаар байна.

Л.Мөнхбаатар: Одонтуяа гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд хариулъя. Ажлын хэсэг нэмж хариулж болно.

Л.Энх-Амгалан: Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Энэ үе тэнгийнхний дээрэлхэлт гэдэг энэ сэдвээр, энэ асуудлаар мэдэхгүй өмнө нь ингэж дуугарч байсан юм уу үгүй юм уу би санахгүй байна. Ямар ч байсан сүүлийн 2 жилд энэ Засгийн газар нэг шүгэл үлээж ямар ч байсан энэ үе тэнгийн дээрэлхэлт гэдэг асуудал нийгэмд ийм далд мөртөө маш их тийм бугширсан тэсрэх гэж байгаа мин шиг ийм болчихсон асуудал их хүндэрчихсэн юм байна шүү л гэдэг бид нар үнэн энэ мэдээллүүдийг гаргаж тавьсан. Одоо бид нар ард түмнээсээ юуг нь нуух юм. Тэгээд бид нар чинь 90 оноос хойш энэ хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулна гэж Үндсэн хууль дээр тунхагласан.

Гэтэл өнөөдөр яг түрүүн Цогтгэрэл дарга ч гэсэн шүүмжлээд байх шиг байна. Тэгээд хүмүүнлэг ардчилсан нийгэм байгуулах энэ боловсролынхоо тогтолцоог боловсролынхоо системийг бид нар хийж чадсан юм. Цөм хөтөлбөрийн үр дүнг PISA-ийн үнэлгээгээр үнэлж байгаа үнэлгээ бас нэг талаасаа мөн.

Гэтэл энүүгээр гарч ирж байгаа үнэлгээ чинь өөрөө энэ цөм хөтөлбөрийн чинь сул тал нь хүүхдэд дэндүү их академик мэдлэг өгсөн байна аа. Доод эрэмбийн ур чадвар эзэмшүүлсэн байна гэдэг ийм үнэлэлт дүгнэлт гарчихлаа. Ийм үнэлэлт дүгнэлт.

Тийм учраас цаашидаа энэ хүүхдэд дан ганц энэ академик мэдлэг эзэмшүүлэх биш, хүүхдэд мэдлэг чадвар төлөвшил гэсэн ийм цогц чадамж хэрэгтэй юм байна аа. Ийм мэдлэг чадвар цогц чадамжийг бий болгосон энэ хөтөлбөрүүдийг бид нар хийх зайлиггүй шаардлага байх ёстой юм байна гээд сая бид нар энэ боловсролын шинэ сэргэлтийн 6 түвшинд зарлаж байгаа гол хөтөлбөрийн шинэчлэлийн 6 шинэчлэлийн

нэг чинь хөтөлбөрийн шинэчлэлийн асуудал байгаа юм.

Тиймээс Одонтуяа гишүүнээ ингээд бид нарыг нэг асуудал гарахаар л гал унтраах маягаар бид нар ер нь асуудалд хандаж болохгүй. Гал унтраах маягаар. Тийм учраас энэ тогтолцооны шинэчлэлийг бид нар хийж байж тодорхой үр дүнд гарах ёстой. Тэгээд мэдээж өнөөдөр нийгэмд үүсчихсэн байж байгаа энэ асуудлууд цахим гадуурхалтын асуудлууд өнөөдөр өдөр ирэх тусам сэтгэл санаа зовоож байгаа ийм асуудлууд байна. Ямар ч байсан Монгол Улсын Засгийн газар яг юу хийсэн юм бэ гэж асуувал нэг сургуулийн сэтгэл зүйчдийг бид нар ямар ч байсан бэлдлээ. Сургуулийн сэтгэл зүйчдийг өнөөдөр ямар ч байсан нэг төрийн өмчийн 760 гаруй сургуулиудаас ямар ч байсан 3 сургуулийн 2 нь сургуулийн сэтгэл зүйчтэй болно.

2 жилийн дотор ирэх 9 сарын 1 гэхэд бид нар сургуулийн бүх сургуулиудыг сэтгэл зүйчтэй болгоно. Тэр тусмаа төрийн өмчийн их, дээд сургууль, мэргэжлийн сургуулиудад. Энэ үе тэнгийн дээрэлхэлт бас энэ мэргэжлийн болон техникийн боловсролын түвшинд бас асуудал маш хүнд байгаа. Тийм учраас бид нар бол энэ хөтөлбөрийн түвшинд сэтгэл зүрхний боловсролын энэ хөтөлбөрүүдийг бас бид нар энэ техникийн болон мэргэжлийн боловсролын сургуулиуд дээр бас хэрэгжүүлж байна. Их үр дүн өгч байна үр дүн өгч байна. Мөн одоо бид нар энэ ахлах сургуулиудын хүүхдүүд дээр бас энэ сэтгэл зүрхний боловсрол EQ гэж ярьж байгаа энэ боловсролын хөтөлбөрүүдийг бас хэрэгжүүлж байна. Бас тодорхой үр дүнд хүрч байна.

Тийм учраас цаашидаа бид нар зөвхөн энэ ахлах сургууль мэргэжлийн боловсрол, дээд боловсролын түвшинд биш цэцэрлэгийн наснаас нь энэ сэтгэл зүрхний боловсрол EQ-ийн чадвар өндөртэй иргэдүүдийг бэлдэх ийм л хөтөлбөрийн шинэчлэл бид нар зарлаж

байгаа юм. Ийм хөтөлбөрийн шинэчлэлийг хийхээр одоо бид нар хөтөлбөрийнхөө үзэл баримтлалыг орон даяар хэлэлцүүлээд ингээд удахгүй энэ хөтөлбөр дээр суурилсан сурах бичгийнхээ асуудлуудыг хийхээр энэ ажлуудыг эхлүүлж байгаа гэж та харж болно.

Тийм учраас энийг юу гэдэг юм үнэхээр одоо бид нарын мэдээж байгаа тохиолдлууд нь энэ байгаа байхгүй юу. Мэдэхгүй тохиолдлууд чинь асар их байгаа шүү дээ. Өдөр тутам байгаа энийг нууж байгаа.

Тийм учраас ямар ч байсан бид нар энэ сургууль дээр суурилсан сэтгэл зүйчдийн асуудлууд, сургууль дээр ажиллаж байгаа нийгмийн ажилтнууд, сургууль дээр ажиллаж байгаа эмч, хоол зүйчдээр удирдуулсан бас багуудыг ажиллаж багуудыг гаргаж бас энэ дээр тодорхой үр дүнгүүд бас гарч байгаа л гэж бас хэлэхийг хүсэж байна.

Л.Мөнхбаатар: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Саяын АН-ын бүлгийн дүгнэлтэд бид нар улс төржсөн буюу тийм үзэмжээрээ асуудал ерөөсөө ганц ч зүйл яриагүй ээ. Бүгдээрэнгий нь тоотой баримттай тэр PISA-ийн дүгнэлтээс нь PISA дээр Монгол хүүхдүүд 9 дүгээр ангийн буюу 15 настай хүүхдийн 7 мянган хүүхдээс 3-ны 2 нь уншаад Монгол хэлээрээ уншсан зүйлээ ерөөсөө ойлгохгүй байна гээд л тэр тайлан дээр байгаа. Бид нар тэрийг л хэлсэн. 2 хүүхэд тутмын нэг нь үндсэндээ 4 аргын тоогоод дөнгөн данган мэдэж байна. Энэ чинь 9 дүгээр ангийн хүүхэд. Энэ чинь олон улсын дунджаас Монголын дундаж асар хоцрогдолтой болчихжээ гэдэг яг тодорхой тоо баримтуудыг тэр тусмаа та нарын ирүүлсэн тоо баримтуудыг энд ярьсан. Ер нь тэгээд Монгол Улсад боловсролын асуудал мэдээж хүн төрөлхтөнд үеийн үед дахиад бүхий л улс үндэстэнд хэрэгтэй явж ирсэн. Тэр

тусмаа яг өнөөдөр манай Монгол Улсын хувьд асар ийм л чухал цаг үе дээрээ л ирчхээд байна гэдгийг бүгдээрээ л бас ач холбогдол өгцгөөдөг. Тархай бутархай цөөхүүлээ олон 100 сая тэрбумаар тоологдох улс үндэстэнтэй хиллэдэг. Бид нар оюун ухаан, техник технологийн тухай ярихаас өөр аргагүй. Ийм цаг үед ирчихсэн.

Тэгээд саяын нөхцөл байдлууд саяын тэр PISA-ийн дүгнэлтийг олон улсын дүгнэлтийг харахаар бид нар ерөнхийдөө л ер нь манай боловсролын тогтолцоо өөрөө өөрсдийгөө хуураад, эцэг эхийгээ хуураад, улс орноо хуураад ирсэн нэг ийм л дүн дүгнэлт гарч байна шүү дээ. Тэгэхээр энэн дээр ер нь боловсролын яам ямар үнэлэлт дүгнэлт өгөөд бид нар энийгээ яг тодорхой яаж засах ёстой гэж байна? Ер нь та яг бодлогоо бодож байгаа юм. Бид нар чинь нэг ийм чанар хүртээмжийн асуудал гээд нэг баахан барилга байшин л барилаа. Өнгөрсөн хугацаанд баахан барилга байшин барьсан.

Гэтэл яг тэр нэг хард зүйл хатуу зүйлээс чинь гадна тэр дотор нь нэг софт зүйл байдаг. Хөтөлбөр олон олон зүйлүүд, чанар, багшийн чанар, бусад олон олон зүйлүүд маань л үнэхээр хоцрогдчихсоныг л харж байна л даа. Улсаараа үндэстнээрээ л баахан байшин л бариад байсан. Барилгын яам болчихоод л Боловсрол биш барилгын яам болчихоод л өнгөрсөн хугацаанд. Барилга бариад байсны л бас гор ч гэдэг юм уу, үр дүн ч гэх юм уу нэг зүйл рүү хэт туйлширч явсны л тийм үр дүн нь гарч байна л даа, нэгдүгээрт нь.

Хоёрдугаарт нь дахиад энэ дүгнэлт дээр гарч байгаа нэг зүйл олон улсын дунджаас Монгол Улс бараг 2.5 жил ч байлуу хоцрогдолд тэр тусмаа Монгол дотор ороод ирэхээр Улаанбаатарын дунджаас аймгууд дахиад 2 жил шахмын хоцрогдолд, аймгаасаа сум 2 жил шахмын хоцрогдолд.

Ингээд үзэхээр ер нь Монголд тэр хот хөдөөгийн ялгаа гэдэг зүйл чинь жинхэнээсээ энэ боловсрол дээр очоод гарчхаад байна л даа. Тэр тусмаа бусад улс орнуудын 12 жил сурч авдаг боловсролыг манай хүүхдүүд хэдий мэдэхгүй бараг 16, 17 жил сурч авахаар дүн гарч байгаа юм уу даа энэ одоо. Тэгэхээр энэ энэ чинь одоо асар том тийм аюулын харангын дохиог энэ ямарваа нэгэн тийм улс төрийн зүйл биш. Яг л энэ тайлан дээр байгаа тоонуудыг л би хэлж байна. Тэгэхээр энэн дээр бид нар ер нь энийг чинь нэг ийм бодлогын эрс өөрчлөлт л хийх юм биш үү? Яг яах ёстой юм? Тэр 19 оны Юнейскогийн дүгнэлт чинь бас яг л тийм л байлаа шүү дээ. Монгол Улс тэр бүр трансформ гэдэг үгээр эрс өөрчлөх өөрчлөлтийг хийхгүй энэ аргацаасан байдалтай энэ Монгол Улсын суурь боловсролын тогтолцоо чинь асар том улс үндэстний чинь өмнө асар том асуудлыг дагуулна.

Энэн дээрээ том өөрчлөлт хийгээч л гэдэг. Тэгэхээр энд ингээд нэг ийм бодлогын өөрчлөлт гэдэг зүйл бид нар харахгүй байна уу, мэдэхгүй байна уу, бүү мэд. Сүүлийн үед нэг л байшин барилгын хүртээмж ярьсан Засгийн газар хүртээмж ярьсан яам ийм л болсон. Тэр дотор нь байгаа тэр хөтөлбөр зэрэг олон олон зүйлүүд тэр софт гэж хэлдэг олон олон зүйлүүд маань хааччихсан юм бэ? Энийг энэ ОУБ-ын олон улсын дүгнэлт чинь энийг илрүүлэн гаргаж ирээд байгаа юм биш үү? Тэгэхээр энэн дээр та тэр барьж байгаа бодлогоо сая тэр хоцрогдлыг яаж тэр олон жилийн хоцрогдлыг яаж нөхөх юм? Хот хөдөөгийн ялгааг юу гэж бодож байгаа вэ? Энэ дээр бодлогын ямар шийдлүүд байгаа юм? Энэ бүгдээсээ та нэг тийм тодорхой улс төржсөн биш хариулт өгөхийг танаас хүсье.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайд хариулчихъя.

Л.Энх-Амгалан: Тийм харин ийм системийн шинэчлэл хийх ёстой болчихлоо гээд л энэ Засгийн газар гарч ирээд боловсролын сэргэлт гэдэг сэргэлтийг хийе ээ. Хамгийн түрүүнд энэ Боловсролынхоо багц хуулийг эрх зүйн шинэчлэл хийе гэж 2 жил бид нар үндэстэн даяараа л Монгол даяараа л энэ хэлэлцүүлгүүдийг хийлээ шүү дээ. Тэгээд ямар ч байсан энэ Засгийн газрын энэ парламентын магадгүй бид нарын үлдээх ёстой өв бол энэ Боловсролын багц хуулийг баталснаараа л энэ өв болж үлдэх болов уу гэж бодож байгаа юм. Монгол Улсын парламентын Их Хурал анх удаа сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсролын тогтолцооныхоо шинэчлэлийг ямар ч байсан хийж авлаа. Энэ тогтолцооны шинэчлэл дээр бид нар яг юу хийх гээд байгаа юм бэ гэдэг асуудал байгаа юм. Бид нар 6 зүйлийг л хийе гэж байгаа юм. Энэ 6 зүйлийг хийж чадах юм бол өнөөдөр Монгол Улсад үүссэн байгаа энэ хот хөдөөгийн сургуулийн ялгаа төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгаж чадах юм байна аа. Нэгдүгээрт нь бид нар хөтөлбөрийн шинэчлэл зайлиггүй хийх шаардлагатай байна аа.

Өнөөдрийн энэ хүүхдийн Монгол Улсад явж байгаа энэ хөтөлбөр чинь өөрөө хүүхдийг амьдралд бэлддэг биш, шалгалтад бэлддэг ийм тогтолцоотой улс болчихсон байна аа. Тийм учраас бид нар хөтөлбөрийн энэ 21 дүгээр 100 аж үйлдвэрийн 4 дүгээр хувьсгалд дээд эрэмбийн ур чадвар эзэмшүүлдэг ийм хөтөлбөрийн шинэчлэл хийхээс өөр сонголт бид нарт байхгүй болсон. Нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал бид нар үнэлгээний тогтолцоогоо шинэчилье гэж байгаа юм. Дүн тавьж эс үгүй бол хүүхдийн дүнгээр хүүхдийг үнэлдэг. Энэ чинь бол энэ тогтолцоо нь маш хоцрогдсон тогтолцоо. Тийм учраас хүүхдийн ахиц дэвшлийн үнэлгээ,

сургуулийн ахиц дэвшлийн үнэлгээ багшийн ахиц дэвшлийн үнэлгээ гэдэг энэ үнэлгээний шинэчлэлийнхээ тогтолцоог хийе гэж байгаа юм.

Гуравдугаарт нь бид нар багшийн хөгжлийнхөө тогтолцоог бид нар шинэчилж. Ямар хүүхдийг багш болгох юм, ямар хөтөлбөрөөр бэлдэх юм. Багш төгсөж очоод ажлын байран дээр яаж тасралтгүй хөгжиж байх энэ үндэсний багшийн хөгжлийн тогтолцоог бид нар яаж хийх юм бэ гэдэг асуудал. Тэгээд мэдээж дахиад энийгээ дагаад багшийн цалин хөлс нийгмийн баталгааны асуудлууд дээр тодорхой шинэчлэлүүд хийх ийм зайлиггүй шаардлага.

Дөрөвдүгээр асуудал бол ерөөсөө 1 хүүхдийг сургаж байгаа энэ хувьсах зардал дандаа хуучин байгууллага, сургууль, цэцэрлэг санхүүжүүлдэг байсан тогтолцоо. Бид нарын шинэ хуулиар нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардлыг хүүхдийн сурлагын ахиц дэвшил багшийн хөгжлийг дэмждэг энэ тогтолцоо руу бид нар шилжүүлж байгаа.

Тийм ч учраас энэний үр өгөөжийг өнөөдөр манай багш нар маань бас хүртэж эхэлж байгаа шүү дээ. Олон жил ярьдаг байсан багш нарын хичээл практикийн зардлууд, дата интернэтийн зардлууд, багшийн хөгжлийн зардлууд, сургуулийн нөхөн хангалтын зардлууд гэдэг энэ зүйл чинь өнөөдөр бодит ажил хэрэг болоод явж байна аа.

Тавдугаар асуудал бол засаглалын асуудал. Түрүүн Батсуурь гишүүн ч хэлсэн. Ямар ч байсан энэ боловсролыг улс төрчдийн савраас гаргасан ийм засаглалын тогтолцооны шинэчлэл болж чадсан байгаа юм. Сургуулийн менежментийн асуудал байгаа. Цэцэрлэгийн менежментийн асуудал байгаа.

Зургаадугаар шинэчлэлтийн асуудал бол энэ цахим шинэчлэлтийн

асуудал байгаа юм. Ер нь бид нар энэ цахим шилжилтүүдийг бүрэн хийж байж хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгах.

Хүүхэд өнөөдөр хаана амьдарч байна, хаана сурч байна, хүүхдийн эцэг эх нь ямар орлоготой байна гэдгээс үл шалтгаалж хүүхэд бүрд өөрийнх нь түвшинд таарсан чанартай боловсрол өгөх ийм л б шийдлийг бид нар зарласан. Энэ б эрх зүйн шинэчлэл энэ б боловсролын шинэчлэлийг бид нар хийж чадах юм бол нөгөө хамгийн сайн сургууль гэрт ойрхон сургуультай болох. Энэ тогтолцооны шинэчлэл байгаа. Тийм учраас хууль өнгөрсөн хавар батлагдаад өнөөдөр бэх нь хатаагүй байна. Бэх нь хатаагүй байна. Тэгээд хуулийн энэ боловсролын аливаад боловсролын салбарын шинэчлэл гэдэг бол хамгийн багадаа 8-аас 12 жилийн тогтвортой үйл ажиллагааг шаардаж байдаг ийм шинэчлэл.

Тийм учраас хууль батлагдаад маргааш өнөөдөр бид нар PISA-хаа үзүүлэлтээр олон улсын байгууллагуудтай өрсөлдөөд тэр хэмжээнд хүрнэ гэж байхгүй шүү дээ. Бид нар өнөөдөр өрсөлдөж байгаа энэ улс орнууд чинь манай боловсрол зарж байгаа санхүүжилтээс даруй хамгийн багадаа 8-аас 12 дахин хэмжээний санхүүжилтийг боловсролдоо хийж байж энэ OECD-ийн түвшинд энэ боловсролын чанар хүрч байна шүү дээ. Тэгэхээр бид нар энийг тогтолцооны шинэчлэлийн хүрээнд системийн шинэчлэлийн хүрээнд нь харж байж энэ асуудал дээр хандахгүй бол яг нэг хууль баталснаар өргөс авсан юм шиг ийм сайхан болох ийм нөхцөл бүрдэхгүй л гэж би харж байгаа.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсен асуултаа асууя.

Б.Бейсен: Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Манай аймгийн хувьд энэ сүүлийн бараг арваад жил болчхов уу сүүлийн биш гээд 21 дүгээр байранд байдаг энэ бас хос хэлний сургалтын асуудалтай бас холбоотой болов уу гээд харж байгаа. Дөнгөж 1 дүгээр ангид 5 настай орж байгаа хүүхэд дээр англи хэл, монгол хэл, казак хэл гурвуулаа зэрэг ордог. Үндсэндээ эх хэлийг сурч байж дараагийн хэлээ сурахгүй бол бас юм ойлгохгүй хагас тутам мэдлэгтэй болчхоод нэг талд байгаа. Энэ талаар яг хос хэлний сургалт дээр та сайд ямар байр суурьтай байна? Ямар төсөл хөтөлбөр Засгийн газартай танилцуулав? Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ сургуулиудын та бүх сургуулиудаар явсан аймгуудаар бүгдээрэнгээр явсан. Багш нарын чадвар муутай холбоотой байна уу? Аль эсвэл сургалтын материал дутагдалтай байна уу? Хуурамч дипломтой олон багш нар байна гэсэн. Энэнтэй холбоотой байна уу? Энэ талаар нэг тодорхой хариулт авъя. Уг нь энэ сургуулиудыг компьютер, тоног төхөөрөмж, сургалтын материалаар хангах гээд би энэ 4 жилд бас 2 тэрбум орчим төгрөг тавиулсан гишүүний багцаар шүү. Урьд жилийн 2022 онд 9 сургуулийг компьютер, тоног төхөөрөмжөөр 30 компьютертой нь ухаалаг самбартай нь, принтертэй нь, өнгөт, парт ширээтэй нь ингээд 550 сая орчимд тэгээд 9 сургуулийг хангасан. Энэ жил гэхэд 750 сая, 800 -аад сая төгрөг тавиулсан. Бүх багш нар нь сургалтын материал, компьютер, тоног төхөөрөмж, I PAD байхгүй, нөтбүүк байхгүй.

Тийм учраас сургууль болгон дээр аймгийн төвийн бүх сургууль, хөдөөгийн бүх сургуулиуд дээр бүгдээр нь 12, 12 нөтбүүк тавиулсан. Булган сумын Шүвтэр гээд Урианхай үндэсний цөөнх байдаг нэг сургууль байгаа. Энэ жил өндөр хүчдэлд холбогдож байгаа. Тэрнийхийг бид 3 гишүүн ярьж байгаад тусад нь 10 нөтбүүк тавиулсан. Урьд нь 13 сумын 3 сум үлдсэн байсан. Сагсай,

Дэлүүн, Баяннуур 3 сум. Энэ 3 сум энэ жил компьютер тоног төхөөрөмжийн асуудлыг хангахаар бүгдийг нь нийлүүлж байгаад сая багш нар энэ нөтбүүктэй нь. Тэгээд аймагт очихоор чанаргүй юм өгчихдөг. Тендер бас аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгчдийн бараг тендерийн асуудлаар хуваагаад авдаг. Урд тэр 9 сургуулийг 9 багц болгоод өгсөн байсан. Энэ удаа тэгээд тэр 750 саяыг бид нар энэ юутай ярьж байгаад Төсвийн байнгын хороо тантай бас ярьсан. Тэгээд энэ хот руу татаж байгаад тэр 3 сургуулийн компьютер тоног төхөөрөмж тэгээд л сая бүх сургуулиудын багш нарын нөтбүүктэй хамтраад Улсын Их Хурлын тогтоол гараад л татаж аваад Боловсролын яам хотод зарлаад чанартай юмаар хангаач гэдгийг танай албан газруудтай бүгдээрэнтэй нь ярьж тантай бас ярьсан байсан. Гэтэл түрүүлээд аймаг тийм Их Хурлын тогтоол гарсан юман дээр аймаг тэрэн дээр зарласан байна. Зөвхөн 3 сургууль дээр гээд ярьж байгаа юм байна энэний цаана. Тэгээд урьд нь Одоо тийм 500 саяд 9 сургуулийг хангаж байсан байвал 750 саяд, 3 сургуулийг яана гэж тийм юм байхгүй. Энийг та хяналт хийгээд би бас АТГ-т энэ гомдол гаргах тендерээ буцаадаг юм. Тийм асуудал хийхгүй. Энийг цаана бас тийм ашиг сонирхлын зөрчлүүдийг би хардаад байгаа юм. Та энэн дээр нэг тодорхой мэдээлэлтэй байна уу? Энэний талаар нэг судалгаа аваад та нэг багш нарыг тодорхой сургалтын материалаар хангаж байж л сурагчид тодорхой мэдлэг боловсролтой байхгүй багш нар нь өөрсдөө сургалтын материал, компьютер, нөтбүүк тоног төхөөрөмжгүй байж байж сурагч нарт сургагч боловсрол олгоно гэдэг чинь тун хэцүү.

Нөгөө талаар цэцэрлэгүүд байж байна. Энэ цэцэрлэг мөн компьютер тоног төхөөрөмжийн өтөөхийн асуудал дутагдалтай. Шинээр баригдаж байгаа цэцэрлэгүүдийн төсөв гүйцэд тавигдсан уу? Тэгээд дотор тавилгуудыг нь гүйцэд

өгөх үү? Тэр талаараа асуугаад тодорхой мэдээлэл авъя аа.

Л.Мөнхбаатар: Бейсен гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Бейсен гишүүн ямар ч байсан хуучин бид нар энэ аймгийн боловсролын үнэлгээг зөвхөн энэ боловсролын үзүүлэлтийг ЭЕШ шалгалтаар үнэлдэг нэг ийм ганцхан үзүүлэлтээр л үздэг, үнэлдэг, дүгнэдэг төсөөлөл авдаг байсан. Ямар ч байсан сүүлийн 2 жилд энэ Засгийн газар ямар ч байсан боловсролын чанарын үнэлгээ гэдэг энэ ойлголтуудыг гаргаж ирснээр их том дэвшил болж байгаа гэж бодож байгаа. Өнөөдөр манай аймгийн удирдлагуудад бас би талархаж байгаа.

Аймгийн удирдлагууд нь бас энэ аймгийнхаа боловсролын чанарын үзүүлэлтүүдийг хардаг болсон. Чанар дээшлүүлэхийн тулд бас тодорхой хөрөнгө оруулалт хийдэг болсон. Бодлогоор дэмждэг болсон. Манай эцэг эхчүүд асран хамгаалагч нар ч гэсэн өнөөдөр ингээд энэ аймгийн яг аль сургууль өнөөдөр ямар үнэлгээтэй байгаа юм. Аль багш өнөөдөр ямар үнэлгээн дээр байгаа юм. Хүүхдийг ер нь аль хичээл дээр ямар чанарын үнэлгээнүүд байгаа юм бэ гэдгийг бид нар хичээл бүрээр нь хардаг ийм үнэлгээтэй болсон. Тэгээд хэмжиж чадахгүй бол хянаж чадахгүй, хянаж чадахгүй удирдаж чадахгүй гэж. Энэ бол боловсролын шинэ сэргэлтийн хамгийн том магадгүй миний сайдын хувьд ч гэсэн хийж үлдээж байгаа цөөхөн өвүүдийн нэг энэ чанарын энэ үнэлгээний тогтолцоо болов уу гэж би бодож байгаа юм. Ямар ч байсан БШУЯ бусад салбаруудаас түрүүлж бид нар их өгөгдлийн энэ платформуудыг сая нэвтрүүлээ. Хиймэл оюун ухаанаар бид нар бүх багшийн хомсдолуудаа хардаг.

Өнөөдөр хаана ямар сургууль, цэцэрлэгүүдийг ямар хэдэн суудалтай, ямар багтаамжтай сургууль

цэцэрлэгүүдийг барих вэ? Ирээдүйд ямар хэрэгцээ шаардлагууд гарч байна вэ гэдгийг бид нар энэ биг дата буюу их өгөгдлийн системээрээ бид нар хардаг боллоо. Энэ маш том дэвшил.

Цаашидаа ч гэсэн манай энэ бүх салбарууд бас ийм төлөвлөлт рүү ороосой гэж бодож байгаа юм. Бүх хүүхдүүдийнхээ гүйцэтгэлийн үнэлгээнүүдийг шаардлагатай эцэг эхчүүдэд маань харах энэ боломжуудыг олгож байна. Soril.mn гэж хүүхэд өөрийнхөө эцэг эхчүүд өөрийнхөө сайн дураар яг хүүхэд өнөөдөр яг ямар түвшинд хичээлийн ямар хичээл дээр ямар хичээлийн хоцрогдолтой явж байгаа вэ гэдгээ хардаг дүгнэдэг. Ийм үнэлгээний тал дээр бол ямар ч байсан манай Засгийн газар манай яам бол томоохон ажил хийж үлдээж байгаа ийм салбар болж байгаа гэдэг дээр нүүр бардам хэлчихье гэж бодож байна аа.

Баян-Өлгий аймгийн хувьд бол боловсролын сайд 3 удаа очсон тохиолдол байхгүй болов уу гэж би бодож байгаа. Боловсролын сайдаар ажиллаж байх 3 жилийн хугацаанд би Баян-Өлгий аймаг дээр 3 удаа очиж Баян-Өлгий аймгийн энэ боловсролын чанарыг сайжруулах асуудал дээр нэлээн л өөрөөсөө шалтгаалах энэ Засгийн газар өөрөөсөө шалтгаалах энэ ажлуудыг хийж гүйцэтгэсэн тодорхой үр дүн гарч байгаа. Бид нар Монголын гавьяат багш нараар ахлуулсан 30 гаруй багш нараар ахлуулсан энэ гавьяат багш нарын багуудыг сүүлийн 2 жил сургууль бүр дээр ажиллуулж байна. Маш их том үр дүн гарч байгаа.

Хос хэлний боловсрол дээр урьд нь Хос хэлний боловсрол гэдэг лоозон байдаг байсан бол хос хэлний сурах бичигтэй анх удаа болсон. Тийм учраас энэ хүүхдийг өнөөдөр нөгөө хаана амьдарч байна хаана сурч байгаагаас нь үл шалтгаалж чанартай боловсрол эзэмших энэ чиглэл рүү бол хамгийн гол үр дүн гарч байгаа аймаг бол би Баян-Өлгий аймаг гээд тэр

нүүр бардам хэлчихье гэж бодож байна. Баян-Өлгий дээр байгаа нэг хамгийн том дутагдал гэх үү, хамгийн том асуудал гэх үү энэ тендертэй холбоотой асуудал байгаа юм аа. Энэ их тийм нэг аймгийн соёл гээд хэлчихэд арай ч хатуу үг болчих болов уу.

Ингээд иргэдийн хөрөнгө оруулалт, техник, тоног төхөөрөмжийн эх үүсвэрүүдийн манай Бейсен гишүүний хувьд бас би онцгойлон талархал илэрхийлье. 2 жил боловсролын салбартаа хамгийн их хөрөнгө оруулалт хийж байгаа гишүүний нэг мөн. Гэтэл харамсалтай нь яг нөгөө батлуулсан мөнгийг нь аймаг дээр нь эрхийг нь шилжүүлчихээр аймгийнх нь иргэдийн Хурлын Төлөөлөгч нар нь хувааж аваад ингээд нэг ийм буруу замаар будаа тээчихдэг нэг ийм түүх нэг ийм муухай соёл Баян-Өлгий аймаг дээр байгаад байна аа. Энийг бид нар ер нь арилгах л ёстой. Тийм учраас миний түрүүний хэлдэг энэ тендерийн хонгил гэдэг зүйл Баян-Өлгий аймаг дээр жинхэнэ утгаараа үүсчихсэн ийм нөхцөл байж байна. Бид нар тодорхой Баян-Өлгий зарим компаниудыг бид нар хар жагсаалтад оруулах энэ саналуудыг бас Сангийн яаманд, Засгийн газарт бас хүргүүлсэн байгаа.

Л.Мөнхбаатар: Тодруулга байхгүй дэгээрээ 5 минутад багтааж асуултаа асууна, хариултаа авна. Дашидондогийн Ганбат гишүүн асуултаа асууя.

Д.Ганбат: Яах вэ боловсролын асуудал бол аягүй чухал асуудал л даа. Ядуурал дээр нэмэгдээд дээр нь боловсролын ядууралд орчихвол бид нар бүүр энэ юмнаасаа мөд нэг хэсэгтээ гарч чаддаггүй. Энэн шиг их мөнгөтэй энэн шиг эрх мэдэлтэй энэ Засгийн газар байгаагүй. Сүүлийн 30 жилд бид нар боловсролыг эрхэмлэдэг ийм ард түмэн л дээ. Тэр уламжлал ч гэсэн байх шиг байна.

Эрхэм баян эрдэм ном гээд л ингээд л ярьж байдаг ийм сэтгэхүйтэй. Бид нар өөрсдөө хоосон хоноод ч хамаагүй яаж ийгээд л хүүхдээ эрдэм боловсролтой болгочихъё гэж боддог. Манай хүүхдүүд ч гэсэн өөрсдөө маш сайн материал IQ өндөртэй ийм байсан. Хэдийгээр бид нар муу хэлээд байдаг байсан социализмын үед ч гэсэн тэр сургалт боловсролоороо сайн байсан учраас энэ шилжилтийн үеийг бид нар амжилттай давж чадсан. Боловсролын салбар дээр бол их олон сайд солигдлоо. Та арай дөнгүүр сайд тэгээд 3 жил ажиллаж байх шиг байна. Гэхдээ бас санаанд хүрэхгүй байна аа. Энэ олон улсын гаднын байгууллагуудын дүгнэлтээр энэ Монгол хүүхдүүд чинь 3.5-аас 4 жил хоцрогдсон байна шүү дээ үеийнхнээсээ дэлхий нийтийн хэмжээнд.

Тэрнээс биш бид нар өөрөө өөрсдөө ч юм уу, та нар өөрөө өөрсдөө бид нар ийм сайхан байна сайн байна гээд ингээд ярих тусдаа хэрэг. Тэгээд энэ сэргэлт гэж яриад байгаа зүйлээ энэ боловсролыг яг өнөөдрийн түвшинд хүрэх юмаа танаас бол нэлээн гайгүй юм хүлээж байсан л даа. Зарим нэг бид нарын хөгжил дэвшил байна байна. Тэр англи хэлийг гол хэл болгож судалъя барья гэсэн. Энэ зөв зүйтэй ийм боловсролын хуульд өөрчлөлт орсон. Бас манай Дамдинням гишүүн ч гэсэн их зүтгэсэн. Сайд ч өөрөө зүтгэсэн байх, энийг бол хийсэн. Цаашидаа өөр нэмээд сайн өөрчлөлт хиймээр байгаа байхгүй юу. Бид нар чинь энэ 2 хөршөөсөө аль болохоор ялгагдахыг боддог. Үеийн үед л тийм байсан. Шашин номоо хүртэл Энэтхэгээс залж байсан ийм түүхтэй. Тэгээд энэ кирилл үсгээ латин үсгээ сольчих боломж бий юу? Тэгвэл жинхэнэ өөрчлөлт болох гээд байна, жинхэнэ сэргэлт болох гээд байна.

Бид нар Казахстанас үлгэр дуурайлал авч болж байна шүү дээ. Нэг үе бид нар кирилл үсэг биш латин үсэгтэй байсан. 1939 оны үед байх. Тэгээд ч мэдлэг мэдээллийн 70, 80 хувь нь бол интернэт дээр, англи хэл дээр. Тэгээд латин үсгээр

байна. Ийм зүйлийг бас хийчихвэл зүгээр байсан юм гэж хэлмээр байгаа юм. Энхийг танаас хүлээж байлаа. Нөгөө талаар бол 6 настай хүүхдүүд сургуульд ордог болсон. Энэ дэлхий нийтийн жишиг л дээ. Энэ зөв л дөө. Хөдөө орон нутагт энэ бол хүндрэлтэй байдаг. Тухайн үед үе үед нь бид нар энийг шийдээд явдаг байсан. Ийм хүнд бэрхшээлтэй нөхцөлийг. Бид нар аймгийн төв дээр ч юм уу эсвэл 3, 4 аймгийг нийлүүлээд ч юм уу тэр хүүхдүүдийг 6, 7 настай хүүхдүүдийг нэг анги болгоод нэг сургууль болгоод сайн багш нарыг аваачаад ингээж хичээллүүлж болох боломжтой. Энийг судалж үзсэн үү? Тэгээд 5 дахь өдөр ч юм уу бүх гэр оронд нь тойроод тараагаад өгчихдөг суман дээр нь хүлээгээд авчихдаг ийм боломж байгаа.

Тэрнээс аль болохоор хялбарчлаад ингээж шийдэж болохгүй юм гэсэн ийм бодол байдаг шүү. Энэ Улаанбаатар хотод та нарын сурталчилгаа бол сугалаагүй цэцэрлэгт явдаг болчихлоо энэ тэр гээд л нэг тиймэрхүү л хэмжээнд л явах юм л даа. Нэг ангид 30, 40 хүүхэд сурч байна. Тэр хувийн сургуулиудыг дэмжих хэрэгтэй. Ад үзээд байх шаардлага байхгүй. Тэд нар чинь бас ачааллын, улс орны ачааллыг төрийн ачааллыг бас зохих хэмжээнд үүрье гээд өөрсдөө бас ингээд зүтгэж байна шүү дээ. Тэгээд сургалт бол олон төрөлтэй эх эцэг нь сонгох ийм боломжтой байх нь зөв зүйтэй. Гэтэл хувийн сургууль мөнгөө төлөөд сураад байхад тэрний боловсролын ялгаа чанар энэ тэр бол шаардлагын хэмжээнд хүрэхгүй бараг 50, 60 хүүхэдтэй нэг ангид байгаа тэр сургуулиудаас ялгарах юм алга гэж ярих юм. Энэ тийм байгаа юу ямар байгаа юм? Энэний учир шалтгаан нь юундаа байдаг юм бэ? Уг нь хувийн сургуулиуд нь магнайлаад тэрний араас манай улсын сургуулиуд хоцрохгүй ингээж явах ёстой байтал харин хувийн сургуулиуд нь тийм үр дүнтэй биш ажиллаж байна гэсэн ийм мэдээлэл байх юм. Энэ яг ямар учиртай юм.

Л.Мөнхбаатар: Ганбат гишүүний асуултад хариулъя. Энх-Амгалан сайд хариулъя.

Л.Энх-Амгалан: Ганбат гишүүнтэй санал нэг байна аа. Бид нар бас сайн материалаар муу бүтээгдэхүүн хийдэг л ийм боловсролын тогтолцоотой болчихсон юм байна лээ л дээ, болгочихсон юм байна лээ. Тэгээд бид нар ингээд энэ боловсролд хийж байгаа энэ реформын шинэчлэлүүдийг аль нэг нь тийм улс төрчийн улс төрийн намын гэнэтийн шийдвэр гаргаж ямар сайндаа сүүлийн 30 жилд 10 удаагийн хөтөлбөрийн шинэчлэл хийсэн улс орон байхгүй болов уу гэж бодож байгаа. Тэгээд гэнэтийн ийм шийдвэрүүдийн золиос нь өөрөө боловсрол болчихдог.

Тэр золиос нь багш нар болдог, хүүхдүүд болдог энэ тогтолцооноос л бид нар салах ёстой гэж ойлгож байгаа. Тэгэхээр 6 настай хүүхдүүд бол илүү эцэг эхтэйгээ ч, цэцэрлэгтэйгээ л ойрхон байх нь зөв байх л даа. Ямар ч байсан энэ малчдын хүүхэд дээр байгаа асуудал дээр бид нар Боловсролын багц хууль дээр сонголт өгсөн 7 настай хүүхэд 7 нас хүрээд сургуульд орох энэ боломж нь өнөөдөр энэ боловсролын багц хуулиар нээгдсэн байгаа.

Харин таны хөндөж тавьж байгаа энэ санал бол бид нар энэ ахлах сургуулийн хэмжээнд хийгдэх ёстой ажил гэж бодож байгаа юм Ганбат гишүүн ээ. Хуучин ч гэсэн манай энэ социализмын тогтолцоонд байсан. Өнөөдөр манай 330 сумд 12 жилийн тогтолцооны энэ сургуультай ийм үр ашиггүй сургуулийн тогтолцоог хийчихсэн улс орон их ховор болов уу гэж бодож байгаа юм. Цаашидаа бид нар сум дундын аймгийн төв дээр байгаа сургуулиуд, Улаанбаатар хот дээрх сургуулиудын хэв шинжүүдээ эргэж харж төрөлжсөн ахлах сургуулиудыг байгуулах нь илүү боловсролын чанарыг өгөөжийг нэмэхэд бол маш чухал ач холбогдолтой ийм зүйл байдаг юм байна

лээ гэж ойлгож байгаа. Сугалаагүй цэцэрлэг гэж шоу хийгээд байна гэж байна. Та хүүхэдгүй ачгүй учраас мэдэхгүй байгаа байх аа. Ямар ч байсан хүүхдээ цоожтой хаалганы цаана түгжчихээд олон зуун мянган эцэг эхчүүд шаналж байсан энэ цаг үе саяхан шүү. Манайхан хүний сайн хийсэн юмыг ингээд нэг ийм амархан мартчихдаг нэг ийм загасны ой санамжтай ийм хүмүүс.

Ямар ч байсан энэ Засгийн газрын нүүр бардам хэлэх зүйл бол бид нар ямар ч байсан энэ цэцэрлэгийн хүртээмжийг бид нар 96 хувьд хүргэсэн. Ганбат гишүүнээ 96 хувьд хүргэсэн. Энэ бол бүс нутгийн хэмжээнд байх томоохон амжилт гээд Юнейскоогоос хүртэл бид нарыг чемпионс гэж шалгаруулаа шүү дээ. Энийг бол бас үр дүн гэж ойлгох ёстой байх.

Өнөөдөр Монгол Улсад бүх ангид 30, 40 хүүхэд 50, 60-уулаа сурч байгаа. Ийм ойлголтыг төрүүлж болохгүй ээ. Одоо бид нар биг дататай болсон. Аль анги дээр, аль сургууль дээр өнөөдөр 45 хүүхдээс дээш бүлэг бүрдэж байна вэ гэдгийг бид нар өнөөдөр Монгол Улсын хэмжээнд хардаг болсон. 67 сургууль дээр 3 ээлжийн сургуулийн асуудал байсан. Энийг энэ Засгийн газар шийдвэрлэсэн. Цаашидаа та бүгдийн хэлж байгаа бид нар хүртээмжээс илүү энэ боловсролын чанарыг нэмэх чиглэл рүү онцгойлон анхаарч ажиллана аа.

Тийм ч учраас энэ боловсролын шинэ сэргэлтийн бодлогыг зарлаж ажиллаж байгаа юм аа.

Төрийн сургууль, хувийн сургуулийн ялгаа онц байхгүй байна гэж та хэлчих шиг боллоо гэж надаас асууж байх шиг байна. Тиймээ саяын PISA-ийн үнэлгээгээр олон улсын үнэлгээгээр хөдөөгийн сургууль* хотын сургууль нар чинь ялгаа гарчихсан байна аа. Харин өндөр төлбөртэй хувийн сургууль, улсын сургуулиудын чинь хооронд ялгаа гараагүй юм байна шүү гэдгийг хэлж байгаа юм.

Тийм учраас манай хувийн сургуулийнхан энэ дээр дүгнэлт хийх ёстой. Өнөөдөр хувийн сургууль, төрийн сургуулиудын ялгаа математикийн гүйцэтгэл дээр 417, 426. Математикийн гүйцэтгэл дээр улсын сургууль нь илүү, унших дээр 366, 380, байгалийн ухаан дээр 404, 417 дээр энэ өндөр төлбөртэй сургуулиуд чинь өнөөдөр төрийн өмчийн сургуулиудын өгч байгаа боловсролын түвшинд хурч чадахгүй байна л гэдэг дүгнэлт гарчихсан юм.

Тийм учраас цаашидаа ер нь бол энэ манай эцэг эхчүүд асран хамгаалагчид бол энэ дээр сайн дүгнэлт өгөх байлгүй. Нэг өгсөн сонирхолтой дүгнэлт бол дундаж давхаргынхан хүүхдээ өндөр төлбөртэй сургуульд орж байгаа нь үр ашиггүй байна шүү гэдэг дүгнэлтийг энэ PISA хийгээд өгчихсөн шүү.

Би сая хийгээд өгчихсөн. Тийм учраас бид нар төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгаж хамгийн сайн сургууль гэрт ойрхон байх сургуулийн тогтолцоог л.

Л.Мөнхбаатар: Цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109.11-д заасны дагуу ди парламент цахим хэлэлцүүлгийн платформ дээр байршуулсан Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан иргэдээс ирүүлсэн саналуудыг Засгийн газрын гишүүнээс асууна.

Улсын Их Хурал дахь МАН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Гонгорын Дамдинням, Засгийн газрын гишүүнээс асуулт асууна.

Асуултаа асуугаад Энх-Амгалан сайд шууд хариулаад явахаар ингээд яачихъя. Техникийн нөхцөлийг бүрдүүлчих.

Ингээд нийт хугацаа 20 минут хүртэл хугацаа байгаа шүү. Ингээд Дамдинням гишүүний болон Энх-Амгалан сайдын микрофоныг нээе.

Тийм асуултаа асуугаад, хариултаа аваад явж болно. Бүх асуултаа тавиад хариултаа авч болно. Тэрийгээ Дамдинням гишүүн өөрөө сонгох юм байна. Дамдинням гишүүний микрофоныг өгөөрэй.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе ээ.

Боловсролын шинэчлэлтэй холбоотой хийгдэж байгаа хамгийн том ажлуудын нэг бол энэ их олон улсын үнэлгээнд Монголын боловсрол хамрагддаг болсон. Энэ шинэ жишиг бол түүхэнд үлдэх байх гэж би боддог. Боловсролын багц хуулийг удирдаж чиглүүлж ажиллахдаа бол бас энийг нэлээн их түлхэж хийж оруулсан. Харин манай БШУЯ-ныхан маань бэлтгэл ажлыг сайн хангаж хэмжээд авлаа, бас манай сөрөг хүчний гишүүд маань бас өнгөрсөн 24 жилийн хугацаанд бидний алдаа онооны үр дүнг өнөөдрийн ганц сайдаас асуух бас жсоохон явдалтай. Тэгэхдээ бас асууж байгаа юмнуудад нь үндэслэл байна. Хийсэн сайн зүйлсийг бол бид нар дэмжинэ. Тийм.

Тийм учраас цэцэрлэгийн хүртээмж сайжирсан саяын PISA-ийн үнэлгээг хийсэн энэ ажлууд бол энэ Боловсролын сайд энэ энэ Засгийн газрын үед хийгдэж байгаа том ажлууд мөн. Энэ Их Хурлын үед хийгдэж байгаа хамгийн том ажлууд манай Энх-Амгалан сайд бас дурдахгүй байх шиг байна. Энэ Их Хурлын үед хийгдэж байгаа хамгийн том ажил бол өнгөрсөн энэ 34 жилийн хугацаанд бид нар Монголын боловсролын тогтолцоог СӨБ-оос нь ерөнхий боловсрол, дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсрол хүртэл нь цогцоор нь харсан эрх зүйн реформыг хийсэн. Бас хаа

хаанаа хийсэн юмнуудаа дурдаж байх ёстой байх.

Энэний үр дүнд манай боловсролын салбарын шинэ өөрчлөлтүүд хийгдээд явах ёстой. Тэгэхээр энэ гарч байгаа энэ том багц хууль гарсны дараа 120 гаруй журмууд гарах юм. 120 гаруй журмууд маань Энх-Амгалан сайдаа хэр хэмжээнд явж байна. Хэд нь гарсан байгаа вэ? Захаасаа гарч байгаа журмууд дээр нэлээн шүүмжлэл дагуулсан асуудлууд яригдаж байна. Энэн дээр нэг тайлбар өгөөч.

Нэгдүгээрт бид нар бас энэ Монголын боловсролыг өөд нь татах хамгийн нэгдүгээр гарц бол багш нараа анхаарч үзье. Нийгмийн баталгааг нь сайжруулъя. Цалин урамшууллыг нь сайжруулъя. Ажиллах амьдрах орчныг нь сайжруулъя гэдэг өөрчлөлтүүдийг бид нар хуульд хийсэн. Багш нар ажиллаж байгаа эхний 5 жилдээ 6 сарын цалинтай тэнцэх урамшууллыг авна. Энэ урамшуулал цаашидаа 3 сар тутам хэрэгжээд олгогдоод 3 жил тутамд 6 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшууллыг аваад явна гэдэг нэгдүгээр ийм заалт маш чухал заалт орсон. Эндээс жирэмсний амралттай байгаа багш нарыг хасаад байна гэдэг ийм асуудал яригдаж байгаа. Тэгээд бид нар чинь хүн амын бодлогоороо хүн амаа нэмэгдүүлэх ёстой. Зах зээлээ тэлэх ёстой гэдэг байр суурь бариад яваад байгаа боловч бас үндсэн ажлаа эмэгтэйчүүдийнхээ энэ хүүхэд төрүүлэхэд нь бид нар бас энэ нийгмийн даатгалын шимтгэл дээр нь нэг хүүхэд тутам 1.6 жилээр тооцож олгоод ингээд үндсэндээ төрийн бодлого бол хүн амаа өсгөх чиглэлд яваад байгаа юм. Одоо энэ ялангуяа энэ залуу эмэгтэй багш нар манай багшлах боловсон хүчний дийлэнх хувийг эзэлж байгаа. Энэ хүмүүс энэ 3, 5 жилийн нэмэгдлээ авахад жирэмсний амралт нөлөөлөөд байна. Бид нарыг нэг бол хүүхэд битгий төрүүл, нэг бол ажлаа ингээд хийгээд яв гэдэг ийм сонголтод

тулгаад байна гэдэг асуулт маш их ирж байна.

Энэ дээр зохицуулалт хийж болохгүй юу? Нэгдүгээр асуулт.

Хоёрдугаар асуулт боловсролын салбарт ажиллаж байгаа боловсролын салбар өөрөө бүх хүмүүсийн оролцоогоор явагдаж байдаг. Сургуулийн орчинд ажиллаж байгаа. Хөдөөгийн сумын сургуульд ажиллаж байгаа галч хүртэл энэ боловсролын салбарт хувь нэмрээ оруулж байгаа. Тогооч оруулж байгаа, захиргааны ажилтан оруулж байгаа, захирал оруулж байгаа менежерүүд орлого оруулж байгаа, санхүүгийн ажилтнууд оруулж байгаа юм. Энэ хүмүүсийн нэг хүүхдийг үнэ төлбөргүй сургана гэдэг заалт Боловсролын хуульд уг нь хийж өгсөн. Гэтэл энэ нэн тэргүүний гэдэг бид нар энэ журмаа оруулаад явахаар энэ нэн тэргүүний ээлжид энд Монгол Улсад шаардлагатай мэргэжлээр сургахаараа энэ шаардлагатай мэргэжлийн жагсаалтаа яаж батлаад байгаа юм бэ? Мультимедиа инженерээр сурах.

Ингээд юуны асуудал үүсэж байгаа вэ гэхээр энд хөөрхий насаараа боловсролын салбарт ажиллачихсан энэ боловсролын салбарын ажилтнууд өөрийнхөө нэг хүүхдийг үнэ төлбөргүй чухал мэргэжлээр сургах нь гэсэн инженер техникийн ажилчдыг бид нар тэргүүн эгнээнд тавина гэсэн боловч энэ код гэдэг юмаар нь хуваагаад мультимедиа инженер Монгол Улсад нэн хэрэгтэй мэргэжил мөн. Тийм нарийн мэргэжлийн инженерүүдийг энэ жагсаалтдаа оруулаагүй байна гэдэг асуудлууд яригдаж байна аа. Энэ журмууд дээрээ та нар ер нь ямар анхаарал хандуулж байгаа вэ? Энэ дээр бас засаж залруулах боломж ч байгаа юу?

Гуравдугаар асуулт маш том улс төр олон нийтийн дэмжлэгтэйгээр бид нар англи хэлийг Монголын боловсролын

үндсэн гадаад хэл болгоно гэдэг заалтыг оруулсан. Энэ ажлын хэрэгжилт ямар явагдаж байгаа вэ? Энэ ажил сайн хийгдэж байж Монголын бүх хүүхдүүд бүх түвшиндээ боловсролынхоо бүх шатдаа Англи хэлийг өндөр түвшинд сурч байж PISA-ийн шалгалтыг маш амжилттай өгөх бас нэг гарц болно. Онлайнаар дэлхийн хамгийн сайн сургуулиудын хичээлийг үнэ төлбөргүй үздэг болно.

Монгол Улсын Ерөнхий сайд АНУ-д айлчлахдаа АНУ энэ дээр бас тусалцаа үзүүлнэ гэдэг асуудлыг ярьсан. Хүүхдүүдийг бас энэ англи хэлээр сургаж өгөх, англи хэл заах хүмүүсийг сургана гэдэг асуудал ярьсан. Энэ ер нь хаана явж байгаа вэ? Гуравдугаар асуулт.

Дөрөвдүгээр асуулт энэ хувийн хэвшлийн сургуулиудыг хувийн хэвшлийн энэ төрийн ачааг үүрэлцэж байгаа салбараа ер нь бас жоохон бодож дуугарч баймаар байна даа гэсэн ийм байр суурьтай байгаа шүү. Төр энэ хувийн хэвшлийн дааж байгаа 40 гаруй мянган хүүхдүүдэд зориулаад сургууль соёлын байгууллага байгуулаад явах хөрөнгө оруулалтын мөнгө бид нар т байхгүй.

Тийм учраас бид нар хувьсах зардлаа өгөөд энэ хүмүүсээр хүүхдүүддээ Үндсэн хуульд заасан үнэ төлбөргүй боловсрол эзэмших энэ боломжийг нь бид нар хангаж ингэж явдаг. Төрийн сургууль хувийн сургууль 2 хоорондоо чанарын ялгаа муу байхгүй гэдэг нь төрийн сургуулийн сайныг яриад байгаа болохоос хувийн сургуулийн мууг яриад байгаа асуудал ерөөсөө ч биш гэж харж байгаа юм. Энэ сургуульд бас чамгүй олон тооны багш нар, чамгүй олон тооны хүн ажиллаж байгаа. Энэ хүмүүсийн нийгмийн баталгааг хангах чиглэлийг бас хуулиудад бид нар тусгаж өгсөн.

Тэгэхээр энэн дээр энэ Засгийн газраас дагаж гарах журмууд дээрээ та нар ямар зүйлүүдийг оруулж байгаа вэ?

Тэнд чинь бас л ялгаагүй Монгол хүүхэд сурч байгаа. Тэнд чинь бас л ялгаагүй нэг Монголын иргэн багшилж байгаа, ажиллаж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ хүмүүсийн асуудлыг бид нар ярьж баймаар байна. Ядаж нэг төсөл хөтөлбөрүүддээ хамруулж байдаг юм баймаар байна. Монгол Улсын Боловсролын яам болохоос Монгол Улсын төрийн өмчийн их дээд сургууль, ерөнхий боловсролын Боловсролын яам биш шүү дээ. Тэгэхээр бүгдэд нь тэгш хандах тухай асуудлаа бид нар бас яримаар байгаа шүү.

Эцэст нь энэ төрийн албаны ёс зүйтэй холбоотой асуулт байна. Би маш тодорхой жишээгээр Дархан-Уул аймгийн Боловсролын газрын даргыг үүрэг гүйцэтгэж байгаа хүний асуудлыг танд Энх-Амгалан сайдад тавьсан бичгээр. Төрийн албаны захирах, захирагдах ёс, эрэмбэ дараа, ёс зүйн асуудал ерөөсөө байхгүй. Ийм хүмүүсийн асуудлыг шийд гэдэг асуудал тавихад та ёс зүйн дүрэм Төрийн албаны ёс зүйн дүрэм маань батлагдаагүй байгаа учраас хариуцлага тооцох боломжгүй байна гэдэг хариултыг танай яамнаас ирүүлсэн байсан.

Энэ журам чинь батлагдсан уу? Батлагдсан бол энэ тодорхой хүмүүст энэ манай салбарын нэр хүндийг шороотой нь хутгаж байгаа чадваргүй мөртөөсөө амбиц хөөсөн энэ хүмүүсийн асуудал шийдэгдэхгүй байхгүй юу. Түүрүүний энэ Ганбат гишүүний манай энэ бусад сөрөг хүчний гишүүдийн яриад байгаа энэ боловсон хүчний асуудал байна шүү дээ.

Бид нар боловсон хүчнээ сайн болгоё гэж бүх талаар дэмжиж байгаа. Чадах чинээгээрээ засаг бол хичээж байгаа, Их Хурал хичээж байгаа. Ёс зүйгүй хүмүүс энэ дотор байна. Энэ хүмүүсийг яаж шийдэх вэ гэдэг энэ асуудал байна. Өөрөөр хэлбэл энэ дүрэм журмаа та нар хэзээ баталж гаргах юм,

яаж хэрэгжүүлэх юм? Хэрэгжиж байгаа юу? Ийм ийм асуулт байна даа.

Л.Мөнхбаатар: Асуултад хариулъя. Боловсрол шинжлэх ухааны сайд.

Л.Энх-Амгалан: Дамдинням гишүүнд талархах ёстой.

Дамдинням гишүүн бас Боловсролын багц хуулийг ажлын хэсгийг ахалж маш сайн ажилласан гэж би бодож байгаа. Түүрүүн өөрөө хоцроод ороод ирсэн юм шиг байна. Би үгийнхээ эхэнд Монгол Улсын Их Хурлын бараг үлдээх ёстой өвүүдийн нэг нь энэ Боловсролын багц хууль байна гэдгийг би хэлсэн. СӨБ ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсрол, дээд боловсрол, насан туршийн боловсролын төв тогтолцоонд суурилсан ийм эрх зүйн шинэчлэлийг хийсэн анхны Их Хурал. Энэ Их Хурлын гүйцэтгэсэн үүрэг гэж ойлгож байгаа. Тэр дотроос Дамдинням гишүүн бол энэ хуулийг, багц хуулийг ахалж, нэлээн сэтгэл гаргаж, цаг гаргаж бас нийгмийн зөвшилцлийн хүрээнд гарсан ийм хууль бас их амархан гараагүй.

Энэ хууль бас нийгмийн зөвшилцлийг олоход бас хэцүү байсан. Сүүлийн 2 жил бас энэ дээр нэлээн сэтгэл гаргаж ажилласан гишүүн гэдгийг бас би бүүр онцолж бас хэлье гэж бодож байна.

Хоёрдугаар асуудал энэ журмын хэрэгжилттэй холбоотой асуудал байгаа. Яах вэ нийт нийт 120 гээд та хэлчих шиг боллоо. Бид нарын юугаар бол 70 орчим журмын хэрэгжилтийн асуудал ярьж байгаа. Одоо ямар ч байсан нэг 50 гаруй хувь нь Засгийн газраар батлагдаад журам хэрэгжиж эхэлсэн. Ингээд зарим журмууд Засгийн газраар хэлэлцэгдэхээр саналууд нь аваад ингээд явж байгаа. Энэ бас журмууд бол цаг хугацаандаа явна. Ямар ч байсан бид нар журмууд дээрээ нэг эрэмбэ тавиад хамгийн түрүүнд энэ улсын төсвийн хэрэгжилттэй холбоотой,

хуулийн хэрэгжилттэй холбоотой, цаг хугацаа шаардсан томоохон журмууд дээрээ анхаарал тавьж энэ журмуудынхаа хэрэгжилтийг хангаж ажиллаж байгаа. Зарим гарч байгаа журмууд дээр юу гэдэг юм амьдралд хэрэгжээд эхлэхээр хууль өөрөө амьдралаар шалгадаг ийм журамтай, ийм ёстой.

Тэгэхээр ингээд одоо энэ хууль маань бас яг амьдрал дээр буугаад ирэхээр зарим нэг зүйлүүд дээр асуудал гарч ирж байгаа зүйлүүд бий. Засах залруулах ч зүйлүүд байна. Хэзээ ч Монгол Улс хэзээ ч төгс төгөлдөр хууль гэж байдаггүй. Энэ дээр харин та нэг буруу ойлголттой байх шиг байна. Зүгээр танд ямар нэг хүн ойлгуулсан байгаа юм? Ингээд энэ багш нарын 5, 5 жил ажиллаад 5 жилээс дээш ажилласан багш нар 3 жил тутам ганцхан багш биш шүү дээ бас боловсролын салбарын ажилтнууд энэ б сартай тэнцэх цалингийн нэмэгдлийг авах энэ журам маань батлагдсан, хэрэгжиж эхэлсэн. Тэгэхдээ энэ дээр жирэмсэн болоод хүүхдийнхээ юу декретийн амралтаа аваад яг төрөх хүртэлх хугацаандаа хуулийн хүрээнд байгаа энэ хугацаанд дээр тэр журмууд, тэр хугацаанууд нь тооцогдохгүй байна. Тасарчих гээд байна. Тэрэнд нь тэр хугацаанд нь энэ урамшуулал нэмэгдлүүд олдохгүй болчих гээд байна гэдэг нэг ийм буруу ташаа мэдээлэл байна.

Яг л Хөдөлмөрийн хуулиар яг жирэмсэн болоод декретийнхээ амралтыг аваад декретийнхээ амралтын хугацаанд ажилдаа буцаж орж ирж байгаа энэ хугацааг бид нар тасралтгүй ажиллах хугацаанд тооцож урамшуулалд тооцох хугацаанд дээр урамшууллыг нь бодож олгоно. Энэ дээр ямар нэгэн харин нэг асуудал гарч ирж байгаа. Зарим багш нар өөрөө декретийнх нь хугацаа дуусаад ажилдаа орж ирэхгүйгээр 3 жил хугацаанд би хүүхдээ өөрөө асаръя, гэрээр асаръя аа. Энэ хугацааг тасралтгүйгээр тооцож тэр хугацааны 3 жилийн

нэмэгдлийг олго гэж байгаа байхгүй юу. Энэ 2 өөр ойлголт шүү дээ. Тэгэхээр бид нар энэ 3 жилийн тутмын нэмэгдлийг чинь хамгийн сайн багш нартаа гүйцэтгэл гаргаж байгаа багш нартаа олгох ийм тогтолцооны асуудал болохоос биш, хүүхдээ 3 жил хараадах тэгвэл тэрийг чинь дахиад 3 жилийн нэмэгдэлд нь оруулаад өгье өө гэдэг ийм бодлого хэзээ ч байж болохгүй.

Тэгэхээр энэ дээр жаахан буруу ташаа юунууд ингээд ойлголтууд гарсан юм байна лээ. Энийг ингээд засаад залруулаад явж байгаа гэдгийг бас би танд хэлчихье. Жишээ нь 3 жил нэг хүүхэд гаргаад 3 жил гэртээ асарчхаад би 3 жилийнхээ нэмэгдлийг авъя. Дахиад хүүхэд гаргаад 6 жил гэртээ асарчхаад би дахиад 3 дахь жилийнхээ нэмэгдлийг авъя. 3 дахь хүүхдээ төрүүлээд би 9 жил гэртээ хүүхдээ асармаар байна. 3 жил тутмынхаа нэмэгдлийг авч болох уу л гэдэг асуулт байхгүй юу. Ийм л асуулт байхгүй юу.

Тэгэхээр энийг бол манай боловсролын салбарынхан бусад энэ төрийн нэмэгдэл авч байгаа салбарынхан бол ойлгох ийм зааг ялгаатай ойлгох ийм зайлшгүй шаардлага үүсэж байгаа гэж ойлгож байгаа юм. Тэр боловсролын салбарт 15 жил буюу түүнээс дээш тасралтгүй ажилласан багш сурган хүмүүжүүлэгч нар боловсролын салбарын ажилтнуудын хүүхдүүдийг төрийн өмчийн сургуульд сургалтын төлбөрийн зардлуудыг нь даах энэ журмууд батлагдсан.

Өнөөдөр хэрэгжээд явж байгаа. Энэ журам дээр бол тэргүүлэх эрэлттэй мэргэжлээр сурч байгаа оюутнууд дээр одоо олгох ийм бид нар хуулийн заалт гарсан учраас энэ хуулийнхаа заалт дээр тэргүүлэх болон эрэлттэй мэргэжлээр. Эхний ээлжид ямар ч байсан. 580 хүүхдийн асуудал эцэг эхчүүдийн асуудал гарч ирж байгаа. Энийгээ бид нар нэгэнт хууль дээр батлагдсан, төсөв нь

батлагдсан журам нь батлагдсан учраас энэ асуудал маань ажил хэрэг болоод явж байгаа.

Гурав дахь асуудал англи хэлний асуудал байгаа. Бид нар 3 дугаар ангиас англи хэлийг зааж эхэлнэ. Энэний бэлтгэл ажлууд хангагдаж байна. Бид нар хөтөлбөрөө хийж байна, сурах бичгийнхээ бэлтгэл ажлуудыг хийж байна. Хамгийн гол нь багийн асуудал гарч ирж байгаа юм. Тийм учраас энэ 3 дугаар анги дээр, 3 4 дүгээр анги дээр англи хэл заах багийн энэ асуудлуудыг бид нар яаж шийдвэрлэх вэ гэдэг дээр бид нар төлөвлөлтүүд хийж байна. Төлөвлөлтүүд хийж байна тэгээд ингээд ямар ч байсан 9 сарын 1-нээс туршилтын байдлаар эхлээд тэгээд ямар ч байсан 2025 оноос бол улсын хэмжээнд энэ хөтөлбөрийн шинэчлэл хийгдэж ингэж явна. Ганцхан англи хэл биш ерөнхийдөө энэ шинэ үндэсний хөтөлбөрийн үндсэн хэрэгжилтүүд 2025 оноос хийгдэх учраас энэ хүрээндээ энэ ажлууд нь хийгдээд явна аа. Давхар ганцхан англи хэл биш бид 1 дүгээр ангиас код буюу компьютерын ухааны хичээлүүдийг бас заах бэлтгэл ажлууд бас хийгдэж явж байгаа гэдгийг бас энэ дашрамд хэлье гэж бодож байна.

Хувийн сургуулийг гадуурхсан, хувийн сургуулийг дэмжихгүй байгаа ямар ч ийм үг үйлдэл гаргаагүй гэдгийг би хариуцлагатайгаар хэлье ээ. Нийт хүүхдийн 10 хувь нь ЕБС-д сурч байгаа үндсэндээ 780 гаруй мянган хүүхдийн дал гаруй мянган буюу 10 хувийн хүүхэд нь энэ хувийн сургуульд сурч байгаа. Бас тодорхой төрд ирж байгаа ачааллыг хувийн хэвилийнхэн үүрэлцэж байгаа. Энэ дээр санал нэг байгаа.

Хувийн сургуулиуд дээр байгаа маш сайн санал санаачилгууд байгаа. Би энийг дэмжинэ ээ. Одоо жишээ нь British school бол манай англи хэлний багш нарын чадварыг дээшлүүлэх зуны сургалтууд, өвлийн сургалтуудыг бас хийдэг багш нараа ажиллуулдаг ийм сайн туршиллагууд

гарч байна. Би хувийн сургууль дээр нэг л зүйлийг ярьж байгаа. Та нар төрийн сургуулиас багш авахгүй шүү. Төрийн сургуулиас багш авдаг. Төрийн сургуулиас гүйцэтгэл өндөртэй хүүхдүүдийг авдаг ийм байдлаар ажиллаж болохгүй ээ. Ерөнхийдөө цаашидаа бид нар энэ төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг л арилгах ёстой юм байгаа юм. Тэр тусмаа өнөөдөр төр өөрөө энэ боловсролын ялгааг санхүүжүүлдэг ийм тогтолцоо руу орчихсон юм байна лээ. Төрийн өмчийн 3 Кембриджийн сургууль гэж нээхээд хамгийн сайн гүйцэтгэлтэй хүүхдүүдийг бүгдийг нь түүж авчхаад хамгийн сайн багш нараа түүж авчхаад жирийн сургуулиас 50 хувийн нэмэгдэл аваад сууж байдаг. Аймаг дээр лаборатори сургууль гэж байгуулаад жирийн сургуулиас 30 хувийн нэмэгдэл аваад төр өөрөө энэ боловсролын чанарыг, ялгааг гаргадаг энэ өдөөгч хүч нь төр өөрөө байж болохгүй байхгүй юу.

Тийм учраас сургууль бүхэн сайн сургууль байх ёстой. Сургууль бүхэн Кембриджийн стандарттай сургууль байх ёстой. Тийм учраас Кембриджийн сургалттай сургуулийн тоог нэмэхээсээ илүү бид нар бүх сургууль төрийн өмчийн сургуулиудыг Кембриджийн стандартын түвшинд хүргүүлэх энэ ажлуудыг л бид нар зохион байгуулж байгаа юм. Боловсролын шинэ сэргэлтийн хүрээнд хийж байгаа 6 энэ ажил бол зургуулаа Кембриджийн стандарт. Боловсролын хөтөлбөр Кембриджийн стандарт боловсролын үнэлгээ бол Кембриджийн стандарт. Ажлын байран дээр багийн тасралтгүй хөгждөг энэ тогтолцоо, үндэсний тогтолцоог PDQ тогтолцоо энэ Кембриджийн стандарт. Нэг хүүхдийг сургаж байгаа үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо буюу хүүхдийн ахиц дэвшил багийн хөгжлийг санхүүжүүлдэг энэ санхүүжилтийн тогтолцоо Кембриджийн стандарт. Багийн стандарт Кембриджийн стандарт. Цахим шилжилт бол

Кембриджийн стандарт. Сургуулийн менежмент Кембриджийн стандарт.

Тийм учраас төрийн өмчийн энэ бүх сургуулиудаа бид нар Кембриджийн стандартын түвшинд хүргэж байж л хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг арилгах одоо нөгөө гэрт ойрхон сургууль бол хамгийн сайн сургууль болох энэ тогтолцоог энэ 6 шинэчлэл дээрээ л хийе гэж бид нар зорьж байгаа.

Төрийн албан хаагчдын ёс зүйн асуудлыг хөндөж тавьж байх шиг байна. Манай Улсын Их Хурлын гишүүд аймгийнхаа Боловсролын газрын даргын асуудлыг л яриад эхэлж байгаа бол бид нар боловсролыг улс төрөөс хараас хараат болгож чадаагүй юм байна л гэж би бодож сууж байна. Тэгж бодож сууж байна. Хууль дээр бид нар цагаан дээр хараар Аймгийн боловсролын газрын даргад тавих шаардлагууд, сургуулийн цэцэрлэгийн удирдлагуудыг тавих шаардлагуудыг бид нар цагаан дээр хараар маш сайн бичиж өгсөн. Гэтэл өнөөдөр Улсын Их Хурлын гишүүд нь аймгийнхаа Боловсролын газрын томилгооны асуудал дээр улс төрийн байр суурь илэрхийлээд оролцож байна гэдэг бол энэ хууль хэрэгжихгүй юм байна л гэж би бодож байна. Хууль хэрэгжихгүй юм байна.

Ийм хэлбэрээр бид нар одоо хандаж тэгээд ийм хэлбэрээр бид нар боловсролын чанарыг сайжруулах асуудал ярих гэж байгаа бол бид нарын бодож байгаа бид нарын хийх гэж байгаа ажилд асар их зөрөөтэй байна л гэж би харж байна. Мэдээж салбар дээр ёс зүйн асуудал байхыг үгүйсгэхгүй. Ёс зүйн асуудал алдсан багш нар, сурган хүмүүжүүлэгч нарыг, бид нарыг ёс зүйн асуудлыг Ёс зүйн зөвлөлөөр нь оруулдаг ийм тогтолцоотой болчихсон байж байгаа.

Тэгэхээр үнэхээр тэр тухайн байгууллага дээр байгаа хүмүүс нь ёс зүйн асуудал гаргасан бол аймгийнхаа одоо тэр төрийн албаны ёс зүйн зөвлөл сургууль дээр байгаа ёс зүйн зөвлөл дээрээ тэр л энэ асуудал нь шийдвэрлэгдээд явах болов уу л гэж бодож байна.

Л.Мөнхбаатар: 59 секунд дуу байна шүү.

Г.Дамдинням: Энх-Амгалан сайд 2 л асуудал байна даа. Нэгдүгээрт та би, танай одоо шинэ Боловсролын хуулиар энэ томилгооны асуудлыг яам болон Боловсролын ерөнхий агентлагт ирсэн. Энд ёс зүй сахиулах үүрэг хариуцлага нь танд байна аа. Та өмнө нь энэ асуудал баримттай юм байна, нотолгоотой юм байна, журам маань гараагүй учраас бид нар энд үнэлгээ дүгнэлт хийж чадахгүй байна гэдэг хариулт өгч байсан. Эндээ л хариулт өгөөдхөөч л гэж байгаа юм. Журам чинь гарсан уу? Аймаг дээрээ энэ яригдах боломжгүй болчихсон шүү дээ. Энэ бол Боловсролын ерөнхий газар яригддаг болсон. Тэгэхээр энэ дээр би улс төржөөд байгаа биш зүгээр л хариуцлага чинь болсон уу, яасан уу.

Л.Мөнхбаатар: Журам гарсан уу гэж асуугаад байгаа юм байна. Тэнд нь хариулчих тэгээд хугацаа дуусаж байна.

Л.Энх-Амгалан: ТАЗ-өөс энэ журмыг баталж ирүүлсэн. Тэгээд энэ журам бол хэрэгжиж эхэлсэн байгаа. Тэгээд энэ хүрээндээ таны гаргасан гомдол, таны гаргасан асуудлуудыг бас бид нар эргэж хариу өгнө өө.

Л.Мөнхбаатар: Асуулт асууж, хариулт авч дууслаа. Дамдинням гишүүнд баярлалаа.

Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурлын гишүүн Улсын Их Хурал дахь АН-ын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл Засгийн газрын

гишүүнээс асуулт асууна. 20 минутад багтаан асуулт хариулт явагдана дэг мөн адил байгаа. Цогтгэрэл дарга. Энх-Амгалан сайд 2-ын микрофоныг нээе асуулт хариултаа явуулъя. Цогтгэрэл даргын микрофоныг өгөөрэй.

О.Цогтгэрэл: Саяын тайлангийн дүнгүүдээс ч харсан ер нь манай боловсролын тогтолцоо олон зүйлийг ч харсан. Ер нь манай боловсрол дахиад салбар хооронд, хот хөдөөгийн ялгаа бас Монгол дотооддоо асар их болчихсон. Энэ ялгаа нь өөрөө явсаар байгаад боловсролын ялгаа өөрөө амьдралын ялгаа болж хувирах ийм л орлогын ялгаа болж хувирах ийм л нөхцөл байдал аль хэдийн ингээд үүсчихсэн учраас боловсролын асуудал асар их чухал аа. Дахиад Монгол Улсын хувьд Монгол Улсын бүтээмж техник технологи олон олон зүйл олон улсын түвшинд ямар байгаа билээ? Энэ дээр дахиад л бид нарт боловсролын асуудал ямар чухал байгааг л бас харуулж байна.

Миний хувьд бас Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдсоноос хойш ер нь өмнө ч гэсэн тэр сонгогдсоноос хойш Увс аймагт сонгогдож гарсан тойргийн аймагтай боловсролд гэрэл нэмье гэдэг төслөөр бас үндсэндээ энэ улс төрийн бараг зорилгогүй сургуулийн дунд сургуулийн жоохон хүүхдүүдтэй ажиллаж байгаа олон олон төслүүдийг бас хэрэгжүүлсэн. Тэр тусмаа энэ “Боловсролд гэрэл нэмье” төслийг 3 4 жилийн хугацаанд бас энэ энд ямар нэгэн төсвийн хөрөнгө мөнгө биш 100 хувь бас тийм хувийн байдлаар бас бусад боловсролд ээлтэй хүмүүсийн энэ оролцоо дэмжлэгээр өнгөрсөн хугацаанд физик, математикийн хичээлээр хими, биологийн хичээлээр тодорхой үр дүнгүүд гаргах гэж бас нэлээн олон ажлуудыг хийсэн. Бас эхний байдлаар ч гэсэн эдгээр чинь энэ зөвхөн нэг ийм байшин барилга унаа машин биш. Эдгээр нь яг сургалтын хөтөлбөртэй холбоотой чанартай холбоотой. Тэр тусмаа дижитал

технологи онлайнаар холоос хэрхэн яаж үр дүн гаргаж болох вэ? бүүр АНУ болоод үндсэндээ энэ Монгол хүүхдүүд, Монголын хөдөөгийн хүүхдүүд, гадаадад амжилттай сурч байгаа хүүхдүүдийг хүртэл орон нутгийн хүүхдүүдтэй холбож өгөх бас тийм зөвлөгөө мэдээлэл өгүүлэх гэх мэтийн ингээд маш олон ажлуудыг энд холбож бас хийж ирсэн.

Ийм болохоор бас энэ боловсролын салбарын асуудал бас миний хувьд бас их илүү тийм их ойр дөт гэх үү дээ бас энэ санаа зовним ийм асуудал байгаа учраас бас энэ санаа зовнисон нь энэ зовним тоонууд дээр бас илүү бас эмзэг хандаж байгаа шүү гэдгээ бас хэлье ээ.

Тэгээд саяын тайлангаас гарч байгаа тэр зүйлүүдийг харахаар Энх-Амгалан сайдаас би тодорхой яг ажил хэргийн л зүйл асуух гээд байна л даа. Ер нь 9 дүгээр ангийн хүүхэд 15 настай хүүхэд Монгол хүүхэд 3 хүүхэд тутмын 2 нь Монгол хэлээрээ уншаад ойлгохгүй байна гэдгийг бид нар яг юу гэж ойлгох ёстой вэ? Энэ чинь Монгол хэлээрээ уншсаныгаа ингээд ойлгохгүй байна гэдэг чинь бусад бүх хичээлийн асуудал энэ дээр асар хүнд л болчхож байна шүү дээ ер нь. Тэгэхээр энэнд ер нь яг тодорхой та нар шинжлэх ухаан болоод энэ салбарын хариуцсан хүмүүс яг ямар дүгнэлт хийж байгаа юм? Энийг яаж өөрчлөх юм? Энийг чинь л өөр энэ чинь бүүр бараг бид нарын хувьд нэг ийм гоёор хэлэхээр бид нар энэ нэг ийм академик боловсролдоо анхаараад ур чадвар дээрээ сурах арга барил дээрээ анхаарахгүй байгаа юм шиг ингээд тайлбар бас хийчихвэл яг болох юм уу? Болохгүй юм уу?

Магадгүй энэ бид нарын түүхэн уламжлал олон зүйлээсээ нэг ийм төвөд ном цээжилдэг. Энэ чинь яг бид нарын хувьд нэг л тийм их тулсан том асуудал болчихоод байгаа юм биш үү? Тэгээд яаж энийг тэр олон улсын тэр саяын дүгнэлт дээр бол ур чадвар болохгүй байна л гэсэн байна лээ л дээ. Юу чадвар байтугай ур

чадварын өмнөх тэр уншаад ойлгохгүй байна л гэж байх шатад байна шүү дээ. Тэгэхээр энэн дээр ер нь бид нар ямар дүгнэлт хийж ямар тодорхой үр дүнгүүд гаргана гэж та наад салбарынхан бодож байгаа юм. Аль болох товчхондуу хариулт бас таныг өгөхийг хүсье.

Л.Энх-Амгалан: Цогтгэрэл гишүүнд талархаж байгаа. Бас Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдож ажиллаад Увс аймагт өөрийнхөө сонгогдсон тойрогт боловсролын салбарт хийж байгаа хөрөнгө оруулалтууд гэрэл асаая тийм гэрэл асаая гэдэг бас энэ хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж физик, математик, байгалийн ухааны бас шилдэг их дээд сургууль дээр байгаа багш нарыг аваачиж энэ багш нарын ур чадварыг дээшлүүлэх чиглэл рүү бас нэлээн санаачилгатай ажиллаж байгаа. Бас энэ санал санаачилгуудыг ч гэсэн бусад аймгуудад бас нэвтрүүлэе гэж бас Боловсролын яам анхааралтай бас ажиглаж энэ санаачилгыг бас дэмжиж байгаа гэдгийг бас би хэлье гэж бодож байна.

Дижитал технологийн хувьд бол бид нар ямар ч байсан энэ Монгол Улсын Засгийн газар бүх 760 сургуулиа бид нар интернэтийн өндөр хурдны шилэн кабельд холбож сургуулийн wi fi сүлжээг энэ жил 9 сарын 1 гэхэд бүгдийг нь шинэчлэх чиглэлээр ажиллаж байна. Бид нар ямар ч байсан Монгол Улсынхаа бүх багш нарыг 56 мянган багш нарын компьютерын асуудлуудыг өнөөдөр 60 хувийг нь шийдвэрлэлээ. Үлдсэн 5 сарын 1-ний хугацаанд бид нар бүх багш нараа компьютержуулах томоохон ажлуудыг хийж хэрэгжүүлэх ажлууд явж байна гэдгийг бас би онцлоод хэлчихье гэж бодож байна. Ер нь яагаад Монгол хүүхдийн 3 хүүхдийн 2 нь ингээд уншиж чадахгүй уншсанаа ойлгохгүй болчихвоо гэж. Ерөөсөө энэ цөм хөтөлбөрийн л үр дүн ингэж гарч байгаа юм бол гээд л хэлчихэд нэг хатуудчихгүй болов уу гэж бодож байна.

Яг энэ Монгол хэлний чинь үзэж байгаа цаг унших бичиг энэ тэрийг чинь цагуудыг нь хасчихсан юм байна лээ шүү дээ цөм хөтөлбөрөөр. Тэгэхээр чинь хүүхэд яаж эх хэлээрээ зөв уншиж, эх хэлээр эх хэл дээрээ байгаа уран зохиолын номуудыг унших энэ боломжууд л энд хасчихсан гэсэн үг шүү дээ. Энэ бол тодорхой нэг нөлөөлөл болов уу гэж бодож байна, нэгдүгээр асуудал.

Хоёрдугаар асуудал бол энэ агуулга хүнддээд байна гэж байгаа юм. Ер нь энэ хичээлийн агуулга энэ манай энэ цөм хөтөлбөрийн үндэсний агуулга их хүнддэсэн байна. Би нэгхэн жишээ дурдахад сургуулийн насыг 6 нас болгочихсон мөртөө яг 6 настай хүүхэд дээр яг хуучин зааж байсан 8 настай хүүхдийн хөтөлбөрийг оруулаад ирж байгаа байхгүй юу тэгээд? Ингээд хүүхдийн сургалтын хөтөлбөрийн агуулга хүнддэсэн. Манай ерөнхий боловсролын энэ хөтөлбөрөөр явж байгаа хичээлийн тоо бусад улсуудаас харьцуулахад 3-аас 6 хичээлээр их байна гэдэг ийм дүгнэлтүүд бас гарчихсан явж байгаа.

Нөгөө талаасаа бол яг ингээд нөгөө манай энэ хөтөлбөр дээр явж байгаа гол сул тал бол өнөөдөр явж байгаа энэ хөтөлбөрт бол хүүхдийг шалгалтад бэлддэг, тоо цээжлүүлдэг, нүдлүүлдэг, нөгөө доод эрэмбийн ур чадваруудыг эзэмшүүлдэг ийм л хөтөлбөртэй болчихсон юм байна аа. Тийм учраас бид нар энэ дээд эрэмбийн ур чадвар буюу сэтгэн бодох чадвар асуудлуудыг задлан шинжилдэг чадварууд гээд энэ чадваруудыг бид нар хийж өгөх ийм зайлиггүй ийм шаардлага байна гэж бодож байна. Та асуугаад байна. Яагаад ингээд 3 хүүхдийн 2 нь ийм унших чадвар уначхав гэж. Тийм учраас 1 дүгээрт агуулга хүнддэсэн.

Хоёрдугаарт бага ангийн хүүхдүүдийн агуулгад тэр хүнддэсэн учраас хичээлийн тоо нэмэгдсэн учраас

хүүхдүүд сурах сонирхолгүй анги дэвших тусам сурах сонирхолгүй болж, хичээлийн хоцрогдол үүссэн. Ийм л нөхцөл байдлаас болж энэ асуудлууд үүссэн юм болов уу гэж бодож байгаа юм.

Гуравдугаарт бол манайд ерөөсөө энэ боловсролын технологи их хоцрогдсон байна Цогтгэрэл гишүүн ээ. Боловсролын технологи. Тийм учраас бусад улсуудын энэ боловсролд оруулж ирж байгаа энэ технологиудыг бид нар цаг алдалгүйгээр нэвтрүүлэхгүй бол бид нар ингээд дахиад л хоцроод байна. Тийм ч учраас өнөөдөр хувийн өмчийн өндөр үнэтэй авдаг байсан *eduten* гэж математикийн сэтгэлгээг хөгжүүлдэг Финландын тогтолцоог бид нар нэвтрүүлж 3, 4 дүгээр анги дээр туршиж үзэж байна. Мааш сайн үр дүн гарч байна. Туршиж үзэж байгаа биш үндэсний хэмжээнд бид нар нэвтрүүлж байгаа математикийн нэг цаг дээр нь нэмж. Хуучин бүтэн нэг ангиараа 3, 4 дүгээр ангийн хүүхдүүд нийлээд 40 минут, 45 минутад тавхан бодлого боддог байсан бол өнөөдөр хүүхэд бүр өөрийнхөө мэдлэг чадвараар та өөрөө сумд дээр өөрийнхөө тойргийн сумд дээр очиж энэ *eduten* гэдэг хөтөлбөрийн юутай хэрэгжилттэй танилцсан гэж би ойлгосон. Тодорхой бас сайн үг сайшаалын үг хэлж хэлсэн гэж ойлгосон.

Өнөөдөр дөнгөж 30* 40-үүлээ нийлээд тавхан бодлого боддог байсан бол одоо хүүхэд бүр 50-аас 100 бодлого боддог. Тоглонгоо математикт сурдаг, тоглонгоо тоолоод сурдаг. Нөгөө нулимсгүй математик, нулимсгүй цагаан толгой гэдэг энэ ойлголтууд чинь өнөөдөр улс оронд бий болчихсон байж байна. Тэгэхээр ийм бод юуны технологиудыг бид нар боловсролд оруулж ирж чадах юм бол өнөөдрийн PISA-ийн үнэлгээгээр гарсан энэ математикийн гүйцэтгэл байгалийн ухааны гүйцэтгэл хамгийн гол нь одоо PISA-ийн шок гэж бид нар хэлж болно. PISA шок бол энэ эх хэл буюу унших чадвар дээр унасан энэ асуудал яг засах

залруулах ийм тодорхой шийдлүүд нь байгаа гэж харж байгаа.

О.Цогтгэрэл: Дараагийн асуулт асууцихъя. Энэ 10 минутын тал нь явчихлаа. Хоёулаа жаахан хурдан, надад бас олон асуулт байгаад байна. Яг одоо Монгол Улсын нэг багшид ноогдох сурагчийн тоо тэр олон улсын стандарт болоод Монголын стандартаараа хэд байдаг юм өнөөдөр яг хэд байгаа юм? Дахиад дээрээс нь энэ дээр тодорхой тоо бол та бас тоогоор хэлж өгөөч? Энэ багшийн ур чадварыг үнэлдэг багш нарын шаардлагаа хангаж байгаа ур чадвараа эзэмшсэн багшийн хувь хэмжээ нөгөө талаасаа ур чадвараараа шаардлагад нийцэхгүй байгаа багшийн хувь хэмжээ яг өнөөдөр ер нь судалгаа болоод дүгнэлтээрээ үнэлгээгээрээ хэд байдаг вэ?

Л.Энх-Амгалан: Нэг багшид ноогдож байгаа хүүхдийн тоо, нэг бүлэгт ноогдож байгаа хүүхдийн тоо бол нөгөө сургуулийнхаа хэв шинжээс шалтгаалаад хот хөдөөд ялгаатай байгаад байгаа юм Цогтгэрэл гишүүн ээ. Ерөнхийдөө бол бид нар 30-аас 35 хүүхэд гэж байгаа. Хөдөөд бол энэ харьцаа бол байгаа. Хамгийн гол асуудал бол улсын хэмжээнд байгаа тэр 3 ээлжид эрсдэлд орох гэж байгаа 67 сургууль дээр энэ асуудал үүссэн. Нэг анги дээр 45-аас дээш хүүхэдтэй байгаа. Улсын хэмжээнд энэ чинь 20-иод мянган бүлэг байна уу тэ? Хориод мянган бүлгээс ямар ч байсан 45-аас дээш хүүхэдтэй байгаа нь 2 мянга орчим бүлгийн гэдэг ийм тооцоо гарч байгаа.

Бид нар ямар ч байсан энэ бүлгийн энэ тоог бууруулах чиглэл рүү 3 ээлжийн сургуулиудын тогтолцоог халж, 2 ээлж рүү шилжүүлсэн энэ ажлуудыг бас хийж байна аа.

Хоёр дахь асуудал бол энэ багшийн ур чадварууд дээр бид нар багшийн гүйцэтгэлийн үнэлгээг нэвтрүүлээд 2 жил болж байна. Янз янз байгаа. Хичээл бүр дээр судлагдахуун бүр дээр багшийн

гүйцэтгэлийн үнэлгээнүүд өөр өөр гарч байгаа. Ерөнхийдөө хэлчихэд бол бараг үндсэндээ багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр бид нар 6 шатад багшийн гүйцэтгэлийн ур чадваруудыг үнэлж байгаа. Ингээд 1-ээс 4 дүгээр шатад байгаа багш дээр бид нар гүйцэтгэлийн үнэлгээний ур чадварын үнэлгээ хийгдээд тэгээд 1-ээс 4 дүгээр шатан дээр байгаа багш нар дээр цалингийн, үндсэн цалингийн 15-аас 40 хувийн урамшуулал олгодог буюу нийт багш нарын 51 хувь нь өнөөдөр 1-ээс 4 дүгээр түвшинд байна.

Тийм учраас 49 хувь нь тодорхой 5, 6 дугаар түвшин дээр байгаа. Ур чадвараа сайжруулах ийм шаардлагатай багш нар байна.

О.Цогтгэрэл: Саяын PISA-ийн үнэлгээнээс энэ хуудсыг нь харж байна л даа. Энэн дээр багш нарын мэргэжлийн чадваргүй, шаардлага хангахгүй багшлах боловсон хүчний хувь хэмжээ гэсэн олон улсын дундаж 20 OECD-ийн дундаж 25, манайх 38 гэсэн байна л даа. Тэгэхээр энэн дээр бол бас ингээд багштай холбоотой том асуудал байгаа юм. Гол асуудал би түрүүнийхийг асуудаг нь бид нар чинь нэг ийм барилга байшин, хүртээмж, ээлжийн тоо яриад байдаг. Гэтэл нэг багш дээр ноогдож байгаа сурагчдын тоо сая таны хэлж байгаагаар ч гэсэн ийм асуудалтай. Дахиад дээрээс нь хөдөө орон нутаг, аймаг, сумдад жишээ нь тэр сургалтын хэрэглэгдэхүүн, хичээлийн бусад техник хэрэгсэл олон зүйл мэдээж хомсдолтой олон олон зүйлүүд бас тайлан дээр харагдана лээ.

Тэгээд ирэхээр энэ дундаас яг тэр байгалийн ухааны хичээл дээр жишээ нь 2 хүүхэд тутмын нэг нь бараг анх дөнгөн данган нь анхан шатны мэдлэгтэй байна 9 дүгээр ангийн хүүхэд.

Тэгэхээр энэнтэй холбоотой ингээд бид нар нэг ийм хүртээмж баахан ярьчихдаг. Хүртээмж нэг ийм сургалтын анги танхим яриад байсан, яг сургалтын

чанар, дахиад яг бид нар нэг зөөлөн ур чадвар гээд л олон зүйл ярьдаг. Энэ нэг ийм чанарын үзүүлэлтүүд маань л байхгүй болчихоод байгаа нэг ийм л зүйл бид нарт харагдаж байна л даа. Энэн дээр бид нар ямар бодлого гаргах ёстой юм бэ?

Л.-Энх-Амгалан: Ер нь Цогтгэрэл гишүүн энэ дээр бид нар санхүүжилтийнхээ тогтолцоог л шинэчлэх ёстой. Үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо л гэж бид нар нэрлээд байгаа юм. Хуучин бид нар нэг хүүхдийг сургадаг хувьсах зардлыг байгууллага санхүүжүүлдэг энэ тогтолцоог бид нар халж байна.

Тийм учраас нэг хүүхдийг сургадаг хувьсах зардал бол боловсролын чанартай нь хүүхдийн сурлагын ахиц дэвшилтэй нь холбогддог үр дүнд энэнтэй нь холбодог ийм санхүүжилтийн тогтолцоог л бид нар нэвтрүүлэхээр сүүлийн 2 жил оролдож байгаа юм. Тэгэхээр бид нар хичээл бүхний өртгийг тооцож байгаа юм. Цогтгэрэл гишүүн 1 дүгээр ангид орж байгаа хичээлүүд 1-ээс 12 дугаар ангид орж ирж байгаа бүх хичээлүүдийн өртгийг нь тооцож энэ хувьсах зардлуудыг бид нар олгож байгаа учраас нөгөө байгалийн ухааны лабораторитой сургууль, байгалийн ухааны лабораторигүй сургууль 2-оос чинь бид нар адилхан үр дүн нэхэж болохгүй шүү дээ.

Тийм учраас бид нар тэр хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, энэ лабораторийн ялгаанууд сургуулиудын лабораторийн ялгаануудыг бид нар энэ нэг хүүхдийг сургаж байгаа хувьсах зардал дээр нь зөв өртгүүдийг нь тооцож энэ индексжүүлж энэ санхүүжилтийг олгож эхэлсэн. Энэ дээр бас тодорхой үр дүнгүүд гарч байгаа шүү дээ. Сургууль дээр бид нар нөхөн хангалтын зардал гэдэг олгодог болсон. Багш нар өнөөдөр олон жил карманаасаа гаргадаг байсан хичээл практикийн зардал гэдгийг энэ хувьсах зардлаас бид нар олгож олгож

эхэллээ. Тийм учраас бид нар яг үнэхээр таны хэлээд байгаа энэ байгалийн ухааны хичээл бусад хичээлүүдийн чанар дээр яг энэ ялгаа яаж арилгах юм бэ гэдэг цорын ганц шийдэл бол зөвхөн 1 хүүхдийг сургаж байгаа хувьсах зардалтай нь уяж байж энэ тогтолцоог хийж байж л бид нар энэ чанарын ялгааг арилгана л гэж харж байгаа.

О.Цогтгэрэл: Хүртээмжийн асуудлаас гадна чанарын асуудал гэдэг үнэхээр л энэ тайлангийн гол зүйл болоод гарчихсан. Тэгээд тэрэн дээр бас бодлогын ажлууд тэгээд явах ёстой байх аа. Өөр нэг яригддаг нэг зүйл энэ заавал сонгож үзэх ёстой хичээлийн тоо олон улсад бараг янз бүр л байдаг байлгүй. Тэгэхдээ нэг 8-аас илүүгүй байхад манайх зарим ангид аа 16 байдаг ч гэнэ үү? Тэгээд энэний шалтгаан нь нэг баахан шинээр хөтөлбөр гаргадаг баахан сурах бичиг шинээр зохиогддог, баахан сурах бичиг хэвлэлийн компаниудын нөлөө хүртэл энэ дээр байдаг гээд л ийм салбарын зарим хүмүүс бас ярих юм. Тэгэхээр энэн дээр тэр нэг заавал судлах хичээл гэдэг дээр энэ сургалтын хөтөлбөр дээр бид нар нэг томоохон өөрчлөлт ер нь хийх ёстой биш үү? Энэ одоо нэг энэ жилийн жилд л хэлэгдээд л яригдаад л явдаг. Тэгээд нэг баахан хүүхдүүдийг хичээл даалгавраар сурсан сурах эрмэлзлийг нь унтраасан яг түрүүний гардаг үр дүнгүүдэд ингээд нөлөөлсөн амьдралд яг ахлах ангиудад тэр тусмаа мэргэжил сонголт руу дөхөөд ирсэн үед хэрэгтэй хэрэггүй мэдэхгүй баахан хичээлүүд л байдаг гэж салбарынхан нь энэн дээр нэлээн ийм мэдээллүүд гардаг. Энэн дээр ер нь ямар бодлого барьж байгаа юм бэ? Энэ бол бодитой ийм зүйл байна уу?

Л.Энх-Амгалан: Бодитой ийм зүйл байна байна. Аль ангид ямар хичээлийг ямар цагаар орох вэ гэдэг бол эргээд энэ хөтөлбөртэйгөө холбогдож байгаа асуудал. Тэгэхээр өнөөдрийн энэ хөтөлбөрөөр бид нар хүүхдэд Монгол хүүхдэд яг энэ манай боловсролын

салбарынхан суралцахуйн зорилтууд гэж нэрлэдэг юм байна лээ. Нэгдүгээр ангийн хүүхдэд хэдэн суралцахуйн зорилтоор дамжиж ямар мэдлэг чадварууд бий болж байх вэ? Ямар хичээлээр ямар ур чадварууд бий болж байх вэ гэдэг асуудал байгаа.

Тэгэхээр бид нар өнгөрсөн 2 жилийн хугацаанд хийсэн энэ сурах бичиг дээр хийсэн шинжилгээнүүд, хөтөлбөр дээр хийсэн шинжилгээнүүд дээр бол үнэхээр энэ хичээлийн агуулгууд нь хүнд. Бага анги дээр хүндэдсэн хичээлийн тоонууд нь их байна гэдэг юм нь тодорхой гарчихсан.

Тийм учраас бид нар Монгол Улс орон даяар хэлэлцүүлж байгаа энэ хөтөлбөрийн шинэчлэлээр бид нар энэ алдаануудыг засаж залруулна аа. Одоо энэ бага анги дээр ирж ажиллаж яаж байгаа ачааллуудыг багасгах, үзэж байгаа хичээлийн тоонуудыг багасгах. Мөн хамгийн гол нь хичээлийн интеграцуудын, агуулга хоорондын интеграцуудыг хийх. Бусад энэ хичээл би түрүүн технологийн тухай ярьсан шинэ технологийг нэвтрүүлэх энэ чиглэл рүү бид нар энэ ажлуудыг хийж байж л тодорхой үр дүн гарна гэж бодож байна. Тэрнээс биш хэн нэгэн хэвлэлийн компанийг дэмжээд хичээлийнхээ тоог нэмээд сурах бичиг хэвлээд байгаа ийм гэнэн ойлголт байж болохгүй гэж харж байна.

О.Цогтгэрэл: Мэдээж энэ бүх зүйлүүдийн нэг салшгүй нэг том хэсэг нь багшийн асуудал. Тэгэхээр бид нар чинь нэг бас дахиад л хялбархнаар бодоод л багшийн цалинтай холбоотой бүх зүйлийг ярьдаг тодорхой хэмжээгээр бас бодвол нэмэгдэж байгаа байх. Тэгэхээр энэ багш гээд бас ингээд асар удаан хугацаанд бэлтгэгддэг, чанартай багш, сайн багш гэдэг хүний бүхэл бүтэн амьдралыг амьдралын замыг өөрчилдөг ийм чухал хүчин зүйл улсуудын багшийг хөгжүүлэх, багшийг дэмжих гэдэг энэ үнэт

капиталыг энэн дээр хийгдэж байгаа ажлаа бас энэ дээр бодлогын өөрчлөлт шинэчлэлт юу байна? Энийгээ нэг хэлээч?

Тэгээд төгсгөлд нь нэг асуулт байгаад байгаа нь бас өмнөх гишүүд ярьсан тэр нэг орон нутгийн Боловсролын газрын удирдлагатай холбоотой асуудал. Надад бас Увс аймгаас тийм нэг мэдээлэл ирсэн. Увс аймгийн Боловсролын газрын даргыг өөрчилж байгаа юм байна. Жишээ нь тухайн миний мэдэж байгаагаар энэ Увс аймгийн боловсролын газар яг ийм боловсролын газартай, боловсролын байгууллагадаа бараг 20, 30-аад жил ажиллаж байгаа дотроо тэр мерит тогтолцоогоороо яваад саяхан баталгаажсаад шинэ хуулийн дагуу батлагдчихсан томилогдсон гэж ойлгосон. Зөвхөн миний мэдэж байгаагаар сүүлийн 2, 3 жилд Увс аймаг ЭЕШ-ын дүнгээр ЭЕШ-ын дүнгээр улсын хэмжээнд 1, 2 дугаар байранд орж тэр багшийн гүйцэтгэлийн үнэлгээ гэдэг олон зүйлээрээ л амжилттай яваа мэдээллүүдийг би тухайн үед бас энэ боловсролд гэрэл нэмэн гэдэг төсөл дээр очихдоо сонирхож бас сонсож, тэр тусмаа ер нь энэ бололцооны ажилдаа идэвх зүтгэлтэй, дур сонирхолтой ажилладаг, бас ийм мерит тогтолцоогоор ороод гараад ирчихсэн хүмүүс бас арай өөр байдаг юм байна гэдэг ойлголттой бас нэлээн зүйлүүд дээр бас хамтарч ажиллах нөхцөлүүд гарч байсан.

Гэтэл энэ хүнийг шууд ингээд дээрээс солино. Ажлаа өгөө гэдэг ийм шаардлага очсон гээд л дуулдана лээ. Жишээ нь энэ чинь өөрөө харин жинхэнээсээ нэг тийм улс төржсөн нөхцөл байдал энэний цаана яваад байгаа юм биш үү. 20, 30 жил ажиллачихсан ажлын үнэлгээгээрээ улсын хэмжээнд 1, 2 дугаар байранд ажил нь ороод дүгнэгдээд явж байх шиг байна. Гэтэл ингээд шууд халах өргөдлөө халах тушаалаа авчхаад сууж байгаа гээд л мэдээлэл ирж байна.

Л.Энх-Амгалан: Багшийн асуудал хамгийн чухал асуудлууд аа. Монгол Улс ер нь өөрийнхөө өнгөрсөн 70 жилийн турш хийсэн хамгийн үнэ цэнтэй зүйл бол хамгийн шилдгүүд нь багш болдог байсан. Энэ тогтолцоогоо л нураачихсан юм байна лээ л дээ. Нураачихсан юм байна лээ. Одоогийн хамгийн гол асуудал бол энэ ЭЕШ-ын оноогоор доогуур бага оноотой хүүхдүүд багш болсныг амсаж байна шүү дээ нийгмээрээ амсаж байна. Тэгэхээр бид нар Монгол Улсад энэ багшийн хөгжлийг дэмжих 3 тулгуурт бодлого гэж бид нар энэ Засгийн газар гаргаж ирж байгаа. Ямар хүүхдийг багш болгох юм. Ямар хөтөлбөрөөр сургах юм. Тэр багш бэлдэж байгаа сургуулиудын хөтөлбөрүүд нь заавал магадлан итгэмжлэгдсэн. Ийм хөтөлбөрөөр багш бэлдэх ёстой. Багш ажлын байранд, багш төгсөж очоод ажлын байран дээр тасралтгүй хөгждөг энэ тогтолцоог бид нар хийх ёстой юм байна лээ. Энэ бол бид нарын хүсээд байгаа нөгөө кембриджийн тогтолцоо байхгүй юу. Кембриджийн стандарт байгаад байгаа. Ийм стандарт байгаад байгаа юм.

Тэгэхээр энэ тогтолцоог бид нар үндэсний тогтолцоо болгож байж бид тэгэхгүй бол бид нар багш бэлддэг Монгол Улсын Багшийн их сургуулиасаа Багшийн Их Сургууль нь багшаа бэлдээд байдаг. Багшийн их сургуулийн төгсөж очсон багш нар ажлын байран дээр очихоороо багшийн мэргэжлийн институт гэдэг шал өөр институтээр 5 жил, 10 жил огт шаардлага хангахгүй яг мэргэжил дээшлүүлэх сургалтууд хийдэг. Ийм тогтолцооны гажгууд бий болсон байна аа.

Л.Мөнхбаатар: Гүйцээгээд хариулчих юм уу? Асуулт хариулт дууссан. Хугацаа нь дууссан байна. Та ямар хариулт авъя гэнэ ээ?

О.Цогтгэрэл: Увс аймгийн боловсролын газрын даргыг.

Л.Мөнхбаатар: Энх-Амгалан сайдад нь гүйцээгээд хариулчихъя даа. Нэг л юм байна? Бас асуулт юм байна. Тэр сонгон шалгаруулалтынхаа талаар тайлбарлачих.

Л.Энх-Амгалан: Бид нар боловсролын багц хуулийг Улсын Их Хурлаар баталсан 1 сарын 1-ээс Боловсролын багц хууль хэрэгжиж эхэлж байгаа орон даяар.

Тийм учраас энэ аймгийн Боловсролын газрын удирдлагуудад тавих улсууд дээр хуулиар шалгуур тавьсан. Цэцэрлэг, сургуулийн удирдлагад ажиллах улсууд дээр хуулиар шалгуур тавьсан. Ийм учраас энэ хуулийг хэрэгжүүлэхэд бол өмнө нь шалгуур хангаагүй байсан шалгуур хангаагүйгээр ажиллаж байгаа улсууд дээр сонгон шалгаруулалт зарласан байгаа. Би дахиад хэлье. Улсын Их Хурлын гишүүд аймгийнхаа Боловсролын газрын даргын томилгоо, цэцэрлэг сургуулийн томилгоо руу хошуу дүрээд байх юм бол бид нар одоо энэ боловсролыг улс төрчдийн савраас гаргаж чадахгүй юм байна л гэж би бодож байгаа.

Л.Мөнхбаатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонслоо.

Ингээд дараагийнхаа асуудалд оръё. Ажлын хэсэгт баярлалаа.

15.55 цагт

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг төслийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа танилцуулна. Таныг индэрт урьж байна.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын дэд дарга,

Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлаас 1998 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг батлан хэрэгжүүлж эхэлснээс хойш өдгөө 26 жил болж байна. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах явцад холбогдох байгууллага иргэдээс гаргах гэсэн санал хүсэлтэд үндэслэн уг хуулийн өргөдөл гомдол хүлээн авах хугацаанд 4 удаа өөрчлөлт оруулсан бөгөөд одоо ч өөрчлөлт оруулах хууль зүйн болон нийгмийн шаардлага үүсээд байна аа.

Цагаатгуулах тухай өргөдөл гомдол хүлээн авах хугацаа 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хурлын чуулганаар батлагдсан нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр өдрөөр дуусгавар болсон. Өргөдөл гаргах хугацаа дууссан боловч Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын гишүүд Өргөдлийн байнгын хороо, Засгийн газар болон Засгийн газрын холбогдох байгууллагад Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн салбар комисст хэлмэгдэгчдийн үр хүүхдүүд холбогдох төрийн бус байгууллагуудаас хуулийн хугацаанаас хоцорсон, хэрэг материал олдоогүй, Ковид-19 цар тахалтай холбоотой хэрэгжиж эхэлсэн хууль дүрэм, журмууд нөлөөлсөн зэрэг нөхцөл байдал шалтгааны улмаас төрийн гэр бүлийн төрөл төрөгсдийг цагаатгуулж нэр төрийг сэргээлгэж чадаагүй гэх олон тооны өргөдөл, гомдол, хүсэлтийг ирүүлсэн байх нь хуулийн хугацааг сунгах зайлшгүй шаардлагыг бий болгож байна аа.

Өнөөдрийн байдлаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй 451 хэрэг, өмнө шинэ нөхцөл байдлаар шалгаад улс төрийн хэрэгт холбогдсон болох нь нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр мөрдөн байцаалтыг зогсоосон 166 хэрэг, орон нутгийн архиваас татан төвлөрүүлсэн 20 хэрэг зэрэг нийт 637 хэргийн мянга орчим хүнд холбогдох үлдэгдэл хэргийг шалгаж дуусгах, цагаатгах, цагаатгуулах, гомдол гаргах зэрэг асуудал хуулийн өөрчлөлтийн байдлаас хамааран зогсонги байдалд ороод байна аа.

Мөн ЗХУ-д шийтгүүлсэн хэлмэгдэлтэд өртөж амь насаа алдсан иргэдийн хэргийн материалыг судалж, тэднийг цагаатгах, цагаатгасан иргэдийн материалыг татаж авах, нэр төрийг сэргээх, дурсгалыг мөнхжүүлэх ажил мөн зогсонги байдалд орлоо. Цагаатгуулах тухай гомдол гаргах хуулийн хугацаа дуусгавар болсон тул иргэдээс ирсэн цагаатгуулах тухай өргөдлийг Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурор анхан шатын шүүхүүд хүлээж авахгүй байгаа боловч архивд хадгалагдаж байгаа улс төрийн хилс хэрэгт хамааралтай хэргүүдийг шалган шийдвэрлэх ажиллагаа явагдсаар байгаа юм аа. Нийт хэлмэгдсэн иргэдийн ихэнхийг цагаатгаад байгаа боловч тодорхой нөхцөл байдал учир шалтгааны улмаас цагаатгуулж амжаагүй иргэдийн эрхийг хуулийн хугацаагаар хязгаарлах нь зохимжгүй бөгөөд эдгээр иргэдэд боломж бололцоо олгож өгөхийг хүссэн гомдлууд ирсээр байгаа юм. Хуулийн төслийг ХЗБХ-оор хэлэлцэх үед дийлэнх гишүүдээс хуулийн өөрчлөлтийг хугацаагүй болгох саналыг илэрхийлснийг хууль санаачлагчийн зүгээс дэмжиж байгаагаа илэрхийлмээр байна аа.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт

оруулах тухай хуулийн төсөл нь цагаатгуулах гомдлыг хүлээн авах хуулийн хугацааг сунгаж тодорхой нөхцөл байдал учир шалтгааны улмаас цагаатгуулж амжаагүй иргэдийн эрхийг хангах, эдгээр эрхтийн иргэдийн эрх зүйн асуудлыг шийдвэрлэх зорилготой юм. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн гэх иргэдийг нэг мөр цагаатгаж нэр төрийг сэргээснээр улс төрийн хэлмэгдүүлэлтийн хор уршгийг өөрийн биеэр мэдэрч, бие махбод, сэтгэл санааны хэлмэгдүүлэлтэд өртсөн хэлмэгдэгч болон дам хэлмэгдэлтэд өртөж сэтгэл санааны хохиролд хамгийн ихээр өртсөн түүний гэр бүлийн гишүүдийн гомдол шийдвэрлэгдэнэ ээ.

Хуулийн өөрчлөлтөөр нөхөн олговортой холбогдох хуулийн зохицуулалт хөндөгдөхгүй тул улсын төвлөрсөн төсөвт ямар нэг байдлаар дарамт нөлөөлөл үүсэхгүй юм аа.

Эрхэм гишүүд ээ,

Энэ хуулийн төслийг хэлэлцэн улс төрийн хэрэгт хилсээр хэлмэгдсэн иргэдийнхээ нэр төрийг сэргээх цагаатгуулах боломжийг нь олгох эрх зүйн орчинд нь дэмжиж, бүрдүүлж, дэмжиж өгөхийг хүсье.

Л.Мөнхбаатар: Одонтуяа даргад баярлалаа.

Төслийн талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Одонтуяа нарын гишүүд 2023 оны 12 дугаар сарын 8-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг

үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2024 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон Хүний эрхийн түгээмэл тунхаглалын зүйл заалтуудтай нийцүүлэн иргэдийн эрх тэгш байдлыг хангах үүднээс улс төрийн хэлмэгдэгчдийг цагаатгуулах, өргөдөл, гомдол хүлээж авах хуулийн хугацааг сунгах шаардлагатай гэж үзжээ. Хуулийн үйлчлэх хугацааг сунгаж хууль батлагдсанаар улс төрийн хилс хэрэгт хэлмэгдсэн боловч хэрэг материал нь бүрэн шалгагдаагүй нийт 637 хэргийг бүрэн шалгаж цагаатгагдах, улс төрийн шалтгаанаар баривчлагдаж ЗХУ-д шийтгүүлсэн иргэдийн хэргийн материал болон одоогийн байдлаар иргэдээс ирүүлсэн 200 орчим өргөдөл, гомдлыг судалж, тэднийг цагаатгах цагаадсан иргэдийн материалыг татаж авах эрх зүйн орчин бүрдэх, хууль санаачлагч уг хуулийн төслийг баталснаар улсын төсөвт зардал үүсэхгүй гэж үзсэн.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг уг төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж байгаагаа илэрхийлээд нөхөн олговор олгосон болон цаашид нөхөн олговор авах иргэдийн тоо болон тооцооллын талаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир уг хуулийн хугацааг олон улсын жишгийн дагуу хугацаагүй үйлчлэхээр төсөлд тусгах, өргөдөл гомдол хүлээж авах хуулийн хугацааг заах шаардлагатай эсэх талаар асуулт асууж хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар улс төрийн хилс хэрэг гэдэгт хууль бус аргаар төрийн эрхийг авах оролдлого багтаж байдаг учраас энэ төрлийн гэмт хэргийг Эрүүгийн хуульд тусгах, авлигын гэмт хэргийн ялын бодлоготой дүйцэх хариуцлага

хүлээлгэдэг байх нь зүйтэй бөгөөд шийдвэрлэлтэд нь цаг хугацааны хязгаарлалт байх нь зохисгүй талаар санал хэлэв ээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах тэдэнд нөхөн олговор олгох хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх ХЗБХ-ны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье ээ.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Л.Мөнхбаатар: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан чуулганы нэгдсэн хуралдаанд оролцож байгаа албан тушаалтныг танилцуулъя.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах Улсын комиссын нарийн бичгийн дарга Ганбаатарын Төгөлдөр оролцож байна.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Нэрсээ өгье. Аубакир, Алтанхуяг гишүүнээр тасаллаа.

Ганибал гишүүнээр тасаллаа. Аубакир гишүүн асуултаа асууя.

Т.Аубакир: Баярлалаа. Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөн олговор олгох тухай хуульд

өөрчлөлт оруулаад үндсэндээ хугацааг нь сунгаж байгаа гэж ойлгож байна. Энэ бас ингэхээс өөр аргагүй байдал бий болчихоод байгаа юм аа. Улсын Их Хурлын гишүүдэд бас өргөдөл хүсэлтүүд ирдэг. Энэ ковидтой холбоотой материал нь олддоггүй мөн одоо энэ яг хэлмэгдэлтийн үед энэний дараахан үед нь тэр хэлмэгдээд тухайн үедээ эсэргүү гэгдээд явсан хүнээр овоглоод явахаасаа эмээгээд овог энэ тэрээ сольчихсон. Ингээд тайван цаг болоод ирэхээр би ингээд хүүхэд нь байсан юм одоо. Тухайн үед ингээд нийгэмд багтаж шингэхгүй болоод бид нар ингээд овог нэрээ хүртэл өөрчлөх шаардлага тулгарсан юм гээд энэ яг овгоо өөр ямар ч байсан тэр хүний хүүхэд нь мөн байсан гэдгийг нотлох процесс нь өөрөө шүүх дээр аягүй удааширалтай. Энийгээ нотолж амжаагүй ийм өргөдөл гомдлууд хүртэл ирдэг юм. Одоо г манай аймгийн хувьд гэхэд л нэг шүүх дээр маргаантай явж байгаа. Тэрийгээ нотлох гээд хөөрхий тухайн үеийн хөгшчүүл нь үндсэндээ бас нэг байхгүй болчихсон. Тэрийг нь нотлоод үгүй энэ үнэхээр тэр хүний хүүхэд байсан юм шүү гээд хэлэх нөгөө хөгшчүүл нь багасчихсан. Зарим нь байхгүй болчихсон.

Тэгээд ингээд энэ хэлмэгдээд өөрийнхөө өвөө эмээ байдаг ч юм уу аавыгаа алдаад тэрийгээ нотолж чадахгүй байх нь өөрөө бас л яг тухайн, гэр бүл, тэр үр хүүхдүүдэд нь бас л хэцүү л асуудал л даа. Тийм учраас иймэрхүү зэрэг нотолж чадахгүй байгаа шүүх дээр тэрийгээ нотлоход хугацаа шаардлагатай байдаг зарим нь мөрдөн байцаалтад зогсчихсон зэрэг ийм хүмүүсийн энэ цагаатгах эрхийг нь хангаж өгөөд эндээ тодорхой хэмжээний хугацаа оруулаад ингээд сунгах гэж байгаа явдалд би баяртай байна. Манай Одонтуяа гишүүний хувьд яг энэ хэлмэгдэгчидтэй холбоотой өргөдөл гомдлыг түргэн шуурхай шийдэж өгөхийг хичээж ажилладаг. Бас хариуцлагатай манай бас Улсын Их Хурлын гишүүн хариуцаад ажиллаж байгаа юм аа.

Тийм учраас энэ хуулийг бол дэмжиж байна. Нэг л асуулт байна. Нэгэнт шүүхээр үнэхээр хэлмэгдсэн юм гэдэг нь тогтоогдчихсон байдаг. Тэгээд нөгөө нөхөн олговор авъя гээд тэгэхээр өргөдөл гомдол их л байдаг байх. Энэ төсвийг нь нэгдсэн төсвөөс шууд батлаад өгчихсөн эд биш байдаг юм уу? Ингээд нэг очерт орно гээд нэг зүйл байгаад байдаг бололтой юм. Манай аймгаас өргөдөл гомдлоо өгөөд ингээд очерт орсон юм. Хойгуур байна урагшлуулж өгөөч гэсэн л ийм нэг гомдол байгаад байдаг юм. Энэ маань яагаад ингээд эсвэл яг тэгээд шүүхийн шийдвэр гаргахтай нь зэрэгцээд төсвийг нь дахиж нэмж батлуул явдаг юм уу? Үгүй бол нэгдсэн төсөвт ороод баталчихсан зүйл байдаггүй юм уу? Яагаад ингээд очер дугаарт байгаад байдаг юм бэ гэсэн нэг л асуулт байна. Энэ хуулийг бол цаашидаа сунгаад даже хугацаагүй болгох тал дээр миний хувьд дэмжиж байгаа.

Би ингээд нэг л асуулт байна энэ асуултдаа хариултаа авъя.

Л.Мөнхбаатар: Аубакир гишүүний асуултад хариулъя. Одонтуяа дарга хариулах уу? Одонтуяа дарга асуултад хариулъя.

С.Одонтуяа: Энэ цагаатгах ажлыг өдөр нь зохион байгуулах комиссоос энэ хуулийг мөрдлөг болгож ажиллаж байгаа 1998 онд батлагдсан. Хэд хэдэн удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан гэж хэлсэн. Тэгэхээр энд хуулийн хугацаа зааж өгсөн байгаа. Шүүхийн шийдвэр гарснаас хойш 2 жил дотор багтааж нөхөх олговрыг олгох ёстой гэж. Тэгэхээр өнөөдрийн байдлаар бид бол хууль зөрчсөн нэг ч асуудал байхгүй. Гэхдээ бид нөгөө хүмүүсийнх нь бас насыг нэлээн харгалздаг. Ингээд насаар нь эрэмбэлдэг. Их өндөр настай хүмүүст бид нар аль болохоор өндөр настай хүмүүсээсээ өгөөд, 2 дугаарт шүүхийн

шийдвэр гарсан байдлыг бас эрэмбэлж байгаад ингээд олгодог.

Өнгөрсөн 3 жилд бол иргэдээс гаргасан энэ хүсэлт Улсын Их Хурлын гишүүдээс гаргаж байгаа, орон нутгаас гаргаж байгаа хүсэлтийг бол бид нар маш шуурхай шийдвэрлээд холбогдох бүх нөхөх олговрыг олгосон байгаа. Нийт би ажлаас гарснаасаа хойш 44 тэрбум төгрөгийг нөхөх олговорт олгосон. Одоо 2024 оны нөхөх олговорт 5-аас 6 хүний л яг нөхөх олговор олгох үлдсэн байгаа. Тийм учраас бол энэ асуудал яг дүрмийн хууль, дүрмийн дагуу явж байна гэсэн үг. Та бас тэр хугацаан дээр зөв санал гаргалаа. Яагаад гэхлээр Байнгын хороон дээр гишүүд хугацаагүй болох нь зөв юм гэсэн юм. Одоо бол энэ төсөвт нэг айхтар дарамт ирэхгүй. Яагаад гэхээр энэ хуульд зөвхөн төрсөн хүүхэд буюу үрчилж албан ёсоор үрчлэгдсэн хүүхэд гэж байдаг. Эсвэл одоо эхнэр нь эсвэл өөрөө. Тэгэхээр одоо бараг төрсөн хүн хүүхдүүд болон үрчилж авсан хүүхдүүд нь бараг өндөр настай болоод нас бараад дууссан. Яагаад гэхээр энэ чинь бүүр 2022 оноос эхлээд л явж байгаа ийм хэрэг байгаа.

Гэхдээ бас энд цагаатгуулж шүүхийн шийдвэр гаргуулж чадаагүй бас нэлээд олон хэрэг байна. Энийг дуусгахгүй бол энэ улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийн асуудал бол олон 10 жил бараг 100 жилээр ингээд хойч үе нь гомдолтой үлдэх ийм аюултай байдаг.

Тийм учраас бид нар энэ Солонгосын ялангуяа БНСУ-ын хуулийг судлахад ерөөсөө өнгөрсөн үеийг үнэн ба эвлэрэл болгон цагаатгах тухай гэж тусгай суурь хууль баталсан байдаг. Өөрөөр хэлбэл үнэнийг яг ерөөсөө тогтоож өгье өө дуустал нь. Тэгээд уучлал гуйгаад нөхөх олговрыг нь олгоод цагаатгаад тэгээд энэ хойч үе хоорондоо эвлэрч амьдрах ёстой. Тэгэхгүй насаараа хүн ингээд төрдөө гомдоод насаараа хүн ингээд өс санаад явах ийм тохиолдлууд олон улсад байдаг. Тийм учраас энэ

хугацаагүй байх нь чухал юм гэж бас үзсэн байгаа. Тийм учраас нэгмөсөн.

Л.Мөнхбаатар: Тодорхой хариулт авчихлаа. Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг асуултаа асууя.

Н.Алтанхуяг: Би энэ нэг л асуулт байгаа. Тэгэхдээ нэг хэдэн юмыг нь бас нэг микрофонд үлдээчихнэ түүхэнд. Бид нар ямар хууль ярьж байгаа вэ гэхлээр энэ хэлмэгсдийн тухай асуудлыг ярьж байгаа юм. Монголын хамгийн тийм хар түүх. Тэгэхээр энэ ямар хугацааг ярьж байгаа вэ гэхлээр 1922-оос 1990 оны хооронд манай Монгол Улсад 36 мянга орчим хүн хэлмэгдсэн гэж. Энэ 36 мянга орчим хүнээс 20 мянга гаруй хүнийг буудан алсан. 8 мянга гаруй хүнийг хорих ялаар шийтгэсэн. Ийм хар түүхийн тухай бид нар бол ярьж байгаа юм аа. Би бас энэ манай залуучууд мэдэхгүй учраас зориуд хэлж байгаа.

Тэгээд энэ асуудлыг хэзээ яаж ингэж ярьж эхэлсэн юм гэхлээр 1996 онд Ардчилсан холбоо эвсэл байгуулагдаад ялаад тэгээд 8 сард энэ хэлмэгдэгсдийн дурсгалын өдрийг бий болгоё гэж ийм Их Хурлын тогтоол гаргаж байсан юм. Тэр тогтоол дээр нь би бас гишүүн дөнгөж шинэ гишүүн байсан. Энэ тогтоолоороо бид нар өдрийг бий хэлмэгдэгсдийн дурсгалын өдрийг бий болгохоос гадна Монголын ард түмнээс уучлал гуйх ёстой гээд тэр тогтоол дээр бол Монголын ард түмнээсээ уучлал гуйсан. Тэгээд 9 сарын 10-ны өдрийг буюу 1937 оны 9 сарын 10-ны хар өдрийг хэлмэгдэгсдийн дурсгалын өдрийг бий болгох ийм өдөр болгосон юм.

Дараагаар нь 1998 онд энэ улс төрийн хэлмэгдэгсдийг цагаатгах нөхөн олговор олгох хуулийг баталж гаргаж энэ үлдсэн, үр хүүхэд, хамаатан саданд нь ядаж нэг хэд гурван төгрөгийн нөхөн олговор өгье гэж ингэж хууль баталсан юм.

Ингээд энэ 26 жилийн хугацаанд би эргээд харлаа л даа. Юу болж байна вэ гэхлээр 20 гаруй мянган иргэдийг бол үндсэндээ 20 гаруй мянган иргэдэд бол нөхөн олговор өгсөн байна аа. Энд бол 117 тэрбум төгрөг өнөөдрийн байдлаар зарцуулж байна. 26 жилийн хугацаанд. Эндээс би юу гэж хэлэх гэж байгаа вэ гэхлээр ер нь цаашидаа Монголын төр гэдэг юм уу энэ хууль хяналтынхан хүнийг ингэж хэлмэгдүүлж, буудан алж, хороож, хорьж, амьдаар нь тарчилгаж ингэсэн ийм юмын дахиж давтахгүйн тулд энэ сая хэн Аубакир гишүүн та нар яриад байна. Хугацаагүй болгох ёстой. Энэ хүнийг хилсдүүлсэн юмыг үнэн мөнөө олох гэдэг бол цаг хугацаагаар хязгаарлах асуудал биш юм аа. Тиймээс энийг бол хугацаагүй болгох нь зүйтэй гэж бодож байна.

Миний асуух гэж байгаа асуулт бол энэ 2 дахь давлагаа эхэлчихсэн. 1990 оноос хойш өнөөдрийг хүртэл өчнөөн олон хүмүүсийг улс төрийн тийм сэдэлтэйгээр ингээд хэлмэгдүүлээд байгаа юм. Одоо эд нарыгаа яах гэж байгаа юм. Би ингээд харахаар зэрэг тэр Мөнгөнтуяа гэдэг охиныг 6 сар шоронд хорьчихоод чи бол гэм буруугүй юм байна. Чамд 42 сая төгрөг улсын төсвөөс гаргаад өгнө гээд нөхөн олговор гэдгийг нь тэгж өгч байгаа байхгүй юу. Тэр нэг Батхуяг гээд нэг хүү байсан. Тэр нүүрсний хэргийг би ярьж байгаа юм. Тэгэхээр тэрийг бас 3 сар хорьчихоод чамд улсын төсвөөс 7.5 сая төгрөг гаргаж өгнө. Одоо ийм замбараагүй байдлаар явах юм уу? Одоо энэ 1990 оноос хойших энэ улс төрийн шинжтэй гарч ирсэн энэ хэргүүдийг нэг анхаарч энэ хэлмэгдсэн хүмүүсийн асуудал чинь Их Хурлын дэд дарга дээр байгаа шүү дээ.

Энэ дээр нэг санал санаачилга гаргах арга юу байна? Та нарт бодож төлөвлөж байгаа юм байна уу? Тэр өнгөрсөн хугацааныхыг би Монголчуудад дахиад хэлье. Үнэхээр хар түүх шүү. 36 мянган иргэнээ бид нар алдсан. Алдсан юу

байх вэ дээ буудсан хорьж, шоронд хорьж тарчилгасан.

Л.Мөнхбаатар: Алтанхуяг гишүүний асуултад хууль санаачлагч Салдангийн Одонтуяа хариулъя.

Дараа нь тодруулж асууж болно.

С.Одонтуяа: Алтанхуяг гишүүн маш чухал асуулт хөндлөө. Тэгэхээр нэг 2 янзын асуудал байгаа.

Нэгдүгээрт энэ манай хууль энэ 1998 онд энэ Алтанхуяг гишүүн өөрөө гишүүн байсан юм байна лээ. Санаачлагчдын нэг. Энэ 1922-оос 1990 он хүртэл нөгөө БНМАУ-ын үед хэлмэгдсэн хүмүүсийг цагаатгах энэ хуулийг батлуулсан. Би бол бүх протокол энэ тэрийг бүгдийг нь л үзлээ л дээ 1998 оныг.

Тэгэхээр энд нэг ноцтой асуудал юу байсан бэ гэхээр бараг тухайн үед хүн амынхаа 10 хувьтай тэнцэх хүмүүсийг бол хэлмэгдүүлсэн байдаг. Бид нарт бол албан ёсоор цагаадсан нь 31653 байхгүй юу. Гэтэл тэнд араас нь энийг цагаатгалаа хөөцөлдөөгүй, эсвэл нас барчихсан, эсвэл бичиг баримт нь устсан эсвэл овгоо сольсон ч гэдэг юм уу ялангуяа лам нарын. Хүний тоо бол нэлээд их өндөр байдаг. Тэгэхээр хамгийн аюултай нь бусад орнуудад энэ хэлмэгдэл яваад энэ үед баривчилсан хүмүүсийнхээ 20 хувийг цаазаар авсан байхад манай улс баривчилсан хүмүүсийнхээ 75 хувийг буудан алах ялаар шийтгэсэн байдаг. Энэ асар том хүний эрхийн зөрчил байсан.

Хоёр дахь нэг чухал асуудал бол 1990 оноос хойшоогоо яах юм бэ гэж байна. Энэ маш чухал асуудал. Би бол ажлаа авснаас хойш яг энэ дээр гол судалгаа хийгээд ажиллалаа. 1990 оноос хойших гэдэг дээр бол ер нь энэ хэлмэгдүүлэлт 2 янз. Хувь хүний асуудал байдаг. Нэг нь төрийн буруутай үйл ажиллагаанаас нийтийг хамарсан энэ хэлмэгдүүлэлт энэ асуудлыг бол яах

аргагүй хууль зүйн зохицуулалт гаргаж шийдэх ёстой. Тэгэхийн тулд энэ би БНСУ-ын хуулийг судалсан. Солонгос бол ардчилсан улс хэрнээ 1980 онд маш том ийм хэлмэгдлийн хэрэг гарч байсан. Бүүр 48 оныхоо Чэжүгийн хэлмэгдлийн хэргийг хүртэл эд нар ингэж нарийн судалж байдаг. Тэгэхээр өнгөрсөн үеийг үнэн ба эвлэрэл болгон цагаатгах тухай гэж суурь хуулийг баталчхаад тэрэндээ үе үед нь таарсан тусгай хуулиуд баталдаг. Жишээлэхэд 1980 оны Кванжүгийн бослогод зориулсан хууль, 1948 оны Чэжүгийн бослогыг яасан хууль. Ардчиллын нөхөн төлбөрийн тухай хууль, Үл мэдэгдэх шалтгаанаар үхсэн хүмүүсийн гэрэл зургийг шалгах тухай хууль, Өнгөрсөн цэвэрлэгээний тухай хууль гээд ингээд тус тусад нь хууль гаргачихдаг. Тэгэхээр энийг бол бид нар ажиллаад энэ тунхгийг соёрхон батлах ёстой юм байна лээ. Энэ ямар кон тунхаг вэ гэхээр яг одоо энэ төрийн буруутай үйл ажиллагааны улмаас хохирсон иргэдийн хохирлыг хэрхэн нөхөн төлбөр болгох юм бэ гэдэг ийм олон улсын ийм тунхаг байгаа юм.

Л.Мөнхбаатар: Одонтүяа дарга гүйцээгээд хариулчихъя.

С.Одонтүяа: Тэгэхээр энэ тунхгийг Улсын Их Хурал соёрхон батлах ёстой манай улс. Тэгэхээр энэ соёрхон батлахын тулд энэ саяын таны хэлдэг асуудал дээр ямар бусад орнууд яаж зохицуулдаг юм бэ энэ хохирлыг нь хэрхэн барагдуулдаг юм бэ гэдгийг тусгасан. Ийм судалгааг сая би Парламентын судалгааны хүрээлэнгээс хийлгээд өнөөдөр авсан. Тэгэхээр шууд энэ соёрхон батлах ажил руугаа орох гэж байна. Соёрхон батлаад бид суурь хуулийг батлаад бусад энэ орнуудын жишгээр энийг хийнэ. Манай Эрүүгийн хуульд төрийн эсрэг иргэн хүн гэмт хэрэг хийвэл ямар хуулийн зохицуулалт ямар ял шийтгэл гэдгийг хэдэн 100 мянгаар бичсэн хэрнээ төр иргэнийхээ эсрэг гэмт хэрэг

хийвэл ямар хариуцлага хүлээх юм бэ гэдэг заалт байдаггүй.

Тийм учраас энэ дээр л бид нар яг ажиллаж байна. Тийм учраас энэ зүйлийг зайлшгүй хийх ёстой. Тэгээд 1990 оноос хойш гэхээр 7 дугаар сарын 1-ний асуудал яах аргагүй анхаарал татдаг. Тэгэхээр 7 дугаар сарын 1-нд зориулсан тусгай хууль гэдгийг бид нар бас баталж болох ийм боломжтой байгаа. Тэгэхээр энэ дээр эрдэмтэн судлаачидтай ажиллаж байна. Хэлэлцүүлгүүдийг хийж байна ийм зүйл байна.

Л.Мөнхбаатар: Алтанхуяг гишүүн тодруулах уу? Тодруулж асууя Алтанхуяг гишүүнд нэмэлт минут өгье.

Н.Алтанхуяг: Ингээд 36 мянган хүнийг хэлмэгдүүлж байна гэдэг үнэхээр энэ геноцит юм шүү дээ. Тэгээд би яах вэ энэ 1990 оноос хойших дээр нь бас анхаарал хандуулаач л гэж хэлж байна л даа. Одоо би хамгийн шинэ түүх ярья. Одонтүяа гишүүн анхаарч байгаарай. Сая Хөгжлийн банкн дээр 80 хүнийг багцалж оруулаад шүүх хурал боллоо. Анхан шатан дээр нь 48 хүн цагаадсан байхгүй юу. Тэгээд дахиад давж заалдах шатын шүүх хурал болоод 27 хүн цагаадаж байна шүү дээ. Тэгэхээр чинь энэ цагаадаж байна гэдэг чинь энэ хүмүүс гэм буруугүй гэсэн үг байхгүй юу. Тэр энэ хүмүүсийг хэн гэм буруутай гээд ийм юм болгочхож байгаа юм. Тэгэхээр төр гэдэг их том үг болчихоод байгаа юм. Тэгэхээр ер нь миний харагдаж байгаагаар бол хэн нэгэн хүнийг хэлмэгдүүлээд хэлмэгдүүлсэн нь цагаадаж байгаагаар нотлогдож байгаа тохиолдолд хариуцлагыг хэн хүлээх юм бэ? Би зүгээр нэг Эрүүгийн хууль янз бүрийн хууль руу бас орж магадгүй.

Л.Мөнхбаатар: Тодруулгад хариулъя. Одонтүяа дарга.

С.Одонтүяа: Тэгэхээр одоо таны 1998 онд баталсан хууль дээр нь хэд хэдэн удаагийн өөрчлөлт оруулсан. Энэ хууль

маань 1922-оос 1990 он хүртэлхийг л хуульчилсан зохицуулсан нөхөх олговор олгох тухай хууль байгаа. Тэгэхээр манай комиссын үйл ажиллагаа бол яг энэ хуулийн дагуу эдгээр хүмүүсийг тогтоох, шүүхийн шийдвэр гаргах, шүүхийн шийдвэр гаргасны дагуу нөхөх олговор олгох гэсэн ийм зүйл хийж байгаа. Энэ бол өмнөх дарга нар нэлээн энэ тал дээр ажиллачихсан учраас би бол бас энэ соён гэгээрүүлэх дахиж энэ асуудал гаргахгүй байх тал дээр хэд хэдэн баримтат кино ингээд л олон зүйлүүдийг хийж байна. Одоо бид нарын нэг хамгийн том хийх ажил бол саяын таны хэлдэг 1990 он оноос хойш гараад байгаа энэ хүний эрхийн зөрчлийг яах юм бэ гэмт хэргийн хохирогч болсон иргэдийн эрхийг нь яаж хангах юм бэ? Нөхөх төлбөрийг нь яаж олгох юм бэ гэдэг дээр ямар ч зохицуулалт байхгүй байгаа. Хувь хүмүүс бол хөөрхий ингээд Хүний эрхийн Комиссоор явдаг, Дээд шүүхэд гомдол гаргадаг. Одоо бас сая энэ ҮХЦ-ийн хууль, шинэ хуулиар бас иргэд хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой зүйлээр хандаж болдог ийм зүйлүүд гарч байгаа юм.

Тэгэхээр яг өнөөдөр манай цагаатгалын комисс бол энэ хувь хүмүүсийн асуудлыг бол хариуцахгүй байгаа юм. Тэгэхээр би бол хариуцахгүй гээд орхихгүйгээр саяын таны хэлдэг энэ судалгаануудыг хийлгэчихлээ. Одоо бид нар энэ конвенц тунхгаа баталчихна. Тэгээд энэ чиглэлийн энэ бүх хуулиудыг баталсан тохио болдолд энэ зохицуулах хууль эрх зүйн орчин үүсэх юм.

Өнөөдөр Монгол Улсад байгаа нь хувь хүний асуудлыг бусад хуулиар зохицуулдаг.

Л.Мөнхбаатар: Одонтуяа дарга гүйцээгээд хариулчихъя.

С.Одонтуяа: Төрийн буруутай шийдвэрийн улмаас нийтийг хамарсан ийм асуудлыг бид нар яг энэ хэлмэгдүүлэлт гэдэг нэр томъёондоо

оруулаад байгаа юм. Тэгэхээр энийг зохицуулах хууль хууль эрх зүйн орчноо бүрдүүлэх гэж байна л гэсэн үг. Тэгэхээр Хөгжлийн банкны асуудлыг хувь хүмүүсийн асуудал гэж үзээд л одоогоор ингээд шийдээд яваад байна шүү дээ. Тэгэхээр Хөгжлийн банкны асуудлыг жишээлэхэд их олон хүн хохирлоо гэдэг ч юм уу. 7 дугаар сарын 1-ний асуудалд олон залуус хохирсон. Гомдол гаргах ямар ч боломж олгоогүй гээд одоо хүртэл тэр залуус гомдолтой байдаг. Тэгэхээр эдгээр зүйлийг авч хэлэлцэхийн тулд бид нар энэ хууль эрх зүйн энэ шинэчилсэн орчныг л бүрдүүлэх гээд үзээд байгаа юм.

Л.Мөнхбаатар: Улсын Их Хурлын гишүүн Наянтайн Ганибал асуултаа асууя. Ганибал гишүүний микрофоныг өгөөрэй.

Н.Ганибал: Өнөөдөр маш чухал асуудлыг ярьж байна л даа. Энэ хар бараан түүх Монголын энэ түүхэнд хамгийн тодоор бичигдсэн бид бүхний бараан өдрүүдийн түүх байдаг. Үүний ар дээрх нөхөн олговор цаана нь тухайн гэр бүлийн ар гэрийнхний авсан тэр их шарх, тэр сэтгэлийн гүн шархуудыг бол ер нь мөнгөөр нөхөн төлөөд бас бүгдийг эдгээнэ гэж бас байхгүй. Гэхдээ төр бас энийгээ анхаарч цаашилаад энэ хар бараан түүхүүдээ давтахгүй байх гэсэн энэ л шийдвэр нь тухайн хуулиар илэрсэн гэж ойлгодог. Тухайн үед засаг барьж байсан АН-ын дарга Ерөнхий сайд байсан хүн бас уучлал гуйж байсан. Ийм дүр зураг бэлхнээ нүднээ харагдаж байна л даа.

Харамсалтай нь цаг хугацааны хувьд эргээд Монголын төр энэ хараан хар бараан өдрүүдээ давтаагүй юу, давтсан уу гэдэг асуудал бас бидний өмнө гарч ирж байна. Сая Алтанхуяг гишүүн маш тодорхой кэйсүүдийг ярьж байна. Ер нь сүүлийн цаг хугацаанд яг бодит үнэнийг хэлсний төлөө дуугарсны төлөө хэвлэлийн сэтгүүлч нар баригддаг ямар нэгэн хэрэг тэр хүмүүс дээр тохдог. Үнэн үгийг хэлснийхээ төлөө фэйсбүүкт олны өмнө

үгээ хэлснийхээ төлөө бас баригддаг, хоригддог, буцаагаад цагааддаг. Улс төрийн хүрээн доторх бүүр бодит жишээнүүд байна л даа. Их Хуралд нэр дэвшиж байгаа нэгнийгээ өрсөлдөгчөө яг сонгуулийнх нь цаг хугацаанд бариад хорьчихдог. Тэгээд сонгууль дууссаны дараа гаргаад ирдэг бас цагаадсан байдаг. Бидний анги дотор тохой залгаад сууж байгаа хүмүүс ч гэсэн өнөөдөр яг сонгуулийн цаг хугацаанд хэрэг тохогдоод 461 рүү ачигдаад сонгууль дууссаны дараа бас тангаргаа өргөсөн хүмүүс ч байгаа.

Тэгээд энэ болгон өнөөдөр Монгол төрд яг хэлмэгдүүлэлт улс төрийн хэлмэгдүүлэлт бидний өмнө байгаад байна гэдгийг тодорхойлоод байгаа юм. Цаашилаад хэрвээ цайзын ялтай байсан бол аягүй бол бид нар чинь бие биеийгээ бараг буудаад алчих ийм хэмжээнд хүртэл сэтгэхүй нь буруу тийшээ яваад байгаа юм уу даа гэсэн ойлголт сүүлийн үед их төрдөг болсон. Үнэн хэлсэн шүүмжилж чадсан энэ өнөөдрийн ардчиллын хамгийн том ололт маань өөрөө энэ хэлмэгдүүлэлтээр эргээд үгүй хийгдэж байгаа ийм нөхцөл байдал харагдаж байгаа юм.

Тэгэхээр өнөөдрийн энэ хуулийн төслийн хамгийн чухал асуудал нь өнөөдрийн бодит амьдрал дээр болж байгаа энэ процесс дээр бид нар ер нь яаж хандах ёстой юм бэ? Одноо гишүүн ээ Их Хурлын дэд даргаас асууя. Тэгээд энэ дээр тодорхой хуулийн ямар заалтууд орж ирэх юм? Өнөөдрийн бид нар магадгүй олон хэлмэгдүүлэлт нүдэн дээр болж байгаа. Түүний ар дээр бас мэдээж тухайн айлын үр хүүхдүүд гэр бүлийнхэн хэдэн сараар, хоногоор, жилээр, бас энэ сэтгэлийн шархыг өөрсөд дээрээ мэдрээд явж байгаа ийм цаг хугацаа бас нүдэн дээр харагдаж байна аа.

Тэгэхээр аливаа хууль аливаа гаргаж байгаа төрийн шийдвэр болгон түүхээ давтахгүй байхын төлөө гаргадаг гэж би боддог. Энийг эргээд гарч байгаа

бол энийг яаж эргээж зөв болгож сайжруулж энэ хэлмэгдүүлэлт гэдэг асуудлыг яаж багасгах вэ гэдэг дээр бас ямар шийдвэрүүд гарах вэ гэж асууя.

Л.Мөнхбаатар: Ганибал гишүүний асуултад хариулъя. Хууль санаачлагч Салдангийн Одонтуяа хариулъя.

С.Одонтуяа: Ганибал гишүүн маш чухал асуудлыг хөндлөө. Тэгэхээр энэ хэлмэгдүүлэлт гэдэг бол би түрүүн хэлсэн. Хэчнээн ч цаг хугацаа өнгөрсөн энийг зайлшгүй үнэн мөнийг тогтоох ёстой 1 дүгээрт.

Хоёрдугаарт энэ дээр маш хариуцлагатай, анхааралтай хандаж, эдгээр хүмүүсийг заавал цагаатгах үнэхээр буруугүй байсан энэ хүмүүсийг цагаатгах ийм ажлыг хийх ёстой. Энэ бол 10 жил, 20 жил, 100 жил өнгөрсөн ч гэсэн л дуусахгүй байна. Тэгэхээр би түрүүн хэлсэн. 1998 онд энэ асуудлыг авч хэлэлцэхэд өнөөдөр 30 жил бид нар энэ асуудлыг хийгээд хийгээд ердөө 31 мянган хүнээ л цагаатгаж чадаж байгаа.

Тэгэхээр 1 ийм асуудал эхэлсэн бол өөрөө маш хүндрэлтэй. Энэ хүмүүсийг дараа нь хэчнээн нөхөх олговор олгоод олгоод ч энэ шархыг нөхөж чаддаггүй. Тэгэхээр би энэ бусад орнуудад ямар байна гээд бүгдийг нь ингээд судалсан. Ялангуяа ардчилал ардчилсан дэглэмтэй ийм улс орнуудын хуулийг л голчлон судалж байна л даа. Тэгэхээр жишээлэхэд Солонгост бол тэр 1948 оны 4 дүгээр сарын 3-нд гарсан Чэжүгийн тэр бослогын дараа 52 жилийн дараа тусгай хууль Солонгосууд гаргасан. Одоо хүртэл энийгээ уучлалт гуйгаад л, энэнийхээ араас хөөцөлдөөд. 1980 онд Солонгост бас 5 дугаар сарын 17-нд Кванжугийн бослого гэж хүчээр цус урсгаж байсан ийм бослого болсон. Энийг бас Кванжу 5 дугаар сарын 18 гээд 10 жилийн дараа энд нөхөх олговрын тухай ардчиллын ийм хууль гарсан байгаа юм.

Тэгэхээр би түрүүн хэлсэн хэд хэдэн энэ конвенцыг тунхгийг Улсын Их Хурлаар бид нар соёрхон баталъя энэ бусад орнуудын жишигийг харъя гэж байгаа юм. Яагаад бусад орнуудын жишигийг харъя гэж байгаа вэ гэхлээр бид нар аль болохоор алдаа бага гаргах ёстой. Хүний эрхийн асуудал учраас. Тэгэхгүй бол одоо яагаад энэ хэлмэгдлийн үед ийм олон хүнийг цаазаар ингэж нэг дор авсан юм бэ гэхээр дандаа хуулийг монголчилсон байдаг байхгүй юу.

Шууд 3 хүний онцгой комисс гаргаад л ерөөсөө өдөрт хэдэн мянгаар нь ингээд л шүүх хурал явуулаад байсан. Тэгэхээр бид нар бол одоо дандаа энэ олон улсын эрх зүйн хэм хэмжээ, олон улсын хүний эрх энэ асуудлын хүрээнд юмаа шийдвэл алдаа их бага болох юм байна лээ. Тэгээд одоо бид энэ судалгаа хийгдсэн эрдэмтэн судлаачид бид нар ажиллаж байна. Одоо энэ Улсын Их Хурлаар энэ тунхгийг соёрхон батална. Тэгээд энэнтэй холбоотой хэт маш олон хуулиудыг батлах ёстой. Сая би ҮХЦ-ийн хууль хэлэлцэж байхад хэлсэн. Энэ бол хөөн хэлэлцэх хугацаа гэж байх ёсгүй шүү. Энэ нийгмийг хамарсан ийм асуудал дээр хөөн хэлэлцэх хугацаа гэж байх ёсгүй шүү гэдгийг хэлсэн байгаа. Тэгээд одоо хүртэл над дээр 7 дугаар сарын 1.

Л.Мөнхбаатар: Энэ бас чухал хуулийн төсөл санаачилж орж ирсэн байна. Орон нутгийн иргэдээс ч гэсэн олонтоо манай гишүүдэд хүсэлтүүд ирдэг. Түүнийг Одонтуяа даргад л ингээд шилжүүлээд байгаа. Цагаатгуулах гомдол гаргах хугацаа бол 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр ингээд тасалбарлаад дуусчихсан. Энэнээс хойш 200 гаруй өргөдөл ирсэн байна гэж байна. Дээр нь 637 өргөдлийг шалгаж шийдвэрлэх шаардлагатай байна гэсэн ийм тооцооллыг гаргасан байгаа юм байна. Тэгэхээр сая гишүүд нэлээн ярьж байна л даа. Аубакир гишүүн, Алтанхуяг гишүүн Ганибал гишүүн ярьж байна. Энэ

угаасаа энэ хэлбэр төстэй зүйлээр ер нь тодорхой гэмт хэрэг дээр бас хөөн хэлэлцэх хугацаа тооцдоггүй ийм хэргүүд байдаг. Түүнтэй адилхан энэ хэлмэгдэгсдийн энэ асуудал дээр бол ялгаагүй энэ хөөн хэлэлцэх хугацаа тооцохгүйтэй адилхан ерөөсөө энэ байдлаар ийм хугацаа тогтоохгүй байх нь бас зүйтэй юм байна гэж үзэж ихэнх гишүүд бас саналуудаа хэлж байна.

Хууль санаачлагчийн хувьд ч гэсэн үүнийг хүлээн зөвшөөрч байна гэж ойлголоо тэ Одонтуяа дарга.

Тэгэхээр хэлэлцэх эсэхийг шийдсэний дараа бол хэлэлцүүлгийн явцад хууль санаачлагчтайгаа ойлголцоод эдгээр хуулиудаа ингээд цааши нь үргэлжлүүлэн хэлэлцээд явах боломжууд нь байна гэж бодож байна. Тэгэхээр хэрвээ ингээд явах юм бол нь Тагнуулын ерөнхий газар дээр бас энэ хэлмэгдэгсдийн асуудал хариуцсан нэгж ажилладаг. Энэнд бас хяналт тавьдаг бас тусгайлсан прокурорууд бас хяналт тавьдаг. Цаашидаа тагнуулын болон мөрдөх алба нь ердийн журмаар энэ асуудлуудыг мөрдөөд прокурор бас хяналтаа тавиад ингээд явах боломж байна гэж харж байна.

Ингээд гишүүд асуулт асууж хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Байхгүй байна.

Байнгын хорооны саналаар санал хураалтыг явуулах дэгтэй. Гэхдээ энэ санал хураалтыг ирэх 7 хоногийн буюу 4 дүгээр сарын 11-ний өдрийн 10 цагаас санал хураалтыг явуулъя. Ингэхдээ Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 14.12-т заасныг баримтлан санал хураалтыг хойшлуулж байна. Гишүүдэд баярлалаа.

Баталсан тогтоолын эцсийн найруулгыг сонсгоё.

“Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай” Улсын Их Хурлын

тогтоолын эцсийн найруулга дээр саналтай гишүүн байна уу? Байхгүй байна. Эцсийн найруулгыг сонссонд тооцлоо.

Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул чуулганы нэгдсэн хуралдааныг өндөрлөснийг мэдэгдье.

19.23 цагт

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ П.МЯДАГМАА